


ECONOMIC ANALYTICA

УЛС ТӨРИЙН ЭДИЙН ЗАСАГ СУДЛАЛ



**ТӨСӨВ,
ТӨСВИЙН БОДЛОГО
ГЭЖ ЮУ ВЭ?**

ECONOMIC ANALYTICA

УЛС ТӨРИЙН ЭДИЙН ЗАСАГ СУДЛАЛ

**ТӨСӨВ, ТӨСВИЙН
БОДЛОГО**

РЕДАКЦЫН БОДЛОГО

- Монгол Улсын өмнө тулгамдаад буй эдийн засгийн асуудлуудад дүн шинжилгээ хийж, судалгааны ажлуудыг хүргэх замаар нийгэм, олон нийтэд эдийн засгийн шинжлэх ухаан, боловсролыг түгээн дэлгэрүүлнэ.
- Эдийн засгийн шинжлэх ухааны салбарын эрдэмтэн, судлаачдыг дэмжих, тэр дундаа залуу эдийн засагч, эдийн засаг судлаачдыг дэмжиж ажиллана.
- Эдийн засагч, судлаачид, эрдэмтэн багш нарын судалгаан, шинжилгээний ажлыг шийдвэр гаргагчид болон бодит эдийн засагт оролцогчдод хүргэх үндсэн платформ болно.

РЕДАКЦЫН БҮРЭЛДЭХҮҮН

- Ерөнхий эрхлэгч:** А.Анар /“Амаржаргал Сан” ТББ-ийн Гүйцэтгэх захирал/
Гүйцэтгэх эрхлэгч: Б.Эрдэнэбулган /“Амаржаргал Сан” ТББ-ийн Улс төрийн шинжээч/
Редакцын зөвлөл: Р.Амаржаргал /Монгол Улсын 21 дэхь Ерөнхий сайд/
Д.Батжаргал /СЭЗИС-ийн Захирал/
Ж.Батхуяг /СЭЗИС-ийн УЗ-ын гишүүн/
Ч.Хүрэлбаатар /УИХ-ын гишүүн, Сангийн сайд/
Н.Баяртсайхан /Монголбанкны Ерөнхийлөгч/
Б.Нямаа /Сангийн Яамны Төрийн нарийн бичиг/
Даниел Шмюкинг /Конрад-Аденауэр-Сангийн Суурин төлөөлөгч/
Б.Сүхбат /Конрад-Аденауэр-Сангийн Төслийн зохицуулагч/
С.Түвшинзаяа /СЭЗИС-ийн Докторын хөтөлбөрийн эрхлэгч/
Б.Бүжинлхам /СЭЗИС-ийн Магистрын хөтөлбөрийн эрхлэгч/
Дизайнер: Д.Тулга

Дугаарыг
эрхлэн гаргасан

Дугаарыг
санхүүжүүлсэн

Хамтран ажилласан



“Амаржаргал Сан” ТББ



Конрад-Аденауэр-Сан

Глобал Эдийн Засгийн
Судалгааны Хүрээлэн

Нээлттэй Нийгэм
Форум

АГУУЛГА

ГОЛ ЯРИЛЦЛАГА

Төсөв гэж юу вэ?

Р.Амаржаргал, Монгол Улсын 21 дэх Ерөнхий сайд

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ӨГҮҮЛЭЛ

Төсөв, мөнгөний бодлого

Ц.Батсүх

2018 оны Төсөв ба хөдөө аж ахуйн тулгамдсан асуудлууд

Ч.Наранчимэг

2018 оны Төсөв ба боловсрол, шинжлэх ухааны салбарын тулгамдсан асуудлууд

Д.Гэрэлмаа

Монгол Улсын төсөв ба дэд бүтэц, хөрөнгө оруулалтын тулгамдсан асуудлууд

Ж.Дэлгэрсайхан

Улсын төсөвт гадаад өрийн үзүүлэх дарамт

Д.Мөнхцэцэг

2018 оны Төсөв ба нийгмийн бодлогын тулгамдсан асуудлууд

П.Гантөмөр

ЭДИЙН ЗАСГИЙН ӨГҮҮЛЭЛ

Дотоодын нийт бүтээгдэхүүний 80 хувьтай тэнцэх өртэй төсөв

С.Батзаяа

БАЙР СУУРЬ

Төсвийн алдагдлыг бууруулах нь өр бууруулах үндсэн үзүүлэлт

УИХ-ын гишүүн, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар

Хоёр жилийн дараагаас төсөв ачааллаа даахгүйд хүрнэ

УИХ-ын гишүүн Д.Тогтохсүрэн

Төсвийн реформ хийх цаг болсон

УИХ-ын гишүүн Б.Баттөмөр

КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН БУЛАН

Монголд компанийн нийгмийн хариуцлага ба тогтвортой хөгжлийн зорилгууд судалгааны товчлол

Монголын Компанийн Засаглалын Хөгжлийн Төв (CGDC)

ТӨСӨВ ГЭЖ ЮУ ВЭ?

Р.АМАРЖАРГАЛ

Монгол Улсын 21 дэх Ерөнхий сайд

2012 онд төсөв, төсвийн бодлого гэж юу вэ, улсын төсөв хэрхэн бүрдэж, Засгийн газар хэрхэн боловсруулж, УИХ-аар батлуулдаг вэ, улсын төсвөөс тухайн улсын ерөнхий эдийн засгийн чиг хандлага, улс төрийн нөхцөл байдлыг хэрхэн тодорхойлж болох вэ зэрэг асуултаудад иргэд, олон нийтэд ойлгомжтойгоор хялбаршуулсан хэлбэрээр хүргэж байсан ярилцлагаа Та бүхэнд шинэчлэн хүргэж байна.

ЖИЛ БҮРИЙН АРАВ, АРВАННЭГДҮГЭЭР САР ТӨСВИЙН “ХЭРҮҮЛ” БОЛЖ БАЙДАГ ҮЕ. ТӨСӨВ ГЭДЭГ ЭДИЙН ЗАСАГ УЛС ОРОН, ТӨРИЙН БОДЛОГОД ЯМАР НӨЛӨӨТЭЙ ВЭ ГЭХ ЭНГИЙН ХЭРНЭЭ ОЛОН НИЙТ ТӨДИЙЛЭН МЭДДЭГҮЙ АСУУЛТААР ЯРИАГАА ЭХЛЭХ ҮҮ?

Би 2-3 зүйлийг л онцолж хэлье. Нэгдүгээрт, төсвийг чи уншиж чадах ёстой. Энэ бол тухайн улс орны санхүүгийн жилийн төлөвлөгөө юм. Үүнийг уншиж чадна гэдэг эдийн засагч болж байгаагийн нэг шинж. Төсөв бол тухайн улс орны хөгжлийн хүрсэн түвшинг илэрхийлдэг. Ийм түвшинд байна шүү гэдгийг нь илэрхийлж байгаа юм. Хоёрдугаарт, энэ улс орон ямар зорилт дэвшүүлээд байна, ирээдүйн чиг хандлага нь хаашаа вэ гэдгийг илэрхийлдэг баримт бичиг. УИХ энэ хоёр өнцгөөс нь харж төсөв батлах учиртай. Төсөв дотор зээл тусламж нэлээд их хувийг эзэлж байвал энэ улс эдийн засгийн хувьд тааруу, гаднаас хараат, чухам хэнийд хараат вэ гэдэг нь хүртэл харагдана. Зээл

тусламжийг орхиод дотоод орлогыг аваад үзье л дээ. Татварыг задлаад үзэхээр хүн амын орлогын татвар, аж ахуйн нэгж, байгууллагынх гэж байгаа. Энэ хоёр тоог задлаад ерөнхий динамикийг нь харахаар эднийх бизнесийн орчин хэр байна вэ, ард иргэддээ үйлдвэрлэл, үйлчилгээ явуулахад хэр өгөөжтэй юм бэ гэдэг нь харагддаг. Товчхондоо, ард иргэдийнхээ нуруун дээр болоод төр засаг нь өөрөө хэдий хэмжээний ачаа үүрч явдаг нь төвөггүй уншигдана. Цаашлаад НӨАТ, Гаалийн албан татвар гэж байгаа. Энэ нь улсын төсвийн бүрдүүлэлтийн хэдэн хувийг эзэлж байна. Ерөнхийдөө гаалийн албан татвар, НӨАТ-ын эзэлж байгаа хувийн жин, бусдаасаа хэдий их байна, төдий чинээ сул засаг байна гэсэн үг. Ардчилал бүрэн хэмжээгээр төлөвшөөгүй, ард иргэдийнх нь эдийн засгийн соёл, боловсрол, сахилга бат нь сул байгаа нь харагддаг. Гаалийн татварыг хил дээр хүч хэрэглэж байгаад цуглуулдаг. Төр хүчээр үүнийг цуглуулж авч байна гэсэн үг. Ард иргэд нь өөрсдөө очоод өгдөг татвар бол хүн амын орлогын албан татвар, аж ахуйн нэгж байгууллагуудын татвар. Үүнээс төр

хэр хүчтэй, аль хэр сул вэ гэдгийг мэдэж болно. Товчхондоо, төсөв гэдэг өнөөгийн түвшин, ирээдүйн зорилтыг илэрхийлж байгаа баримт бичиг боловч том зургаар нь харвал тухайн улс оронд байгаа бүх зүйлийн зангилааг харж болох юм.

ОРЛОГО ТАЛААС НЬ АВЧ ҮЗЭХЭД ӨНӨӨДРИЙН БАЙДАЛ ХАРАГДАНА ГЭЖ ОЙЛГОЛОО. ТЭГВЭЛ ЗАРЛАГЫГ ЮУНД ИХ ЗАРЖ БАЙНА ВЭ. ЭНЭ НЬ ХЭР ЗӨВ МЕНЕЖМЭНТЭЭР ЯВЖ ИРСЭН БОЛ?

Хөгжлийн бодлогыг зарлагаас нь харна. Өнөөдөр нийгмийн хамгаалын асуудал ямар түвшинд байдаг вэ. Ахмадуудад, эмэгтэйчүүд, хүүхэд багачууддаа зарцуулж байгаа мөнгийг харах ёстой. Дараа нь бүтээн байгуулалтын чанартай хөрөнгө оруулалтын асуудал байна. Өнөөдрийн манай баталж байгаа төсөвт айтгар гялайх зүйл байхгүй. Хэдэн сургууль, эмнэлэг шинээр барих, засах зүйлүүд л бий. Бүтээн байгуулалтын том зүйлүүд хэлэлцээд байгаа нь маш бага. Өндөр хүчдэлийн шугам, аймаг, сумдууд руу тавьж байгаа. Монгол Улсын хөгжил маань өнөөдөр ердөө энэ түвшинд л байна. Ер нь цаашид ирээдүйгээ харсан хөгжлийн үсрэлтийн шинэ зүйлүүд өнөөдрийн түвшинд харагдахгүй байгаа. Гэхдээ төсвийг нь хараад уншиж болно. Ер нь цаашдаа юун дээр хөрөнгө мөнгөө төвлөрүүлэх гэж байгааг нь мэдэж болно. Дотоод улс төрийн зөрчил яаж илэрч байгааг улсын төсвийн зарлага талаас нь харж болно. Аль яам руу хэдийг өгч, төсвийг захиран зарцуулах эрхийг нь нэмж байна вэ. Аль бүлэглэл нь илүү яваад байна, аль нь одоо багассаныг хүртэл төсвийн зарлагаас хардаг. Ингэхдээ он оныг нь хараад тав, арван жилийн динамикаар нь харвал аандаа ойлгогдоно. Хуримтлалын асуудал бас их чухал. Чи хөрөнгө оруулалт хийх гэж байвал

хуримтлал байх ёстой. Хуримтлалын түвшин хэд вэ гэдгийг хөрөнгө оруулалтын түвшин харуулна. Одоо Монгол Улсад тухайн жилдээ 100 төгрөгийн хөрөнгө оруулалт хийх гэж байвал хэдийг нь бид өөрсдөө гаргаж байна вэ. Монгол Улсын гадаад бодлого, эдийн засгийн харилцаа, экспорт, импортын түвшин нь ямар байгаа нь бас л төсөв дотроо харагдана.

УЛСЫН ТӨСӨВ ЖИЛ ИРЭХ ТУСАМ ӨСЧ БАЙНА. ҮҮНИЙГ ДАГААД ЭЭРЭГ ӨӨРЧЛӨЛГҮҮД ГАРЧ БАЙГАА ШҮҮ ДЭЭ?

Тооны хувьд өссөн ч цаана нь чухам юу болоод байгааг мэдэхийн тулд харьцуулсан үзүүлэлтийг авч үзэх ёстой. Нөгөө л уул уурхай. Улсын төсөв 30 тэрбум байхад "Эрдэнэт" үйлдвэрээс хэдэн төгрөг оруулж ирээд, түүгээрээ хөрөнгө оруулалт хийгээд явдаг байсан бол өнөөдөр бас л энэ байдал арилагүй байна. Дээрээс нь сүүлийн үед яригдаад байгаа ганц хоёр уурхай байгаа түүнээс л мөнгө нь орж ирж байх. Түүнээс өөр санхүүгийн эх үүсвэр гаргаж чадаагүй байна. Уул уурхайгаас хараат байдал нь улам нэмэгдсэн байх жишээтэй. Зээл, тусламжийн хэмжээ абсолют дүнгээрээ буураагүй, үнэмлэхүй дүнгээр харьцангуй нэг түвшинд яваад байна гэж бид ойлгож байгаа. Гэхдээ эерэг тал нь юу вэ. Манайх төдөн төгрөгийн валютын нөөцтэй байх ёстой гэж ярьдаг байсан бол өнөөдөр хангалттай валютын нөөцтэй болчихсон. Монгол Улсын экспортын хэмжээ гадаадын өрийнхөө үйлчилгээг чөлөөтэй хангахуйц хэмжээнд хүрсэн байх жишээтэй. Энэ утгаараа ахиц байна. Энэ юуг харуулаад байна гэхээр Монгол Улс гадаад эдийн засгийн хамтын ажиллагаагаа өргөжүүлж, эдийн засгийн интеграцид идэвхтэй оролцож байна гэсэн үг. Хоёр хөрштэй интеграцчилах процесс явагдаж байгаа юм байна.

Бүс нутгийн эдийн засгийн интеграци, дэлхийн эдийн засгийн хөдөлмөрийн хуваарьт идэвхтэй оролцоод ирж байгаа юм байна. Өөрийн дуу хоолойтой болж байна гэдгийг харуулах бас нэг үзүүлэлт.

ТӨР АЛБАН ХҮЧЭЭР ТАТВАР ЦУГЛУУДАГ ТУХАЙ ТА ТҮРҮҮНД ЯРИАНДАА ДУРДААД ӨНГӨРЛӨӨ. ЭНЭ ТУХАЙ ТОДРУУЛЖ АСУУМААР БАЙНА?

Өндөр хөгжилтэй улс орны төсвийнх нь бүтцийг Монголтой харьцуулахад өдөр шөнө шиг ялгаатай. Жишээ нь, АНУ гэхэд үндсэндээ орлогын эх үүсвэр нь хүн амын орлогын татвар байдаг. Түүгээрээ л явж байдаг. Хүн ам нь орлоготой, үүнийг дагаад амьдрал ахуй нь дундаж чинээлэг давхаргыг бүрдүүлж байна. Скандинавын орнуудад хүн амын орлогын албан татвар харьцангуй өндөр, төсөв дотроо эзэлж байгаа хувийн жин ч өндөр байдаг. Харин манайд хүн амын орлогын татвар төлдөг хүн маш ховор. Төрийн байгууллагад болон томоохон аж ахуйн нэгжид ажиллаж байгаа хүмүүсийн цалингаас 10 хувийн татвар авч байгаа юм. Ихэнх хүмүүс тэр татварт хамрагдахгүй байгаа. Манай зарим улс төрчид хүн амын орлогын албан татварын эзэлж байгаа хувийн жин улсын төсөв дотор дэндүү бага, үүнийг больчихвол яадаг юм гэдэг. Ийм байж болохгүй. Алсдаа хамгийн гол зүйл хүн амын орлогын татвар болно. Үүнийг монголчууд төлж сурах ёстой. Хүн амын орлогын татвар төлчихөөд түүн дотроосоо хасуулдаг зүйл байх ёстой. Тухайлбал, чи хүүхдийнхээ боловсролд мөнгө зарж байгаа бол хүн амын орлогын татвараас хасагдаад явж байдаг. Цаашлаад чи хувьдаа орон сууц, байшин худалдаж авахад хүн амын орлогын татвараас хасагдаад явж байдаг болох жишээтэй. Эдгээрийг татварын бодлогоороо дамжуулаад хийгээд өгөхөөр төсвийн бүтэц эрүүл саруул, ерөнхий эдийн засаг зөв хэлбэр рүү очно. Хүн

амын хэдэн хувь нь чинээлэг, дундаж, хэдэн хувь нь хамгийн эмзэг давхаргад хамрагдаж байна вэ. Бид аль болох дундаж давхарга руу чиглэсэн бодлого явуулах ёстой.

ТА БУСАД ХӨГЖИНГҮЙ ОРНУУДЫН ТӨСВИЙГ ӨӨРИЙНХӨӨ УЛСТАЙ ХАРЬЦУУЛЖ УНШИХАД ТЭНГЭР ГАЗАР ШИГ ЗӨРҮҮТЭЙ ГЭЛЭЭ. ТУХАЙЛБАЛ, СКАНДИНАВЫН ОРНУУД, АНУ-ЫН ТӨСВИЙГ БОДОХОД НЭГ ҮЗҮҮЛЭЛТЭЭР ИЛҮҮ ГЭЖ БАЙНА. ЕР НЬ ТӨСӨВ ДЭЭР ТАТВАР ТӨЛӨГЧДИЙН ЯЛГАА ЯАЖ ХАРАГДАДАГ ЮМ БЭ. НӨГӨӨ Л ЧИНЭЭЛЭГ ДУНДАЖ ДАВХАРГЫГ ЯАЖ БҮРДҮҮЛЭХ ВЭ ГЭДЭГ ЗОРИЛГООР ЭНЭ АСУУЛТЫГ АСУУЖ БАЙГАА ЮМ?

Олон зүйл байгаа. Бид төсвийн орлого, зарлагыг гүнзгий задлаад үзвэл их олон юм харагддаг гэдгийг харлаа. Төсөв татвар төлөгчдийн мөнгөөр бүрддэг зүйл. Татвар төлөгчдийн мөнгөөр бүрдэж байгаа энэ чухал зүйлийг Дорж, Дондог, Дулмаа дураараа зарцуулж болохгүй. Тийм учраас улсын төсвийг баталж, хуульчлах шаардлагатай болдог. Нэгэнт батлагдаад гарсан хуулийг орон даяар үг дуугүй мөрдөх учиртай. Тэр хуулийн биелэлтийг хангах үүрэг нь гүйцэтгэх засаглал буюу Засгийн газар. Нэг ёсондоо, татварын орлогыг хуулиар тогтоогоод өгчихөж байна шүү дээ. Чи энэ мөнгөө яг л зориулалтын дагуу ном ёсоор нь зарцуулна шүү. Чиний хувийн мөнгө биш гээд юунд яаж зарцуулах вэ гэдгийг шийдэх эрхийг нь Улсын Их Хуралд өгч байгаа юм. Гэтэл өндөр хөгжилтэй улс орнууд тэр төсвөө зарцуулж байгаа байдал нь тэс өөр. Тэнд бол задгай мөнгөөр нь хяналтаа тавина, Төгрөг гэж ярихгүй. Өөрөөр хэлбэл, 100000, 10000, 1000 төгрөг гэхгүй, 1, 5, 10 мөнгө задгай нэгж хүртэл нь нарийн хяналт тавьдаг. Яагаад гэвэл энэ чиний биш, татвар төлөгчдийн мөнгө. Тийм учраас татвар төлөгчдийн мөнгийг

хамгийн үр ашигтайгаар зарцуулсан байх ёстой гэж шаарддаг. Тиймээс парламентаар хэлэлцэж баталж байгаа төсөв нь манайх шиг хэдхэн хуудас байдаггүй. Хэдэн зуун мянган хуудас байгаа. Зарим улс орон төсөв хэлэлцэх үеэр парламент дээрээ хэдэн авдар цаасан хайрцагтай зүйл авчирдаг. Тэр дотор нь маш тодорхой биччихсэн Эрүүл мэндийн яам гэхэд ийм мөнгө зарна. Бичиг цаасны зардал гэхэд тэдэн төгрөг гээд задаргаа нь байдаг. Бичиг цаас гээд ерөнхий дүн тавиад орхих биш, бүүр задаргаа нь А4 цаас бол та нар тэдийг авна шүү гээд бичсэн байх жишээтэй. А4-ийн цаасаа бас задална. Энэ нь нэгдүгээр зэргийн А4 гэд байна, 2 дугаар зэргийн А4 гэд байна, хүрэн цаас гэх мэтээр ярьдаг. Хэрвээ чи зориулалтын бусаар зарцуулсан байна. 2 дугаар зэргийн А4-г зориулсан мөнгөөр 1 дүгээр зэргийнхийг авсан бол хариуцлага хүлээнэ. Манайд бол одоохондоо энэ жишиг рүү хараахан орж чадаагүй байна. Багцлаад л байгаа. Багцаар нь том том дүнгээр нь төсөвт тусгадаг.

ӨМНӨХ ОНЫХОО ТӨСВИЙН ЗАРЦУУЛАЛТЫГ ГИШҮҮД Ч БАРАГ ӨӨРСДӨӨ ХЯНАЖ ЧАДАХГҮЙ ДҮР ЗУРАГ ЗАРИМ ТОХИОЛДОЛД ХАРАГДААГ. ЭНЭ НЬ ЭРГЭЭД ХАРИУЦЛАГАГҮЙ БАЙДЛЫН ЭХЛЭЛ БОЛЖ БАЙНА?

Төсөвт орлогоо бүрдүүлж, зарлага тодорхойлохоос гадна гүйцэтгэл гэж зүйл бий. Товчхондоо, төсвөө яаж гүйцэтгэж, хэрэгжүүлэхийг хэлж байгаа юм. Хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаанд нь хяналт тавьдаг механизм юу юунаас илүү чухал. Түүний төлөө Улсын Их Хурал ажилладаг байх гэж боддог юм. Харамсалтай жишээ татахад 2013 оны төсөв хэлэлцэх үеэр эдийн засгийн шинэтгэл хийнэ гээд 50 тэрбум төгрөг төсөвлөсөн байсан. Юу хийх

гээд байгаа юм гээд асуухаар “Үгүй яах вэ дээ тэгээд л тавьчихсан байж байг л дээ” гэсэн. Өөрөөр хэлбэл, сайд дарга нар төсөвт ингэж хандаж байна. Ингэж хандана гэдэг нь Монголд төсөв, түүнийг тойрсон асуудал, төсвийн сахилга гэдэг ямар түвшинд байна вэ гэдгийг л их тод харуулж байна.

БУСАД ХӨГЖИНГҮЙ УЛС ОРНУУДААС ХАРАХАД ХАМГИЙН САЙН ТӨСӨВТЭЙ ГЭХ ЖИШИГ БАЙЖ БОЛОХ УУ?

Өндөр хөгжилтэй OECD-гийн 24 орон гэж байгаа шүү дээ. Тэр 24 орон ерөнхий баримжаа болдог. Хамгийн гол нь төсвийнхөө гүйцэтгэл дээр хяналт тавьдаг. Хоёрдугаарт, шаардлагатай үедээ төсөв мөнгөө төвлөрүүлж чаддаг. Өнөөдөр Монгол Улсын хамгийн чухал асуудал юу юм бэ гэхээр жагсаалт гаргаад ирэх нь байна. Магадгүй 10 асуудал гаргаад ирлээ гэж бодъё. Тэр 10 асуудлаа эрэмбэлэнэ. Энэ нь нэгдүгээрт, энэ нь хоёрдугаарт гэж эрэмблээд хамгийн чухал асуудал дээрээ төсвөө төвлөрүүлээд хэрэгжүүлээд явж байгаа чадвар их чухал. Жил жилийн төсвийг харахад хүссэн хэмжээгээр орлогын эх үүсвэр байхгүй, бүгдийг нь хөрөнгө оруулалт руу хийж чадахгүй. Хөрөнгө оруулалтад зориулагдаж байгаа зүйл нь харьцангуй бага байна. Ийм тохиолдолд юун дээрээ мөнгөө төвлөрүүлэх ёстой вэ, алинд нь илүү анхаарлаа хандуулах ёстой вэ гэдгээ гаргаж ирэх ёстой. Тухайлбал, эрчим хүчний салбарыг анхаарах хэрэгтэй. Яагаад гэвэл эдийн засгийн суурь нь эрчим хүчний салбар. Гэрэл цахилгаангүй бол жижиг, дунд үйлдвэрлэл, эмнэлэг, боловсрол, том аж үйлдвэр, зам тээвэр, холбооны тухай яриад хэрэггүй. Байшин барилга бариад ч хэрэг алга байна. Өнөөдөр залуус орон сууцанд оръё гэж хүсч мөрөөдөж байгаа. Байшин барилгаа гэж бодъё. Тэнд нь

гэрэл, халаалт байхгүй бол байшингаар яах юм. Тэгэхлээр, өнөөдөр ард иргэдийн амьдрал ахуйг дээшлүүлж, орон сууцны асуудлыг шийдье гэхэд эрчим хүч, дулааны үйлдвэрлэлийн хязгаарлалт үүсч байна. Тиймээс эрчим хүчний асуудал маш чухал юм. Бид өнөөдөр эрчим хүчний хязгаарлалтуудыг хийгээд эхэллээ. Эрчим хүчний эрэлт хэрэгцээ жилд 20-иос доошгүй хувиар өсөөд байгаа. Тэгэхээр, манайд үйлдвэрлэж байгаа эрчим хүчийг өнөөгийн түвшиндээ барихын тулд жилд 20 хувиар өсч байх ёстой. Тэгээд цааш хөгжье гэж байгаа бол түүнээс илүү их хэмжээний эрчим хүч, дулаан үйлдвэрлэх шаардлагатай. Ингэхийн тулд ТЭЦ-V, баруун аймгуудад 36 мегаваттын цахилгаан станц барих тухай асуудал байна. Энэ ганц, хоёр хоногийн дотор барьдаг зүйл бас биш. Зураг төсвийг нь гаргана, газар шорооныхоо ажлыг хийгээд барилгаа бариад дуусна гэхээр хамгийн багаар бодоход 3-4 жил шүү дээ. Тэгэхлээр, өнөөдөр мөнгөө зарж байж 4 жилийн дараа цахилгаантай болох тухай асуудал яриад байна шүү дээ. Гэтэл өнөөдөр мөнгөө зараагүй байж жил болгон 20 хувийн эрэлт хэрэгцээтэй байдаг.

ОДОО ТЭГЭЭД ЯАХ ЮМ?

Гүйцэтгэх засаглал “Олон юм яриад байхгүй шүү нөхдүүдээ байдал ийм байгаа учраас Монгол Улсын амин чухал салбар болоод байгаа эрчим хүч рүү бид хөрөнгө оруулалтаа чиглүүлнэ. Зарим газар конторын, аймгийн төвийн цэнгэлдэх хүрээлэн барихгүй” гэж зоригтой хэлэх ёстой. Өнөөдөр эрчим хүчнийхээ асуудлыг шийдэхгүй бол дараа жил, 4 жилийн дараа бүр ямар ч асуудлыг шийдэж чадахгүй болчих гээд байна гэдгийг ойлгуулж, хөрөнгө мөнгөө үүнд зарцуулах ёстой. Үүнийг бид хийхгүй байна.

ТӨСӨВ, МӨНГӨНИЙ БОДЛОГО

Ц.Батсүх

СЭЗИС-ийн Экономиксийн тэнхимийн профессор,

Монголбанкны Мөнгөний бодлогын зөвлөлийн хараат бус гишүүн, Доктор (Ph.D)

Хураангуй. Энэ өгүүлээр өнгөрсөн жилүүдэд Монгол улсын макро эдийн засгийн үндсэн зорилтуудыг хангахад төсөв, мөнгөний бодлого хэрхэн чиглэж байсан хийгээд ирэх жилийн бодлогын чиг хандлагыг авч үзнэ. Мөн 2018 оны төсөв, мөнгөний бодлого нь эдийн засгийн зорилтуудыг хангахад ямар нөлөө үзүүлэх талаар өгүүлсэн болно.

Түлхүүр үгс: Сангийн бодлого, мөнгөний бодлого, бодлогын хугацааны хожимдол, дискрет ба тасралтгүй бодлого

НЭГ. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО, ТЭДГЭЭРИЙН УЯЛДАА ХОЛБОО

Макро эдийн засгийн бодлого нь эдийн засгийн өсөлтийг хангах замаар иргэдийн амьдралын чанарыг сайжруулах, инфляци, ажилгүйдлийг аль болох тогтвортой нам түвшинд байлгах, төсвийн болон төлбөрийн тэнцлийн алдагдлыг бууруулах зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэдэг. Эдгээр зорилтуудыг хэрэгжүүлэхийн тулд парламентаас баталсан үндсэн чиглэл, үзэл баримтлалын хүрээнд Засгийн газраас төсвийн (сангийн), Төвбанкнаас мөнгөний бодлогыг явуулдаг. Сангийн бодлогын үндсэн арга хэрэгсэл нь татвар, шилжүүлэг, төсвийн зарлага зэрэг хэрэгслүүд байдаг бол Төвбанкны мөнгөний бодлого нь бодлогын хүү, мөнгөний нийлүүлэлтийн зохицуулалтаар дамжин хэрэгждэг.

Макро эдийн засгийн бодлогын арга хэрэгслийн сонголт, бодлогыг хэрхэн хэрэгжүүлэх тал дээр эдийн засгийн онолын сургуулиуд маргаантай байдаг. Тухайлбал, сонгодог эдийн засгийн сургуулиас угшилтай шинэ сонгодог болон бодит бизнесийн мөчлөгийн сургуулиуд эрэлтийн талын бодлогууд макро эдийн засагт үр ашиггүй, харин нийлүүлэлтийн

талын бодлогуудын тусламжтай макро эдийн засгийн зорилтуудыг хангах ёстой гэж үздэг бол Кейнсийн чиглэлийн пост кейнсийн болон шинэ кейнсийн сургуулиуд эрэлтийн талын дискрет бодлогуудыг явуулахыг дэмжсээр байна. Мөн монетарист сургуулийнхан мөнгөний эмх замбараагүй нийлүүлэлт эдийн засгийн уналт, өсөлтийн гол шалтгаан болдог хэмээн үзэж, мөнгөний нийлүүлэлтийг тогтвортой өсөлттэйгээр хийх нь эдийн засгийг тогтворжуулах үндэс гэсэн үзэл баримтлалтай байдаг.

Эдийн засгийн нөхцөл бүрт тохирсон идэвхтэй бодлого явуулах бололцоогүй гэж зарим эдийн засгийн сургуулиуд тайлбарладаг. Учир нь бодлогын дотоод, гадаад хожимдлоос болж, бодлогыг боловсруулаад хэрэгжүүлж үр дүн гарахыг хүлээх хооронд эдийн засгийн нөхцөл байдал өөр болсон байдаг. Нөхцөл байдлыг таньж мэдээд, түүнд тохирсон бодлогыг боловсруулж батлах хүртэлх хугацааг бодлогын хугацааны дотоод хожимдол, харин бодлого батлаад үр дүн гарах хүртэлхийг гадаад хожимдол гэдэг. Төсвийн бодлого дотоод хожимдол, мөнгөний бодлого гадаад хожимдол ихтэй

байдаг.

Сүүлийн жилүүдэд макро эдийн засгийн бодлогын үр нөлөөг тайлбарлахдаа улс төрийн институцийн гажуудлуудыг авч үзэх болов. Улс төрчдийн шийдвэр гаргалт нь ашигч үйл хөдлөл, дахин сонгогдох хүсэл, эзэн-төлөөлөгчийн бэрхшээл зэрэг ойлголтуудаар илүүтэй тайлбарлагдах, ухаалаг бус төрийн загвараар хэрэгждэг гэсэн шинэ улс төрийн макроэкономиксийн парадигм хүчтэй болж байна.


Төсөв, мөнгөний бодлогын богино хугацааны уялдаа холбоог харьцуулан судлах бололцоог нээлттэй эдийн засгийн IS-LM-BP загвар олгодог. IS загвар нь бүтээгдэхүүний захын тэнцвэрт нөхцөлийг илэрхийлдэг бол харин LM загвар нь мөнгөний захын тэнцвэрийг тодорхойлдог. BP загвар нь гадаад секторыг нөхцөл байдлыг илэрхийлэх ба төлбөрийн тэнцлийг хэрхэн хангаж байгааг байдлыг харуулдаг. Эдгээр загварууд нь макро эдийн засгийн эрэлтийн талын бодлогуудын харилцан хамаарлыг тайлбарлах хэрэгсэл болон ашиглагддаг. Энэхүү загварын

шинжилгээний үр дүн үнийн түвшин харьцангуй тогтвортой байгаа үед бодит байдалтай нийцдэг.

Манай улсын эдийн засаг нь нээлттэй, зохицуулалттай хөвөгч ханштай, жижиг эдийн засаг юм. Тиймээс дэлхийн зах зээлийн үнийг хүлээн авагч орон билээ. Өөрөөр хэлбэл, дэлхийн зах зээл дээрх эрдэс болон нефть бүтээгдэхүүний үнэд нөлөөлж чадахгүй гагцхүү түүнийг хүлээн авч, тухайн нөхцөлд зохицон үйл ажиллагаа явуулдаг. Эдийн засагчдын хийсэн судалгаагаар манай эдийн засгийн мөчлөгийн хэлбэлзэл нь гадаад зах зээлийн эрдэс бүтээгдэхүүний үнэ, байгаль, цаг уурын нөхцөл, улс төрийн шийдвэр зэргээс хамаардаг гэж тогтоосон байдаг.

Төсөв, мөнгөний бодлого үндэсний эдийн засгийн цар хүрээ, ханшийн дэглэм, хөрөнгийн урсгалын зохицуулалт, институцийн чадавхи зэргээс хамааран ялгаатай үр дүнг өгдөг. Төсөв, мөнгөний бодлогын үр дүн хэрхэн илрэхийг нээлттэй, хөвөгч ханштай, жижиг эдийн засагтай орны загвараар тайлбарлая.

Зураг 1. Сангийн тэлэх бодлогын нөлөө



Эдийн засгийн тэнцвэр А цэгт хангагдсан байгаа гэж үзье. Төсвийн зарлагын өсөлтөөр илэрхийлэгдэх сангийн тэлэх бодлого явуулснаар IS муруй (1) хөдөлгөөний дагууд баруун дээш шилжинэ. Энэ тохиолдолд эдийн засаг В

цэгт ирэх ба дотоодын хүүний түвшин өснө. Энэ нь гадаадын хөрөнгө орж ирэх нөхцөлийг бүрдүүлэх ба дотоодын валютын эрэлтийг ихэсгэж, улмаар дотоод валютын ханшийг чангаруулна. Дотоод валютын ханшийн чангаралт нь

харьцангуй үнэ буюу валютын бодит ханшийг өсгөснөөр цэвэр экспортыг багасгах ба мөн төлбөрийн тэнцлийн урсгал тооцоо алдагдалтай болно. Энэ тохиолдолд IS муруй зүүн доош шилжих (2a) ба BP муруй дээш шилжих (2c) C цэгт эдийн засгийн шинэ тэнцвэр тогтох болно. Энд мөнгөний эрэлт гадаад валютын ханшаас хамаарахгүй гэсэн таамаглал байгаа тул LM муруй шилжилт хийхгүй. Үр дүнд нь богино хугацаанд бодит бүтээгдэхүүн $Y_0 - Y_1$ болж, эдийн засаг өснө. Төвбанкнаас мөнгөний нийлүүлэлтэд нөлөөлсөн бодлого явуулбал, Y_1 –ийн хэмжээнд дахин өөрчлөлт орж, өсөлтийн

хэмжээ ялгаатай гарна. Энэ мэтчилэн, тус загварын ашиглан төсөв, мөнгөний бодлогын уялдааг хэрхэн хангах боломжийг тайлбарладаг.


Макро эдийн засгийн хоёр үндсэн бодлогын харилцан хамаарлыг "Засгийн газар", "Төвбанк" гэсэн хоёр оролцогчтой тоглоом байдлаар томъёолж, хоёр субъект актив болон пассив бодлого явуулснаар нийт эдийн засгийн хожоо ямар байхыг тогтоож, Нэшийн тэнцвэр хийгээд Парето үр ашигт байдал хэрхэн тогтохыг шинжилснээр бодлогын уялдаа холбоог тайлбарласан байдаг.

ХОЁР. ТӨСӨВ, МӨНГӨНИЙ БОДЛОГЫН УЯЛДАА ХОЛБОО, 2000-2016 ОН

Сангийн бодлогын тэлэлт, агшилтыг Засгийн газрын зарлагын өөрчлөлтөөр, харин мөнгөний бодлогынхыг M2 мөнгөний нийлүүлэлтийн өөрчлөлтөөр

тус, тус хэмжив. Дараахь зурагт Монгол Улсын нэгдсэн төсвийн зарлагын өөрчлөлт болон эдийн засгийн өсөлтийн хамаарлыг авч үзэв.

Зураг 2. Эдийн засгийн өсөлт болон төсвийн зарлагын өсөлтийн хамаарал




Зураг 1-ээс харахад Засгийн газрын зарлага нь эдийн засгийн өсөлтийг даган тэлж, агшиж байна. Энэ хамаарал нь төсвийн бодлогын нөлөөгөөр эдийн засаг өсөөд байна уу, аль эсвэл эдийн засгийн нөхцөлдөө зохицож сангийн бодлого явагдаад байна уу гэсэн

асуултанд хариулахыг шаардана. Ихэнх судлаачдын дүгнэлтээр мөчлөг дагасан бодлого хэрэгжүүлдэг болохыг нотолсон байдаг тул манай улсын хувьд зорилтот бус сангийн бодлого явагддаг гэсэн дүгнэлт хийхээр байна. Энэ байдал нь төсвийн тогтвортой байдлын хуулиар

төсвийн алдагдлыг нэрлэсэн ДНБ-ий тодорхой хувиас хэтрүүлэхгүй байх шалгуураас болдог ч байж болзошгүй юм. Мөн 2016 оны энэ хоёр үзүүлэлтийн сөрөг хамаарлыг улс төрийн сонгуулийн нөлөөтэй холбон тайлбарлаж болох юм. Мөн энэ байдал нь 2000-2016 оны хооронд төсвийн бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийн үйл явц нэг л хэв маягаар явж байгааг давхар илтгэж байна. Эдийн засгийн өсөлтийн түвшинг дундажаар 2.5 дахин өсгөсөн хэмжээгээр төсвийн зарлага ихэсч байна.

Бодит мөнгөний буюу худалдан авах чадвараар нь тэгшитгэсэн мөнгөний нийлүүлэлтийн өсөлт, эдийн засгийн өсөлтийн хамаарлыг доорх зурагт үзүүлэв. Зураг 3-аас мөнгөний нийлүүлэлтийн өөрчлөлт нь эдийн засгийн өсөлтөнд нэг жилийн хожимдолтой нөлөөлж байгаа нь харагдаж байна. Энэ хамаарал нь 2008 оноос хойш илүүтэй мэдрэгдэж байгаа нь Төвбанк мөнгөний бодлогын арга хэрэгсэл, бодлогын хүрээгээ өөрчилсөнтэй холбоотой байж болзошгүй юм.

Зураг 3. Эдийн засгийн өсөлт болон мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийн хамаарал




Ажилгүйдлийн түвшин, эдийн засгийн өсөлтийн хамаарлыг Оукений хуулийн хүрээнд авч үзвэл ажилгүйдлийн нэг нэгж хувийн өсөлт нь эдийн засгийн 1.6 хувийн өсөлтийг алдах нөхцөл болж байна. Хэрвээ ажилгүйдлийн хэвийн түвшинг 6 хувь гэж үзвэл манай улсын эдийн засгийн дундаж өсөлт 10 орчим хувь байж болох юм. Энд тооцооллыг хийхдээ 2009 оны ажилгүйдлийн түвшний зөрүүгээр өмнөх онуудын үзүүлэлтийг засварлан тооцоолсон болно.

Энэ хугацаанд төсвийн болон мөнгөний бодлогын чиг хандлага ямар хамааралтай байсныг сонирхоё.


Төсөв, мөнгөний бодлого 2014 оныг хүртэл эсрэг чиглэлтэй хэрэгжсэн

Зураг 4. Ажилгүйдэл ба эдийн засгийн өсөлт



бол 2015-2016 онд ижил чиглэлтэй явагдсан байна. Эдийн засгийн мөчлөгийн бууралттай үед сангийн

Зураг 5. Төсөв, мөнгөний бодлогын чиг хандлагын хамаарал



хумих, мөнгөний тэлэх чиглэлийн бодлого хэрэгжсэн нь богино хугацааны инфляци, ажилгүйдлийн урвуу хамаарлаас шалтгаалсан байж болзошгүй. Харин сүүлийн 2 жилд нь инфляцийн түвшин нам дор байсантай холбоотой мөнгөний

бодлогыг сулруулсан, эсвэл сангийн бодлого мөнгөний бодлогоор дэмжсэн байдлаар, "сангийн бодлогын ноёрхол" дор мөнгөний бодлого явуулсан гэсэн гаргалгааг хийхээр байна.

ГУРАВ. 2017 ОНЫ ТӨСӨВ, МӨНГӨНИЙ БОДЛОГО БОЛОН 2018 ОНЫ ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙД

Хүснэгт 1. 2017 оны урьдчилсан гүйцэтгэл, 2018 оны төсөөлөл

Үзүүлэлтүүд	2017 оны урьдчилсан гүйцэтгэл	2018 оны төсөөлөл, төсвийн баримт бичигт тусгаснаар	2018 оны мөнгөний бодлогын үндсэн чиглэлд тусгаснаар
ДНБ, өсөлтийн хувь		4.2	3.5-8.6
Инфляци, өмнөх оны эцэстэй харьцуулсан хувиар		8.6	6.0-11.0
M2 мөнгөний өсөлтийн хувь	24.2		21.9
Нэгдсэн төсвийн зарлага, /тэрбум төгрөг/ хоёр дахь тодотголоор	9,154.5	9,651.9	
Нэгдсэн төсвийн зарлагын өсөлтийн хувь		5.5	
Төсвийн урсгал зарлага /тэрбум төгрөг/	7,001.2	7,452.2	
Хөрөнгийн зарлага /тэрбум төгрөг/	1,989.5	1,989.5	
Эргэж төлөгдөх цэвэр зээл /тэрбум төгрөг/	339.4	210.2	

Ирэх оны төсөв, мөнгөний бодлогын уялдаа холбоог авч үзэхдээ “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2018 онд баримтлах үндсэн чиглэлийн төсөл”, “Монгол Улсын 2018 оны төсвийн баримт бичиг” зэрэг материалыг ашиглав. Эдгээр бичиг баримтуудад 2017 оны урьдчилсан гүйцэтгэл, 2018 оны төсөөллийг дараах байдлаар хийсэн байна.


Хүснэгт дэх үзүүлэлтүүдээс тооцоолоход 2018 онд нэгдсэн төсвийн зарлага инфляцийг 8 хувийн зорилгот түвшинд хадгалагдана гэж үзвэл бодит утгаараа 2.5 хувиар буурч, бодит мөнгөний нийлүүлэлт 13.9 хувиар өсөхөөр байна. Өөрөөр хэлбэл төсвийн хувьд илүү чангарсан бодлого, мөнгөний илүү зөөлөн бодлого явагдахаар урьдчилан

тооцоологдсон байна. Энэ нь эдийн засгийн мөчлөгийн хямралтай үеийн бодлогын хослолын санал болжээ.

Төсвийн орлогын бүтцийг 2010 онтой, 2017 оны урьдчилсан гүйцэтгэл, 2018 оны төсөөллийг харьцуулан дараах зурагт харуулав. Зургийн дотор хүрээнд 2010 оны гүйцэтгэлийг, дунд хүрээнд 2017 оны урьдчилсан гүйцэтгэлийг, харин гадна хүрээнд 2018 оны төлөвлөсөн байдлыг дүрслэв. Зураг 6-аас харахад гурван онд төсвийн орлогын бүтцийн хувьд онцын өөрчлөлт гараагүй байна.

Татварын орлого нийт орлогын 86-87 хувийг эзэлж байгаа бол татварын бус урсгал орлого 12-13 хувийг, үлдсэн 1-2 хувийг хөрөнгийн болон тусламжийн орлого эзэлж байна.

Зураг 6. Төсвийн орлогын бүтэц, 2010, 2017, 2018



Татварын урсгал орлого

2010	86%
2017	86%
2018	87%

Хөрөнгийн орлого

2010	0%
2017	0%
2018	0%

Татварын бус урсгал орлого

2010	13%
2017	12%
2018	12%

Тусламжийн орлого

2010	1%
2017	2%
2018	1%

Төсвийн зарлагын бүтцийг мөн дээрх гурван оноор харьцуулан авч үзвэл, бараа, үйлчилгээний зардал болон хөрөнгийн зардал хумигдаж, зээлийн үйлчилгээний

төлбөр, эргэн төлөгдөх цэвэр зээл их хэмжээгээр нэмэгдсэн байна. Энэ нь сүүлийн жилүүдэд гадаадаас бонд босгож, их хэмжээгээр зээл авч байгаатай

Зураг 7. Төсвийн зарлагын бүтэц



Эргэн төлөгдөх цэвэр зээл

2010	8%
2017	6%
2018	2%

Бараа, үйлчилгээний зардал

2010	38%
2017	33%
2018	34%

Татаас ба урсгал шилжүүлэг

2010	34%
2017	26%
2018	31%

Зээлийн үйлчилгээний төлбөр

2010	1%
2017	11%
2018	12%

Хөрөнгийн зардал

2010	19%
2017	24%
2018	21%

холбоотой.


Төсөв, мөнгөний бодлогын 2018 оны чиглэлээс дүгнэхэд ирэх онд эдийн засгийн өсөлт болон инфляци тооцоологдсон түвшний орчимдоо байх ба харин ажилгүйдэл 9.7 орчим хувь байхаар байна.

Төсвийн зарлагад урсгал зарлага 76-81 хувийг эзэлж байгаа нь эдийн засгийн өсөлтөд байнгын нөлөөлөл болж чадахгүй, нэг удаагийн нөлөөлөл болон

хувирч, хөрөнгийн зарлагын бууралт нь эдийн засгийн өсөлт, ажил эрхлэлтийг дэмжиж чадахгүйгээр байна.

Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт болон инфляцийн түвшний хамаарлыг 1995-2016 оны байдлаар авч үзэхэд хоорондоо маш сул хамааралтай байна. Үүнийг манай улсын инфляци нь эрэлтийн шалтгаантай гэхээсээ илүү нийлүүлэлтийн талын шалтгаантай байдаг гэж дүгнэж болохоор байна.

Зураг 8. Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт болон инфляцийн түвшин



Төвбанк мөнгөний нийлүүлэлтийн нэрлэсэн өсөлтийг 20 орчим хувьд байлгахад инфляцийг зорилгот 8 хувьд барих бололцоотой байна. Мөнгөний бодлогын хүрээнд мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлж чадвал, хугацааны хожимдолтой нөлөөгөөр

2019 оноос эдийн засгийн өсөлтийг хурдасгахад хүчтэй нөлөөлж болох юм. Гэхдээ төсвийн бодлогоор 2019 онд эдийн засгийн бодит өсөлтийг дэмжихгүй бол инфляцийг хурдасгах нөхцөл ч болж мэдэлгүй юм.

ДҮГНЭЛТ, САНАЛ

- Макро эдийн засгийн төсөв, мөнгөний бодлогын уялдааг хангах тал дээр хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хуулийн хүрээний зохицуулалтуудыг чанд мөрдөж, улс төрийн нөлөөг багасгах тал дээр анхаарах хэрэгтэй
- Төсвийн бодлогын хугацааны дотоод хожимдол (бодлого боловсруулаад батлах хүртэлх), мөнгөний бодлогын хугацааны гадаад хожимдол (баталсны

дараа бодлогын үр дүн гарах хүртэлх) — уудыг харгалзан бодлогын арга хэрэгслийн сонголтыг зөв хослуулах шаардлагатай байна

- Сүүлийн 10-аад жилд төсвийн бодлогын хувьд макро эдийн засгийн тодорхой зорилтыг хангах тал дээр идэвхитэй бодлого явуулаагүй, эдийн засгийн нөхцөл байдлаа дагасан зорилтот бус шинжтэй бодлого явагдсан байна.

Төсвийн орлогын бүтцийн хувьд ямарч өөрчлөлт гараагүй байна.

- Төсвийн зарлагын бүтцэд зээлийн үйлчилгээний зардал, эргэн төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ нэмэгдэж, хөрөнгө оруулалтын болон бараа, үйлчилгээний зардал шахагдан, хумигдаж байна. Энэ нь Засгийн гадаад зээллэг сүүлийн жилүүдэд ихэссэнтэй холбоотой
- Төсвийн зарлагад урсгал зардлууд ихэнх хувийг эзэлж байгаа нь эдийн засгийн бүтцийн өөрчлөлтөд чиглэсэн төсвийн хөрөнгө оруулалт хийгдэж, ажилгүйдэл, нийлүүлэлтийн талын инфляцийг шийдэх тал дээр анхаарахгүй байгааг илтгэнэ
- Мөнгөний бодлого нь 2000 оноос хойш ихэнх хугацаанд төсвийн бодлогын эсрэг чиглэлтэй явагдсан нь тодорхой хэмжээнд эдийн засгийн тогтворжилтийг хангах чармайлт

гаргасан гэсэн дүгнэлтийг хийж болохоор байна.

- Эрэлтийн талын богино хугацааны бодлогоос нийлүүлэлтийн талын урт хугацааны бүтцийн өөрчлөлтийн бодлогуудыг авч хэрэгжүүлэхгүй бол инфляцийг богино хугацаанд тогтворжуулж байгаа хэдий ч ажилгүйдлийг бууруулж чадахгүй байдалд хүрч байна
- 2018 оны төсөв, мөнгөний бодлого нь төсвийн хувьд хумих, мөнгөний хувьд тэлэх чиглэлтэй эдийн засгийн мөчлөгийн уналтын үеийн хослол болсон байна. 2018 оны хувьд гадаад эдийн засгийн таатай нөлөөллийн дор эдийн засаг харьцангуй өсөх бололцоотой байгаа байдлыг харгалзан, төсвийн бодлого талд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх чиглэлд анхаарах нь зүйтэй байна.

НОМ ЗҮЙ

1. Төрөөс мөнгөний бодлогын талаар 2018 онд баримтлах үндсэн чиглэлийн төсөл
2. Монгол Улсын 2018 оны төсвийн баримт бичиг
3. www.1212.mn
4. П.Авралт-Од., Г.Бумчимэг., Б.Даваадалай., Төсөв, мөнгөний бодлогын уялдаа: Динамик стохастик ерөнхий тэнцвэрийн загвар(DSGE), Монголбанк "Судалгааны ажил"-Тохимол-6
5. Grcic V., (1999). The Polak's Macroeconomic Monetary Model.
6. Taylor.J.B., (2016). Central Bank Models: Lessons from the Past and Ideas for the Future,
7. Төсөв, мөнгөний бодлогын уялдааг хангах асуудал буюу инфляцийн эсрэг хамтын ажиллагаа, www.iltod.gov.mn
8. Д.Батням., Д.Ган-Очир., Tomasz Lyziak., (2008). Монголын инфляцийг таамаглах хураангуй загвар (SIMOM), Монголбанкны судалгааны тохимол
9. The interaction between fiscal and monetary policy: -before and after the financial crisis., FIRSTRUN-Fiscal Rules and Strategies under Externalities and Uncertainties, Funded by the Horizon 2020 Framework Programme of the European Union Project ID 649261, FIRSRUN deliverable 4.2
10. Tomislav Coric, Hrvoje Simovic, Milan Deskar-Skrbic., (2015). Monetary and fiscal policy mix in a small open economy: the case of Croatia., Economic Research – Ekonomska Istrazivanja, 28:1, 407-421, DOI: [10.1080/1331677X.2015.1059073](https://doi.org/10.1080/1331677X.2015.1059073)

2018 ОНЫ ТӨСӨВ БА ХӨДӨӨ АЖ АХУЙН ТУЛГАМДСАН АСУУДЛУУД

Ч.Наранчимэг

*СЭЗИС-ийн ХМСТ-ийн профессор багш, ММН-ийн УЗ-ийн гишүүн,
НШУЗЭХ-ны УЗ-ийн гишүүн, Доктор (Ph.D)*

Хураангуй. Манай улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжин орсноос хойш эдүгээ 27 жил өнгөрчээ. Эдийн засгийн өсөлтийн сүүлийн хорь гаран жилийн динамикаас харахад эхний хэд хэдэн жил бууралттай, харин 2011-2013 оны байдлаар хоёр оронтой тооны өсөлттэй байсан хэдий чсүүлийн 3 жил орчим эдийн засгийн өсөлт нэг оронтой тоонд шилжиж, энэ жилийн хувьд АХБ-наас гаргасан урьдчилсан дүн мэдээгээр эдийн засгийн өсөлт дөрөв орчим хувь, 2018 оны төсөвт 3.3% байхаар төсөөлсөн байна. Иймд эдийн засгийн энэхүү нөхцөл байдлаас үүдэн улсын нэгдсэн төсвийн орлого, зарлагыг зөв төлөвлөх, улмаар орлогыг дорвитой нэмэгдүүлэх боломж гарцыг хайхявдал юм. Улсын төсвийн бодлого нь төсвийн орлогоос хамааран төсвийн зарлагыг хуваарилдаг процесс бөгөөд ирээдүйд орж ирэх орлогыг оновчтой таамаглаж тооцох нь бодлогын шийдвэр гаргалтад чухал үр нөлөөтэй юм. Энэхүү өгүүлмээр Монгол улсын төсөв, хөдөө аж ахуйн тулгамдсан асуудлын уялдаа болон эдгээр асуудлуудыг шийдэхэд төсвийн орлого, зарлагын төлөвлөлт хэрхэн нөлөөлөх, өнгөрсөн жилийн гүйцэтгэлийн үр нөлөө зэргийг авч үзэх болно.

Түлхүүр үгс: Улсын нэгдсэн төсөв, хөдөө аж ахуйн салбар, улсын төсвийн орлого, улсын төсвийн зардал, ХАА-н салбарын төсвийн орлого, ХАА-н салбарын төсвийн зардал

ОРШИЛ

Нийгмийн хэрэгцээг хангахын тулд төрд тодорхой хэмжээний мөнгөн хөрөнгийн эх үүсвэр шаардагддаг. Энэ эх үүсвэрийг төр нь татвар хэлбэрээр бүрдүүлж орлого хуримтлуулан нийгмийн хэрэгцээг санхүүжүүлэх боломжийг олж авдаг бөгөөд үүний үр дүнд орлого, зарлагын тэнцэл, санхүүгийн төлөвлөгөө буюу төсөв бий болдог. Төсвийг эдийн засгийн агуулгаар нь авч үзвэл нэг талаас байнга хязгаартай байдаг орлого буюу нөөцийгямар хэмжээгээр хэрхэн хуримтлуулах, нөгөө талаас энэхүү хуримтлуулсан хязгаартай нөөцийг байнгын өсөн нэмэгдэж байдаг төр болон нийгмийн хэрэгцээг хангахад хэрхэн хүртээж, дахин хуваарилах төрийн санхүүгийн тэнцлийн төлөвлөлтийн

асуудал байдаг. Нэгдсэн төсвийн орлого нь татварын орлого, татварын бус орлого, хөрөнгийн ба тусламжийн орлогоос бүрддэг. 2016 он болон 2017 оны урьдчилсан дүн мэдээгээр улсын төсвийн орлогын төлөвлөгөө давсан биелэлттэй байгаа хэдий ч төсвийн орлогод эдийн засгийн өсөлт, уул уурхайн бүтээгдэхүүний экспорт, импортын бууралт, Оюу толгойн төсөлтэй холбоотой асуудал зэрэг нь гол нөлөөлөх хүчин зүйлс болж байна. Төсвийн орлогын төлөвлөгөөнөөс давсан орлогыг улс төрийн зорилгоор зарцуулах, төсвийн зарлагыг танах, хумих байдлаар асуудалд хандах нь эдийн засгийн нөхцөл байдлыг улам хүндрүүлж, "Төсвийн тогтвортой байдлын тухай хууль" зөрчигдөхөд

хүргэж байна. Хэдийгээр төлөвлөлтийг тооцоо судалгаанд үндэслэн хийдэг ч жил бүр ихэнх улс орон тодорхой хэмжээний төсвийн алдагдал хүлээдэг. Манай орны хувьд төсвийн алдагдал нь савалгаа ихтэй, тогтвортой бус байдаг нь урт хугацаандаа эдийн засгийн нөхцөл байдал улам хүндрэх эрсдэлийг үүсгэж болзошгүй юм. Ялангуяа мал аж ахуйд суурилдаг манай

орны хувьд ХААньтэргүүлэх салбарын нэг бөгөөд салбарын тулгамдаж буй асуудалтай холбоотойгоор "Төр эдгээр асуудлаа олж харсан уу?", "Асуудлаа шийдэх санхүүжилт буюу төсвөө зөв төлөвлөж чадсан уу? гэдгийг тодруулах зорилгоор улсын төсөвт үндэслэн уг судалгааг хийсэн болно.

СУДАЛАГДСАН БАЙДЛЫН СУДАЛГАА

Улсын төсөв, түүний орлого, зарлага тэнцэлтэй холбоотой хийсэн олон улсын байгууллага, эрдэмтэн судлаачдын бүтээл, судалгаа шинжилгээний ажил олон байдаг. Тухайлбал, Ч.Энхбаяр "Монгол улсын 2014 оны нэгдсэн төсвийн төсөлд хийсэн тойм дүгнэлт" (2013), Ричард Дуту "Монгол улсын эрдэс баялгийн орлогын удирдлага"(2012), Дэлхийн банк болон ЕСТАС-ийн төслийн хүрээнд "Монгол улсын 2005 оны төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлд хийсэн мэргэжлийн шинжилгээ"(2006), Б.Мэндбаяр "Татварын орлогын төлөвлөлт болон бизнесийн орчныг сайжруулах асуудлууд"(2010), Д.Баярмаа, П.Хишигбаяр "Монгол улсын 2015 оны төсвийн төсөл, тойм дүгнэлт"(2014), "Монгол улсын 2016 оны төсвийн төсөлд хийсэн тойм

дүгнэлт"(2015) зэрэг ажлуудыг дурдаж болно. Эдгээр судалгаа шинжилгээний ажлууд дотроос Б.Мэндбаяр "Татварын орлогын төлөвлөлт болон бизнесийн орчныг сайжруулах асуудлууд" бүтээлд төсвийн орлогын ихэнх хэсгийг татварын орлого бүрдүүлэх бөгөөд бизнесийн орчин сайжрах үед татварын орлого нэмэгдэж төсвийн орлого тасалдахгүй байх, мөн татварын орлогод нөлөөлөх хүчин зүйлийг судалсан бол Д.Баярмаа, П.Хишигбаяр нарын "Монгол улсын 2015 оны төсвийн төсөл, тойм дүгнэлт" болон "Монгол улсын 2016 оны төсвийн төсөлд хийсэн тойм дүгнэлт"судалгааны ажилд манай улсын эдийн засгийн нөхцөл байдалтай төсвийн төсөл хэрхэн уялдаж байгаад хөндлөнгийн дүгнэлт өгөхийг зорьсон байна.

УЛСЫН ТӨСВИЙН ТАЛААРХ ОНОЛ, АРГАЗҮЙ

Монгол улсын нэгдсэн төсвийн тухай хуульд "Төрийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг бий болгох зорилгоор тухайн жилд төрийн мэдэлд хуримтлуулан хуваарилж зарцуулах мөнгөн хөрөнгийн орлого, зарлагын тэнцлийг Монгол улсын нэгдсэн төсөв", "тухайн төсвийн жилийн төсвийн нийт орлого, зарлагын зөрүүг төсвийн тэнцэл", "нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, нэгдсэн төсвийн нийт зарлагын зөрүүг нэгдсэн төсвийн

тэнцвэржүүлсэн тэнцэл" гэнэ гэж тус тус заасан байдаг. Төсөв нь нэг жилийн хугацаанд татвараар хуримтлуулсан орлогыг хуваарилан зарцуулах замаар давтагдан тойрон эргэж байдаг үйл ажиллагаа бөгөөд тодорхой хэсэг бүлгээр ангилагдсан орлого зарлагын жагсаалтууд жил бүр хуульчлан батлагддаг.


Төсвийн зарчим. Төсвийн үндсэн 5 зарчмыг тогтоож төсвийн процесс, процесс субъектүүдийн эрх үүрэгтэй нь холбон мөрдлөг болгож байна. Үүнд:

- Төсвийн тогтвортой байдлыг хангасан байх
- Төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх
- Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх

- Ил тод байдлыг хангасан байх
- Хариуцлагатай байх

Улсын төсвийн орлого, зарлага. Монгол улсын нэгдсэн төсвийн орлого нь Зураг 1-д тусгагдсан шатлалаар бүрддэг.

Зураг 1. Эдийн засгийн өсөлт, хувь



Мөн төсвийн орлогыг эх үүсвэрийн хувьд дараах байдлаар бүрдүүлнэ.

- Урсгал орлого
- Хөрөнгийн орлого
- Тусламжийн орлого

Төсвийн зарлага нь нийгмийн үйлдвэрлэлийг өргөтгөх, соёл олон нийтийн арга хэмжээг санхүүжүүлэх, шинжлэх ухаан, техник технологийг хөгжүүлэхэд зориулсан улсын төсвийн орлогыг дахин хуваарилах явцад үүсэж буй харилцаа юм. Төрийн чиг үүргийг хэрэгжүүлэхийн тулд батлагдсан төсвөөс төсвийн захирагчийн үйл ажиллагаа, түүний үр дүнг санхүүжүүлэхээр хуваарилж, зарцуулж буй төсвийн хөрөнгийг төсвийн зарлага гэнэ. Төсвийн зарлагыг хэрхэн хуваарилах ямар салбар чиглэлд зарцуулах асуудал нь төрийн бодлогын илрэл юм. Төсвийн зардлыг төлөвлөх үйл ажиллагааны эцсийн үр дүн нь төсвийн орлогоос хамааралтай байдаг. Дэлхийн ихэнх улс, орнууд тэр тусмаа хөгжиж байгаа орнуудын хувьд тохиолддог нэг үзэгдэл бол урсгал зардлаа дутуу төлөвлөж харин хөрөнгө оруулалтаа их төлөвлөх хандлага байдаг. Төсвийн зардлын өдөр тутмын хэрэгцээнд дахин ашиглагдахгүй нэг удаа зарцуулаад өнгөрөх зардлуудыг урсгал зардал гэнэ. Урсгал зардал:

1. Бараа үйлчилгээний зардал. Үүнд:

цалин хөлс, НДШ, бараа үйлчилгээний бусад зардлууд багтана.

2. Зээлийн үйлчилгээний зардал. Үүнд: ЗГ-ын төлөх гадаад зээлийн хүү, улсын зээллэг, бондын хүү, МБ-аас авсан зээлийн хүү орно.
3. Татаас ба урсгал шилжүүлэг. Энэ нь улсын төсвөөс эрчим хүчний болон хотын нийтийн тээвэр зэрэг төрийн өмчийн аж ахуйн нэгжид төсвөөс өгөх татаас, төсөв хоорондын болон төсвийн доторх шилжүүлгүүд, иргэдэд олгох тэтгэвэр тэтгэмж, хөнгөлөлт, нөхөн олговор, олон улсын байгууллагад төсвөөс төлөх гишүүний татвар, хандив хураамжаас бүрдэнэ.

Хөрөнгө оруулалтын зардал нь улсын төсвөөс санхүүжүүлэх улсын өмчид оруулах хөрөнгө оруулалтын зардал юм. Улсын төсвийн нийт зарлагын хамгийн сүүлийн бүрэлдэхүүнд дотоод гадаад зээлийн үндсэн төлбөр ордог.

Төсвийн тусгай шаардлага. Төсөвт дараах тусгай шаардлагууд нэгэн зэрэг хангагдсан байна. Үүнд:

- Нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцдог байх;
- Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн ДНБ-ий 2 хувиас илүүгүй алдагдалтай, ашигтай байх;

- Тухайн жилийн нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь нь тухайн жилийн эрдэс баялгийн бус ДНБ-ий өсөлтийн хувь, тухайн жилийн өмнөх дараалсан 12 жилийн эрдэс баялгийн бус ДНБ-ий өсөлтийн дунджийн аль ихээс хэтрэхгүй байх;
- Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон ДНБ-ий 40 хувиас хэтрэхгүй байх;

Улсын төсвийн төлөвлөлт. Төсвийн төлөвлөлт нь төрийн санхүүгийн бодлогыг хэрэгжүүлэх санхүүгийн төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсгийн нэг юм. Нийгмийн нийт бүтээгдэхүүн ба үндэсний орлогыг улсын нийгэм-эдийн засгийг хөгжүүлэх үндсэн зорилгод чиглүүлэн төвлөрүүлэн хуваарилах, дахин хуваарилан зохицуулах үүргийг төсвийн төлөвлөлт гүйцэтгэдэг. Төсвийн төлөвлөлтийн явцад улс орны эдийн засгийн нөөц байгалийн баялаг, материал, хөдөлмөр санхүүгийн нөөцийг дээд хэмжээгээр дайчлан ашиглах


боломж бий болдог. Төсвийн төлөвлөлт нь тодорхой зорилтууд болон зохион байгуулалтын зарчмыг хангасан байх ёстой. Өөрөөр хэлбэл, төсвийн төлөвлөлт нь бүх шатны түвшинд төсвийг зохиох, хянах, батлах, төсвийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг хамардаг ба харилцан адилгүй хугацаанд төрийн ба төрийн бус байгууллагууд төлөвлөлтийг хуулийн хүрээнд эрхлэн гүйцэтгэдэг.

Төсвийн төлөвлөлтийн зарчим. "Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хууль"-ийн дагуу аккрузал суурьтай төсвийн төлөвлөлтийн болон бүтээгдэхүүнд суурилах зарчмыг тус тус мөрдлөг болгож байна. Бүтээгдэхүүнд суурилсан төсөв гэдэг нь барилга байшин, тоног төхөөрөмж, ажиллаж буй хүний тоо зэрэг байгууллагын эзэмшиж буй хөрөнгө, нөөцөд тулгуурлах бус байгууллагын гадны хэрэглэгчдэд үзүүлэх ажил үйлчилгээ буюу эцсийн бүтээгдэхүүнд тулгуурласан төсөв юм.

ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУД

Хөдөө аж ахуйн салбарын өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудлууд Монгол улсын хөдөө аж ахуйн салбар нь 1990-ээд оны сүүлээр ДНБ-ий 30-аас дээш хувийг эзэлдэг байсан бөгөөд 2004 он хүртэл ДНБ-д эзлэх хувийн жингээрээ байнга тэргүүлж ирсэн. Хэдийгээр уул уурхайн салбар хөгжсөнөөр энэхүү хувийн жин буурсан хэдий ч эдийн засгийн чухал салбар юм. Тухайлбал, өнгөрсөн оны байдлаар ДНБ-ий 12.2%, нийт ажиллагсдын 30%-ийг эзэлж байгаа нь уул уурхайн салбарын дараа орох голлох салбарын нэг хэвээр байгааг харуулж байна. Тус салбарын мах, сүүн бүтээгдэхүүн болон бусад хүнсний бүтээгдэхүүн, ноос ноолуур гэх мэт нэхмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэл нь нийт борлуулалтын орлогын 52% (2016 оны байдлаар)-ийг бүрдүүлж байна.

Зураг 2. Эдийн засгийн өсөлт, хувь



Сүүлийн жилүүдэд дэлхийн зах зээл дээрх уул уурхайн бүтээгдэхүүний үнийн уналтаас шалтгаалан Монгол улсын эдийн засгийн өсөлт огцом саарсан өнөө үед хөдөө аж ахуй болон хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг боловсруулах үйлдвэрлэлийн салбар нь голлох үүрэг гүйцэтгэх хандлагатай байна.

Манай хөдөө аж ахуйн салбар нь мал аж

ахуй, газар тариалан гэсэн 2 томоохон хэсгээс бүрддэг билээ. Уламжлалт бэлчээрийн мал аж ахуй голлодог мал аж ахуйн салбарын хувьд ноолуурын ямааны тоо толгойн өсөлтөөс үүдэлтэй бэлчээрийн доройтол, зуд ган зэрэг байгалийн гамшгийн хохирол, шүлхий гэх мэт малын халдварт өвчин гарахаас сэргийлэх явдал нэн чухал асуудал болж байна. Харин газар тариалангийн салбарын тухайд Засгийн газраас авч хэрэгжүүлсэн бодлогын хүрээнд тариалалтын талбай болон ургацын хэмжээ нэмэгдэж, дотоодын хэрэгцээгээ хангах боломж бий болж байгаа боловч өвлийн улиралд үйлдвэрлэл явуулах, улмаар нийлүүлэлтийн тогтолцоог бий болгох, импортоор орж ирж байгаа хүнсний ногоонд тавигдах хяналт шалгалтыг сайжруулах зэрэг асуудлууд тулгарч байна. Мөн тариалалт ихэссэнтэй холбоотойгоор газар тариалангийн талбайн хөрсний элэгдэл эрчимтэй явагдаж байгааг төрийн зүгээс анхаарах хэрэгтэй болов уу. Энэхүү хоёр салбарын аль алинд нь хамрагдах хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний нийлүүлэлт болон боловсруулах үйлдвэрлэлийн хувьд технологи хоцрогдмол, хөргөлттэй тээвэрлэлт түгээлтийн суваг оновчтой бус байна. Мөн олон улсын стандартад нийцсэн эрүүл ахуй, чанарын хяналтаас

шалтгаалсан хязгаарлагдмал зах зээл, үйлдвэрлэлийн цар хүрээ зэрэг өнөөгийн байдал нь зах зээлийн хангалттай өрсөлдөх чадварыг бий болгож чадахгүй байна. Эдгээр дурдагдаж буй асуудлыг Монгол улсын Засгийн газар анхааралдаа авч, урт хугацааны бодлого болох "Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030" (2016 оны 2 сард УИХ-аар батлагдсан) эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахын тулд хөдөө аж ахуйн салбар нь чухал байр суурьтай хэмээн онцолсноос гадна сүүлийн үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэн хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний борлуулалтыг нэмэгдүүлж, улмаар экспортыг тэлэх зорилт дэвшүүлсэн. Түүнчлэн "Төрөөс хүнс хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого" (2015 оны 11 сард УИХ-аар Монгол Улсын хөдөө аж ахуйн салбарын суурь судалгаа) батлагдсан нь хүнсний аюулгүй байдал, хүрээлэн буй орчны талаар түлхүү анхаарч, нэмүү өртгийн тогтолцоо болон өрсөлдөх чадварыг сайжруулах, хүнсний бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх зорилт тавьсан бөгөөд "Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт" мах, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих үндэсний хөтөлбөр, хөнгөн аж үйлдвэрийн кластерыг хөгжүүлэхээр тусгасан зэргийг дурдаж болно.

Хүснэгт 1. Нэн тэргүүний тулгамдаж буй асуудлууд


Мал аж ахуй	Газар тариалан
- Бэлчээрийн доройтол	- Өвлийн улирлын үйлдвэрлэл (хүлэмжийн аж ахуй)
- Байгалийн гамшиг	- Импортоор орж байгаа хүнсний ногооны хяналт шалгалт
- Малын халдварт өвчин	- Газар тариалангийн талбайн хөрсний элэгдэл
- Бүтээгдэхүүний нийлүүлэлтийн тогтолцоо	
- Тээвэрлэлт болон хөргөлттэй тээвэрлэлт түгээлтийн суваг	
- Боловсруулах үйлдвэрлэлийн технологи	
- Зах зээлийн өрсөлдөх чадвар	

ЭМПИРИК ШИНЖИЛГЭЭ БА ҮР ДҮН


Төсвийн шинэчлэлийн арга хэмжээний үр дүнд Монгол Улсын төсвийн орлого жил бүр өсөж байгаа хэдий ч төсвийг тогтмол алдагдалтай баталж, төсвийн тэлэх бодлого барьж байгаа нь үндэсний мөнгөн тэмдэгтийн өрсөлдөх чадварыг бууруулахад нөлөө үзүүлж байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2018 оны төсвийн хүрээний мэдэгдлийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ 7,231.4 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 23.8%, нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ 9,651.9 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 31.8%, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл -2,420.4 тэрбум төгрөгийн алдагдалтай буюу ДНБ-ий -8% байхаар төлөвлөгдсөн байна.

Зураг 3. Төгрөгийн ам.доллартай харьцах албан ханш /оны эцэст/



Зураг 4. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн төлөвлөгөө, гүйцэтгэл /тэрбум төгрөг/



ЗГ-ын бүтэцтэй холбоотойгоор судалгаанд 2017 оны батлагдсан төсөв, эхний 10 сарын бодит гүйцэтгэл, тодотгосон төсөв,

2017 оны 10-р сарын 26-нд хэлэлцүүлэхээр УИХ-д өргөн мэдүүлсэн 2018 оны төсвийн төсөл зэргийг хамруулан авч үзсэн болно.

Хүснэгт 2. Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, зарлага, тэнцэл

Үзүүлэлтүүд	2017 дүн /Батлагдсан/ тэрбум төг	2017 оны /эхний 10 сарын бодит гүйцэтгэл/ тэрбум төг	2017 оны /тодотгосон/ тэрбум төг	2018 оны /төсөл/ тэрбум төг
Тэнцвэржүүлсэн орлого	6,160.2	6,411.7	6,537.1	7,231.4
ДНБ-д эзлэх хувь	23.3%	-	23.8%	23.8%
Төсвийн зарлага	8,568.9	6,504.6	9,248.6	9,651.9
ДНБ-д эзлэх хувь	32.3%	-	33.7%	31.8%
Тэнцвэржүүлсэн тэнцэл	-2,408.7	-2,654.5	-2,711.5	-2 420.4
ДНБ-д эзлэх хувь	-9.1%	-	-9.9%	-8%

Эх сурвалж: Тухайн оны төсвийн тухай хууль, төсвийн хүрээний мэдэгдэл болон СЯ-ны шилэн данс

Хүснэгт 3. Монгол улсын төсвийн жилд “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр”-ийн салбарын төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа болон бусад байгууллагын төвлөрүүлэх орлого

Төсвийн ерөнхийлөн захирагч	2017 дүн /Батлагдсан/ сая төг	2017 дүн /Тодотгосон/ сая төг	2017 дүн /Төсөл/ сая төг	Төлөвлөлтийн зөрүү
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	131,336.8	161,278.3	199,203.8	өссөн
Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн эргэн төлөлт	76,000.0	52,000.0	115,491.0	өссөн
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	6,738.6	8,880.1	1,414.6	буурсан
Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	48,598.2	100,398.2	82,298.2	буурсан

Эх сурвалж: Тухайн оны төсвийн тухай хууль болон төсвийн хүрээний мэдэгдэл

Хүснэгт 4. Монгол улсын төсвийн жилд “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр”-ийн салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн зарцуулах эрх бүхий төсвийн зарлага

Төсвийн ерөнхийлөн захирагч	2017 дүн /Батлагдсан/ сая төг	2017 оны /эхний 10 сарын бодит гүйцэтгэл/ сая төг	2017 оны /тодотгосон/ сая төг	2018 оны /төсөл/ сая төг	Төлөвлөлтийн зөрүү
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	185,836.1	112,552.9	349,321.2	209,570.4	буурсан
Урсгал зардал	95,146.8	-	99,889.9	108,480.4	өссөн
Дотоод эх үүсвэрээс олгох зээл	21,909.0	-	185,659.0	35,778.7	буурсан
Хөрөнгийн зардал	29,513.0	-	49,384.6	49,418.5	өссөн
Гадаад зээл тусламжаас санхүүжих зардал	39,267.3	-	14,387.7	15,892.8	өссөн

Эх сурвалж: Тухайн оны төсвийн тухай хууль, төсвийн хүрээний мэдэгдэлболон СЯ-ны шилэн данс

Хүснэгт 5. Төсвийн жилд “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр”-ийн салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүн

Хэрэгжүүлэх хөтөлбөр	Хүрэх үр дүн
Мал аж ахуй	
Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээ /сая толгой, давхардсан тоогоор/	56
Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх /1000 толгой мал/	25
Бэлчээрийн ургамал хамгаалал /мянган га/	750
Газар тариалан	
Буудайн үйлдвэрлэлийг дэмжих /мянган тонн/	460
Төмс, хүнсний ногоо /мянган тонн/	269.5
Уриншилсан талбайн хэмжээ /мянган га/	390
Стандартын шаардлага хангасан жимс, жимсгэнэ тариалсан талбай /га/	7000
Хүнсний үйлдвэрлэл	
Үйлдвэрлэлийн аргаар боловсруулсан сүүний хангамж /сая литр/	55
Үйлдвэрлэлийн аргаар боловсруулсан махны хэрэглээг нэмэгдүүлэх /мянган тонн/	15
ХАА, газар тариалангийн бодлого, удирдлага	
УИХ, ЗГ-аас баталсан шийдвэр, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх /тоогоор/	5
ЖДҮ-ийг дэмжих, хөгжүүлэх, ажлын байр олгох	
Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төслийн тоо	100
Зээлийн батлан даалтын сангийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх /Зээлдэгчийн тоо/	100-150

Эх сурвалж: Тухайн оны төсвийн тухай хууль болон төсвийн хүрээний мэдэгдэл

Мөн улсын төсвийн хөрөнгөөр 2018 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн хувьд ХАА-н салбарт зориулан улсын хэмжээнд "Атрын III аян, мах, сүүний анхдугаар аяныг үргэлжлүүлэх хөрөнгө оруулалт", "Мал эмнэлгүүдийн нян судлалын лабораториудын тоног төхөөрөмж", "Орон нутгийн ариутгал, халдваргүйжүүлэлтийн тусгай үйлчилгээний автомашин", төв суурин газарт "Мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн барилга", "Агропаркийн сургалтын төвийн барилга", "Агропаркийн сургалтын тоног төхөөрөмж", "Малын удмын сангийн цогцолборын үйлдвэрлэлийн байгууламжийн тоног

төхөөрөмж", "Инженерийн хийцтэй гүний худаг"-3 газар, "Зөөврийн болон гүний худаг", "Ухаалаг худгийн барилга, тоног төхөөрөмж", "ЖДҮ-ийн барилга, тоног төхөөрөмж"- 2 газар, сум орон нутагт "Малын гаралтай түүхий эдийн цэвэрлэх байгууламж", "Хүнсний иж бүрэн лаборатори", "Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэр"- 6 газар, "Инженерийн хийцтэй гүний худаг"- 3 газар, "Хүнсний ногооны зоорь"- 3 газар, "Зөгийн зоорь", "Услалтын систем", "Малын тарилгын зөөврийн хашаа", "Ахуйн үйлчилгээний төвийн барилга", "ЖДҮ-ийг дэмжих төвийн барилга", "Мал угаах онгоц" зэргийг барьж байгуулахаар төсөвт тусгагдсан байна.

ДҮГНЭЛТ

- Төсвийн орлого бүрдүүлэх, түүний зарцуулалтыг оновчтой болгох, тэдгээрийн хоорондын уялдаа холбоог сайжруулах, төсвөө зөв төлөвлөх асуудал чухлаар тавигдсаар байна. Манай орны хувьд төсвийн алдагдлын савалгаа ихтэй, тогтвортой бус байдал нь эдийн засгийн эрсдэлийг үүсгэж байна. Төсвийн шинэчлэлийн арга хэмжээний үр дүнд Монгол Улсын төсвийн орлого жил бүр өсөж байгаа хэдий ч төсвийг тогтмол алдагдалтай баталж, төсвийн хариуцлага болон төсвийн сахилга бат алдагдаж, улмаар төсвийн тэлэх бодлого барьсаар байна.
- Улсын төсвийн нийт зарлагад хөдөө аж ахуйн салбарын эзлэх хувь олон улсын жишигтэй харьцуулахад доогуур байна.
- Мал аж ахуйн салбарын нэн тулгамдаад байгаа асуудлын нэг болох "Бэлчээрийн доройтол"-ыг шийдэх, гарц шийдэлтөсөвт дорвитой тусгагдаагүй байна. Бэлчээрийг илүүтэй доройтуулж байгаа малын төрөлд илүү татвар ногдуулах

замаар байгаль орчинд эерэг нөлөө үзүүлэх боломжтой. Энэ жилийн төсөвт төв суурин болон хөдөө орон нутагтинженерийн хийцтэй гүний худаг нийтдээ зургааг барихаар төлөвлөсөн байна. Өмнөх жилүүдийн төсвөөс ч худаг гаргах, засварлах ажилд байнга санхүүжилт хийсээр ирсэн. Худаг гаргаснаар бэлчээрийн ачаалал, доройтол багасаж байвал төрөөс санхүүжүүлэх нь зөв зүйтэй зүйл юм. Гэтэл энэ нь заримдаа малын тоог нэмэгдүүлж, бэлчээрийг улам доройтуулах сөрөг шалтгаан болдог. Иймд худаг гаргах нь малчдын бүлгийн бэлчээрийг зөв ашиглах сонирхлыг нэмэгдүүлэх хөшүүрэг болж чадвал бэлчээрт эерэг нөлөө үзүүлэх бөгөөд энэ тохиолдолд төсвөөс санхүүжүүлэх нь эдийн засгийн үндэслэлтэй гэж үзэж болох юм.

- ХАА-н салбарт ихээхэн сөрөг нөлөө үзүүлдэг байгалийн гамшгийн эрсдэл, түүнээс сэргийлэхтэй холбоотой зүйл төсөвт нэг ч тусгагдаагүй байх бөгөөд тухайн цаг үеийн нөхцөл байдалтай уялдан улсын нөөцийн сангаас дэмжлэг

туслалцаа авахаар төлөвлөгддөг нь учир дутагдалтай юм. Хэдийгээр хүн ам, мал сүрэг, эд хөрөнгийг гамшгаас хамгаалах асуудал ЗГ-ын үндсэн чиг үүргийн нэг байдаг ч байгалийн гамшиг ган зудтай үед малчид малаа тэжээхбэлтгэл хангах, хангалттай хэмжээний нөөцтэй болох, цаг агаарын урьдчилсан мэдээ зэргийг харгалзан үзсэн зардал хэмнэх чадвар бүхий стратегитай байх хэрэгтэй.

- Улсын төсвийн хөрөнгөөр 2018 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн хувьд ХАА-н салбарын нэн тэргүүний тулгамдаж буй зарим асуудлыг шийдэхэд зориулагдаж байгаань сайшаалтай. Ялангуяа малын эрүүл мэндийн асуудал юм. Малын эрүүл мэнд нь нэг талаас нийгмийн баялаг тул нийгмийн бүтээгдэхүүн гэж үзэх үндэстэй. Гэхдээ малчид малаа эрүүл байлгах сонирхолтой, малын вакцинжуулалтад хамруулдаг

байх зэрэг нь хамгаас чухал билээ.

- Тус салбарт хэрэгжүүлж буй аливаа төсөл, хөтөлбөрийн төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг тооцож, үр дүнтэй нь нотлогдсон тохиолдолд дараагийн төсвийн төлөвлөлтөд тусгаж байх механизмыг бий болгох хэрэгтэй байна.
- “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр”-ийн салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн зарцуулах эрх бүхий 2018 оны төсвийн зарлагад урсгал зардал хэт их нэмэгдээгүй байгаа хэдий ч хувийн жингийн хувьд 2017 оны тодотгол хийсэн төсвөөс даруй 2 дахин их буюу 50 гаран хувийг эзэлж байгаа нь ихээхэн анхаарал татаж байна. Мөн дотоод эх үүсвэрээс олгох зээлийн хэмжээ өмнөх оноос эрс бага төлөвлөгдсөн нь ХАА-н бүтээгдэхүүний зах зээлийг тэлэх, ажлын байр нэмэгдүүлэх зэрэгт сөрөг нөлөө үзүүлж болзошгүй гэж дүгнэж байна.

НОМ ЗҮЙ

1. Монгол улсын 2017 оны төсвийн баримт бичиг
2. Монгол улсын 2017 оны төсвийн тодотголын баримт бичиг
3. Монгол улсын 2018 оны төсвийн баримт бичиг
4. Монгол Улсын Их Хурлын вэб сайт <http://www.parliament.mn/>
5. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны вэб сайт <http://mofa.gov.mn/>
6. Монгол улсын ХАА-н салбарын суурь судалгааны тайлан, 2017 он
7. Сангийн яамны шилэн дансны цахим хуудас
8. www.1212.mn/

2018 ОНЫ ТӨСӨВ БА БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЛБАРЫН ТУЛГАМДСАН АСУУДЛУУД

Д.Гэрэлмаа

СЭЗИС-ийн Эрдмийн зөвлөлийн гишүүн,

Бизнесийн удирдлагын тэнхмийн профессор, Доктор (Ph.D)

Энэхүү судалгааны өгүүлэлд 2018 оны төсвийн төсөл болон боловсрол, шинжлэх ухааны салбарт тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлохыг зорилгоо. Тухайлбал, боловсрол болон шинжлэх ухаан, технологийн салбарын зорилго, санхүүжилтийн бодлоготой нийцэж байгаа эсэх, санхүүжилт нь суралцагчдын сурлагын амжилтанд нөлөө үзүүлж байгаа эсэх, шинжлэх ухааны салбарын санхүүжилт нь үйлдвэрлэлийн салбарт нэмүү өртөг өндөртэй бүтээгдэхүүн бүтээхсүүр боломжийг бий болгож байгаа зэрэг асуудлуудыг хөндсөнболно.

Түлхүүр үгс: төсөв, санхүүжилтийн бодлого, сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол, дээд боловсрол, шинжлэх ухаан технологи, үйлчилгээний чанар, хүртээмж, тэгш байдал, үр ашиг, үр дүн

Дэлхийн улс орнууд ерөнхий болон дээд боловсролд бусад шатны боловсролоос илүү их анхаарал тавьдаг. Ерөнхий боловсролын үе шатанд хүн насан туршид хэрэглэх онолын болон практик мэдлэг, нийгэмд амьдрах дадал, дээд боловсрол эзэмшихэд шаардлагатай суурь мэдлэгийг олж авдаг. Ерөнхий боловсролын чанараар тухайн орны иргэдийн хөдөлмөрийн бүтээмж тодорхойлогдоно. Бага насны хүүхдийн бие бялдар, оюун ухаан, нийгэмшихүйн хөгжлийг дэмжих, сургуульд бэлтгэхэд сургуулийн өмнөх боловсрол мөн чухал үүрэгтэй. Боловсролын чанар эцэстээ санхүүжилтээс хамаардаг.

1990 оноос өмнө Монгол улсын боловсролын салбар нь улсын төсвийн 25 хувь, ҮНБ-ийн 64 хувийг эзэлсэн хамгийн их хөрөнгө оруулалттай, төрийн онцгой халамжинд байжээ. 1992 онд Монгол улсад зээл тусламж үзүүлэгч гол орон болон ЗХУ(хуучин нэрээр) хямралд орж манай улсын эдийн засагт ихээхэн хүндрэл үүсч, боловсролын салбарын ҮНБ-д эзлэх хувь 33 хувь болтол буурсан байна.

“Монгол улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д Мэдлэгт суурилсан нийгмийг хөгжүүлэх, ур чадвар бүхий иргэдийг төлөвшүүлэх зорилгыг тэргүүн эгнээнд тавьсан байна. Уг зорилгын хүрээнд, нэгт “Хүүхэд бүрийг стандартын шаардлагыг хангасан сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамруулах”, хоёрт “Олон улсад өрсөлдөх чадвартай ерөнхий боловсролын тогтолцоог хөгжүүлж, чанарыг баталгаажуулах”, гуравт “Сургалт-судалгаа үйлдвэрлэлийн түншлэлийг хөгжүүлж, шинжлэх ухаан, технологийн чадавхийг бэхжүүлнэ” гэсэн зорилтуудыг тодорхойлсон байна.


НЭГ. СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛ

Бага насны хүүхдийн боловсролын чанартай үйлчилгээнд хөрөнгө оруулах нь өндөр өртөгтэй стратеги боловч жилд 10 хүртэлх хувийн эргэх ашгийг авчирдаг байна (World Bank, 2016).

Сургуулийн өмнөх боловсрол хөтөлбөрийн хүрээнд 2018 онд төсвийн төсөлд төрийн болон хувийн өмчийн цэцэрлэгт нийт 257,543 суралцагч суралцахаар, хамран сургалтын бохир жин 84.6 хувьд хүргэхээр тооцож нийт 322,065.3 сая төгрөг төсөвлөсөн байгаа нь нийт боловсролын салбарын зардалын 28,3% болж байна.


Манай улсын боловсролын салбарын төсвийн 28 хувь буюу ДНБ-ийн нэг орчим хувийг бага насны хүүхдийн боловсролд зарцуулж байгаа нь бусад дундаж орлоготой орнууд болон ЭЗХАХБ-ын өндөр хөгжилтэй орнуудаас ч их байна. Сургуулийн өмнөх боловсрол (СӨБ)-ын байгууллагуудын тоо нэмэгдэж байгаа нь хувийн хэвшлийн цэцэрлэгүүд олшрох болсонтой холбоотой. СӨБ-ын хамран сургалт байнгын өсөлттэй байгаа ба 2004-2005 оны хичээлийн жилд улсын хэмжээнд 687 цэцэрлэг үйл ажиллагаа явуулж байсан бол 2014-2015 онд 1288 болж 87 хувиар өсчээ.

Зураг 1. Цэцэрлэгийн тоо



СӨБ-ын үйлчилгээ үзүүлж буй нэгжийн тоо өссөн явдал нь хувийн сектороос үүдэлтэй бөгөөд СӨБ дахь хувийн цэцэрлэгийн эзлэх хувийн жин 7 хувиас 35 хувь хүрчээ. Хувийн цэцэрлэгүүдийн 78 хувь нь Улаанбаатар хотод байрладаг. Хувийн цэцэрлэгүүдийн тоо өсч байгаа ч гэсэн СӨБ-ын үйлчилгээний гол ханган нийлүүлэгч улс хэвээрээ байгаа бөгөөд, улсын цэцэрлэгүүдэд сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан хүүхдүүдийн 90 хувь бүртгэлтэй байна.

Зураг 2. Цэцэрлэгийн урсгал зардлын бүтэц



- Цалин, нийгмийн даатгал
- Хоол хүнс
- Халаалт, цахилгаан
- Хувийн хэвшилд олгох дэмжлэг

Эх сурвалж: Боловсролын тойм судалгаа, 2013.

СӨБ-ын хувьд урсгал зардлын хамгийн их хэсгийг цалин хөлс, нийгмийн даатгалын төлбөрүүд (65%), хоол хүнс (18%), халаалт цахилгааны төлбөр (10%) мөн хувийн хэвшилд олгох дэмжлэг багтаж байна (7%).

Монгол орон өргөн дэлгэр газар нутагтай, хахир хүйтэн өвлийн улиралтай учир дулааны зардал нь боловсролын салбарын бүхий л байгууллагуудын их хэмжээний урсгал зардлыг тодорхойлдог. Үүний зэрэгцээ төсвийнхээ багагүй хэсгийг

СӨБ-д хамрагдсан хүүхдүүдийн хоол хүнсэнд зарцуулдаг. Тиймээс хичээл, сургалтын хэрэглэдэхүүн, материалын зардлыг “бусад” гэсэн ангилалд багтааж байна.


Төсвийн хуваарилалт, зарцуулалтаас

харвал ихэнхи хувийг цалин хөлс, хүүхдийн хоол хүнс, халаалт цахилгааны зэрэгт хуваарилж, хичээл сургалтын хэрэглэгдэхүүнд маш бага ноогдож байгаа ажээ.

ХОЁР. ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛ

2018 оны төсвийн жилд ерөнхий боловсрол хөтөлбөрийн хүрээнд нийт 640,653.6 сая төгрөг төсөвлөгдөж, 844 сургууль хамрагдахаар болсон байна. Ирэх 2018 онд нийт урсгал зардлын 56 хувийг ерөнхий боловсролын, 28 хувийг сургуулийн өмнөх боловсролын, 6 хувийг соёл урлагийн, үлдэх 10 хувийг бусад 6 хөтөлбөрт тус тус зарцуулагдахаар, харин дотоод эх үүсвэрээс олгох зээлийн хөрөнгийг 100 хувь дээд боловсролын салбарт зарцуулахаар төсөвлөгдсөн байна

Зураг 3. Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухааны төсөв (урсгал зардал, хувиар)



- Ерөнхий боловсрол
- СӨБ
- Соёл, урлаг
- Бусад 6 хөтөлбөрт

Эх сурвалж: Монгол улсын төсвийн баримт бичиг, 2018

Ерөнхий боловсролын санхүүжилтийн талаарх судалгаануудаас харахад улс орнууд бохир хамрагдалтын жинг 60 хувь хүрсэн байхаар тооцож санхүүжилт

хийхэд ҮНБ-ийн 3,8 хувьтай тэнцүү хэмжээний санхүүжилт хийх хэрэгтэй гэдгийг тооцсон байдаг. Хэрвээ ерөнхий боловсролын бохир хамрагдалтын жинг 80 хувиас 100 хувь хүрсэн байхаар төлөвлөсөн бол ҮНБ-ийн 5,1-с 6,3 хувьтай тэнцүү хэмжээний санхүүжилт хийх хэрэгтэй гэж тооцсон байна (International Institute for Education Planning, 2001). Ерөнхий боловсролд оруулсан хөрөнгө оруулалтын үр өгөөжийн түвшин бусад салбарт оруулсан хөрөнгө оруулалтаас хувийн үр ашиг өндөртэй байдаг гэж Дэлхий Банкны судлаачид тооцоолсон байдаг. Нийт эдийн засгийн ерөнхий боловсролд оруулсан хөрөнгө оруулалт их байх тусам тухайн орны эдийн засгийн өсөлт, ялангуяа экспортын өсөлт өндөр байдаг ажээ (Wood and Ridao-Cano, 1996, Nelson and Pack, 1998).

Бага, дунд боловсролын хамралтын хувийг 2018 оны төсвийн баримт бичигт 2017 онд 95,8 хувь, 2018 онд 95,8 хувь байна гэж тооцсон тул дээрх тооцоололтын дагуу манай улс ДНБ-ийн 6 орчим хувийг боловсролын салбарт зарцуулах шаардлагтай болж байна. Манай улсын хувьд ДНБ-д эзлэх боловсролын салбарын зардлын хэмжээ 1985-1990 онд 12-13,4 хувь, 1991-1993 онуудад 4,8-6,2 хувь байсан бөгөөд 2000 оноос хойш 9,7 хувь болж нэмэгдсэн. Сүүлийн жилүүдэд энэ хэмжээ 5,4-6,5 хувь байсан. Өөрөөр хэлбэл, боловсролын салбарын санхүүжилтийн бодит хэмжээ 1992-2012 онуудад ердөө 2,7 дахин л өссөн байна. 2018 оны төсөвт


4 хувь болгон төсөвлөсөн байгаа нь олон улсын бэнчмарк болох үзүүлэлт ДНБ-ийн 6 хувиас бага, салбарын бодит хэрэгцээг хангаж чадахааргүй санхүүжилт болох нь тодорхой байна.

Rob Greenwald, Larry Hedges, Richard Laine (1994, 1996), Wilson (2002), Guryan (2003), Carnoy (2006) нарын бусад судлаачид "сургуулийн төсвийн зарцуулалт нь сурлагын амжилтанд нөлөөлдөг" гэсэн дүгнэлтэнд хүрсэн байна. Эдгээр судалгааны үр дүнд сургуулийн мөнгийг үр ашигтай, хариуцлагатай зарцуулбал зорилтот бүлгийн хүүхдүүдийн сурлагын амжилт илүү нэмэгдэх, илүү өгөөжтэй байж болох юм гэж үзсэн. Түүнчлэн тэд тэгш байдлыг хангах зорилгоор, үр ашгийг тооцохгүйгээр зардлыг нийтэд нь нэмэгдүүлэх бодлого тэр болгон

амжилтанд хүрэхгүй гэж үзжээ. Тиймээс боловсролын санхүүжилтийн хувьд аль болох бүх суралцагчдыг илүү их амжилт гаргахаар хэрхэн, яаж үр ашигтай зарцуулах гэдэг асуудал чухал байна.

2011-2013 онуудад 21 аймгийн нэг суралцагчид ногдох ерөнхий боловсролын зардал нэмэгдэх тусам суралцагчдын элсэлтийн ерөнхий шалгалт (ЭЕШ)-ын дундаж оноо буурах сөрөг хамаарал ажиглагдаж байна. Хөдөө орон нутгийн сургуулиудын нэг багшид ногдох суралцагчдын тоо Улаанбаатар хотынхоос бага байдаг боловч хөдөөгийн суралцагчдын гол хичээлүүдийн шалгалтын оноо хотын хүүхдүүдийнхээс догуур байгаа нь сурлагын чанар санхүүжилт, зардлын зарцуулалт зэргээс хамааралтай байж болох юм.

Зураг 4. Зардлын үр ашигтай байдлын харьцуулалт




Эх сурвалж: Боловсролын тойм судалгаа, 2013 болон судлаачийн тооцоололт

Монгол улсын боловсролын салбарыг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлд "бүх иргэдэд хүртээмжтэй, чанартай, хэрэгцээнд нийцсэн боловсрол эзэмших тэгш боломж олгогдохгүй байдлыг багасгах явдал" гэж тодорхойлсон. Ерөнхий боловсролын хувийн сургуулиудад амьжиргааны дунд

болон дундаас дээш түвшний өрхийн хүүхдүүд суралцаж байгаа бөгөөд доогуур орлоготой болон хөдөө орон нутагт амьдардаг, мөн ядуу өрхийн хүүхдүүдтэй ижил норматив зардлын санхүүжилтийг нэмж авч боловсрол эзэмшиж байгаа нь тэгш бус байдлыг нэмэгдүүлж

Зураг 5. Зардлын үр ашигтай байдлын харьцуулалт



Эх сурвалж: Боловсролын тойм судалгаа, 2013 болон судлаачийн тооцоололт

байгаа ажээ. Гэтэл сүүлийн жилүүдэд ерөнхий боловсролын санхүүжилтийн бодлого тэгш байдлыг хангах биш, үр дүн хариуцлагад суурилсан хандлагад чиглэсэн ч биш, харин тэгш бус байдлыг аажмаар нэмэгдүүлэх чиглэлд хэрэгжиж байна уу гэж дүгнэж болохоор байна.

Зардлын бүтцийн хувьд ерөнхий боловсролын салбарт зарцуулж буй нийт зардлын 70 орчим хувийг багш нарын цалинд, 10-20 хувийг тогтмол зардалд, тэр дотроо тулш халаалтын зардалд оногдож байна. Харин хичээл практикийн зардал буюу сургалтын хэрэглэдэхүүн, материалын зардалд тун бага хуваарилагдаж байгаа нь ерөнхий

боловсролын сургууль(ЕБС)-ийн зардлын үр ашигтай байдлыг бууруулж байна (Боловсролын тойм судалгаа, 2013).

Олон улсад ерөнхий боловсролыг санхүүжүүлэхдээ тэгшитгэх (нэг хүүхдэд ногдох зардлыг тэгшитгэж тооцох), жинлэгдсэн (хөгжлийн бэрхшээлтэй, авъяаслаг зэрэг ялгаатай бүлгүүдэд нэмэгдүүлсэн зардлыг тооцох), үр дүнд үндэслэсэн (тавивдсан шалгууруудыг хангасан сургууль, дүүрэг илүү санхүүжилт авах) гэсэн санхүүжилтийн стратегиудыг хэрэглэдэг. Манай улс эхний хоёр буюу тэгшитгэсэн, жигнэсэн стратегиудыг хослуулан хэрэглэж байна.

ГУРАВ. ДЭЭД БОЛОВСРОЛ

Мэдлэгт суурилсан нийгмийн үндэс бол дээд боловсрол. Мэдээлэл болон мэдлэг үндсэн нөөц болж байгаа нөхцөлд дээд боловсролын үйлчилгээний хүртээмж, салбар дундын ажил мэргэжилд суралцагсадыг бэлтгэх, хүмүүн капиталын

хөгжлийг хангахын зэрэгцээ глобал асуудлуудыг танин мэдэх чадвар олгодог байхыг чухалчилж байна.

Их сургуулиудын санхүүгийн тогтвортой байдлыг тухайлан авч үзвэл орлого олох сувгуудаа нэмэгдүүлэх, үйл

ажиллагааны төрөл ангиа олшруулах хандлага ажиглагдаж байна. Төрөл бүрийн түвшний, өөрийн гэсэн онцлогтой сургалтын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх нь санхүүжилтийн үндсэн эх үүсвэр болж байна. Захиалгат ЭШ, судалгааны ажлуудыг гүйцэтгэх, судалгаа шинжилгээний ажлын үр дүнгээ борлуулах, фандрайзинг буюу хөрөнгө босгох зэрэг орлого олох боломжит эх үүсвэрүүдийг тодорхойлж болох юм.

Олон улсад дээд боловсролыг зардлаа олон дахин нөхөх хөрөнгө оруулалт, эдийн засгийн нэг салбар хэмээн үзэх хандлага өсөн нэмэгдэж байна. Европын Холбооноос 2008 онд хэвлүүлсэн Брюгелийн тайланд (Bruegel Policybrief, 2008) Европын орнуудад дээд боловсрол эзэмших оюутан жилд дунджаар 8700 евро зарцуулж байхад АНУ-д 36500 евро зардаг. Европт дээрх зардлын 84 хувийг, АНУ-д 47 хувийг нь Засгийн газрын эх үүсвэрээс санхүүжүүлжээ. Жилээс жилд өсөн нэмэгдэж байгаа сургалтын төлбөрийн дарамтыг бууруулахын тулд олон оронд суралцагчдын ирээдүйн орлоготой холбосон зээлийн систем нэвтрүүлсэн байна.

2018 оны төсвийн төсөлд дээд боловсрол хөтөлбөрийн 2017 оны төсвийн хүлээгдэж байгаа гүйцэтгэлийн түвшинд урсгал зардалд 31,873.0 сая төгрөг, дотоод эх үүсвэрээс олгох зээлийн зардалд 96,800.0 сая төгрөг нийт 128,673.0 сая төгрөг тусгасан байна. Дээд боловсрол хөтөлбөрийн хүрээнд улсын төсвийн 4 байгууллагад зардал хуваарилсан бөгөөд үүнээс Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуульд заасны дагуу дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид төрөөс санхүүгийн дэмжлэг олгох үйлчилгээг эрхлэн гүйцэтгэх үндсэн зорилготой Боловсролын зээлийн сангийн 2018 оны төсвийн жилд зарцуулах төсөв 118,916.0 сая төгрөг байхаар тооцжээ.

Оюутны хөгжлийн зээлийн хамрах хүрээг өргөжүүлэх зорилгоор 2018 оны төсвийн жилээс эхлэн зээл олголтын үйлчилгээг Боловсролын зээлийн сан эрхлэн гүйцэтгэхээр тооцож Боловсролын зээлийн сангийн үйл ажиллагааны зардалд 287.0 сая төгрөг төсөвлөсөн байна. Түүнчлэн “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3 дугаар зүйлийн 3.2.20 дэх заалтаар оюутан, суралцагчид олгох буцалтгүй тусламжийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхээр 3.2.21-д өрхийн 3 ба түүнээс дээш хүүхэд нь их, дээд сургуульд зэрэг суралцаж байгаа бол санхүүгийн дэмжлэг үзүүлэхээр заасан, мөн тэтгэмж урамшуулалд хамрагдах хүсэлтэй шаардлага хангасан оюутан суралцагчдын эрэлт, хэрэгцээг үндэслэн төрөөс үзүүлэх буцалтгүй тусламжийн зардалд 12,553.8 сая төгрөг тооцжээ. (Монгол улсын төсөвийн баримт бичиг, 2018).

Дэлхийн өрсөлдөх чадварын 2015-2016 оны тайланд Монгол Улсын өрсөлдөх чадварын түвшинд ахиц гараагүй байна. Манай улс авбал зохих 7 онооноос 3,8 оноо авснаар судалгаанд хамрагдсан 140 орноос 104-г эрэмблэгджээ. Эрүүл мэнд, суурь боловсрол 5,7 оноо, дээд боловсрол мэргэжлийн сургалт 4,5 оноогоор үнэлэгдсэн боловч “Монголд бизнес эрхлэхэд юу саад болдог вэ?” гэсэн асуултанд мэргэшсэн ажиллах хүчний дутагдалтай байдал нь гэж дүгнэгдсэн байгаа нь дээд болон мэргэжлийн сургалтын чанар, хүртээмжийг тухайлан авч үзэх шаардлагатай байгааг илтгэж байна.

Сүүлийн 8 жилийн статистик мэдээллийг авч үзвэл боловсрол, инженер-технологи, эрүүл мэнд-нийгмийн хамгааллын чиглэлээр суралцагчдын тоо тогтмол өсч, мөн хугацаанд эдгээр салбарын нийт суралцагчдын дунд эзлэх хувь боловсролд 0.7, инженер-технологид 0.2, эрүүл мэнд-

нийгмийн хамгааллын салбарын эзлэх хувь 3.9 пунктээр буурсан байгаа нь "Монголын боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө"-ний "Инженер, технологи, байгалийн шинжлэл, багш,


ХАА мэргэжлээр суралцагчдыг дэмжих" гэсэн заалт тодорхой хэмжээнд хэрэгжиж байгаа болон салбарын зүгээс эрэлт бий болсонтой холбоотой (БСШУС-ны яамны статистик мэдээ, 2016).

Хүснэгт 1. Төгсөгчид (боловсролын зэргээр)

	Дипломын дээд	Бакалавр	Магистр	Доктор	Төгсөгчид
2011-2012	918	33,106	3,626	99	37,749
2012-2013	1,181	32,234	3,697	131	37,243
2013-2014	259	29,477	3,996	118	33,850
2014-2015	93	29,728	5,254	106	35,181
2015-2016	231	30,663	4,859	136	35,889

Эх сурвалж: БСШУС-ны яамны статистик мэдээ, 2016.

Зураг 6. Их дээд сургууль төгсөгчид, мэргэжлээр %



Эх сурвалж: БСШУС-ны яамны статистик мэдээ, 2016.

Төгсөгчдийн мэдээллийг өмнөх хоёр хичээлийн жилтэй харьцуулбал: инженер, технологи, барилга-архитектурын салбарын эзлэх хувь 12,7-15,4 хувь хүртэл өсчээ. Гэхдээ урлаг хүмүүнлэг, нийгэм эдийн засаг, мэдээлэл зүй, бизнес удирдлага, эрхзүйн салбараар төгсөгчдийн нийт дүнд эзлэх хувь 44,3-45,4 буюу зонхилох хэсэг хэвээр байна. Төгсөгчдийн ажил эрхлэлтийн тухайлан авч үзвэл 2015-2016 оны хичээлийн жилийн нийт төгсөгчдийн 30.9 хувь нь төгссөн даруйдаа ажлын байртай болсон гэсэн статистик байна, тус үзүүлэлтийг өнгөрсөн хичээлийн жилийн тайлангийн


өгөгдөлтэй харьцуулахад 1.9 пунктээр буурчээ. Докторантур төгсөгчдийн 98.5%, магистрантур төгсөгчдийн 86.7 хувь нь ажлын байртай хүмүүс байгаа бол бакалаврын зэргээр төгсөгчдийн ажил эрхлэлтийн байдал 21.8 орчим хувьтай байгаа нь дээд боловсролын байгууллагын чадавхи, сургалтын чанартай холбоотой гэж дүгнэхээр байна. Төрийн өмчийн, төсвөөс санхүүжилт авдаг Их дээд сургуулиудын хувьд төгсөгчдийн ажил эрхлэлтийн түвшин судлаачийн зүгээс сонирхож үзсэн боловч мэдээлэл хомс байлаа.

Монгол Улсын Их Хурлаас 1995 оны 6

дугаар сарын 13-нд баталсан Боловсролын тухай багц хуулинд анх удаа боловсролын магадлан итгэмжлэлийн эрх зүйн үндсийг тусгасан. Дээд болон мэргэжлийн боловсролын чанарын баталгаажуулалтын зорилго бол Монголын дээд, мэргэжлийн боловсролын системийн байнгын үнэлгээ шинжилгээнд тулгуурлан боловсролын үйлчилгээний чанарыг сайжруулах, үечилсэн магадлан итгэмжлэл хийх замаар сургууль, хөтөлбөрийн нэр хүндийг албан ёсоор хүлээн зөвшөөрөхөд

чиглэгдэнэ (Боловсролын магадлан итгэмжлэх Үндэсний зөвлөлийн дүрэм, 2016). Магадлан итгэмжлэл авсан дээд боловсролын байгууллагын тоо харьцангуй тогтвортой байгаа ч Их дээд сургууль төгсөгчдийн мэдлэг, ур чадвар ажлын байрны шаардлагыг төдийлөн хангаж чадахгүй байгааг бизнес эрхлэгчдийн үнэлгээ болон төгсөгчдийн ажил эрхлэлтийн статистикаас харагдаж байна (Дэлхийн өрсөлдөх чадварын тайлан, 2016).

Зураг 7. Магадлан итгэмжлэгдсэн сургуулиуд, тоо



Эх сурвалж: БСШУС-ны яамны статистик мэдээ, 2016.


Дээд боловсролын чанарыг дээшлүүлэхэд олон арга зам бий. Тухайлбал төрөөс санхүүжилт авч буй их, дээд сургуулиудыг хөтөлбөрийн чанар, эрдэм шинжилгээний ажлын үр дүн, сургалтын орчин зэргээр зэрэглэн, эрэмбэ тогтоож, өрсөлдөөнт санхүүжилтийн зарчмыг нэвтрүүлэх, их, дээд сургуулиудын багш нарын мэдлэг, мэргэжлийн ур чадварыг байнга нэмэгдүүлэх боломжийг бий болгон, ур

чадварын түвшин тогтоох зэрэг байж болно. Мөн төгсөгч оюутнууд тухайн эзэмшсэн мэргэжлээр хэр хурдан ажлын байртай болж байгаа, мэргэжил эзэмших боловсролын зардлыг ажилд орсноос хойш хэдий хугацаанд эргэн олдог зэрэг статистик мэдээллийн сан үүсгэн олон нийтэд хүргэх нь оюутнууд сурах сургууль, эзэмших мэргэжлээ зөв сонгоход дэмжлэг болох нь тодорхой юм.

ДӨРӨВ. ШИНЖЛЭХ УХААН,ТЕХНОЛОГИЙН САЛБАР.

Сүүлийн 2 жилийн дунджаар шинжлэх ухааны нийт санхүүжилт 32.2 тэрбум, түүний дотор эрдэм шинжилгээний ажлын зардал 9.2 тэрбум төгрөгт хүрч энэ нь ДНБ-ний 0,12 хувьтай тэнцэж байна. Олон улсын жишиг үнэлгээгээр дээрх үзүүлэлт 0.4 хувиас бага бол тухайн орны хувьд шинжлэх ухаан нийгэм соёлын үзэгдлийн төдий байр суурьтай, 0,8 хувьд хүрч байвал нийгэм эдийн засгийн хөгжилд нөлөөлж эхлэх хэмжээний, 1.5 орчим бол тухайн орны хөгжилд мэдэгдэхүйц нөлөөтэй гэж үздэг.

ШУТ-ийн салбарын хөгжлийн ерөнхий хандлагыг харвал:дэлхийн тогтвортой хөгжлийг хангах замаар амьдралын чанарыг сайжруулах, ядуурлыг бууруулах,шинжлэх ухаан, үйлдвэрлэл бизнестэй холбогдож бүтээгдэхүүний үнэ өртөгт шинжлэх ухааныг илүү их шингээх,шинжлэх ухааныг жирийн хүмүүст ойртуулах, хүн төрөлхтөний нийтлэг соёлын нэг хэлбэршил болгон улс үндэстнээрээ шинжлэх ухаанжих зэрэг багц асуудалд чиглэгдэж байна(Ж. Мижиддорж, 2014).

Зураг 8. Шинжлэх ухаан, технологийн салбарын санхүүжилт

Эх сурвалж: Шинжлэх ухааны салбарын өнөөгийн байдал, тулгамсан асуудлууд, Д. Рэгдэл 2014

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын багцын 2018 оны төсвийн төсөлд шинжлэх ухаан, технологи хөтөлбөрт 35,723.4 сая төгрөг төсөвлөжээ. ЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт ШУ-ны эрдэм, шинжилгээнд төсвөөс зарцуулж байгаа зардлыг 3 дахин нэмэгдүүлнэ гэж заасныг хэрэгжүүлэх зорилгоор 2017 оны төсвийн тодотголын түвшингээс 2,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж тусгасан ажээ. Өндөр хөгжилтэй орнуудын шинжлэх ухааны салбарт зарцуулж буй хөрөнгийн хэмжээ дунджаар ДНБ-ийн 3 хувийг эзэлдэг бол манай улсын хувьд сүүлийн жилүүдэд ердөө 0,12 хувьд хэлбэлзэж байгаа ба дэлхий дундаж 1,1 хувь буйг анхааралдаа авах шаардлагатай байна. Нэг ногдох ДНБ болон шинжлэх ухаанд зарцуулж байгаа зардлын хэмжээнд эерэг

хамаарал байгааг олон улсын жишиг харуулж байна.

Манай улс онолын суурь болон хавсарга судалгаанд нийт судалгааны ажлын төсвийн 90-ээс дээш хувийг зарцуулж байгаа нь санхүүжилтийн бүтэц оновчгүй байгааг илтгэнэ. Хөгжилтэй орнууд туршилт, боловсруулалтын ажилд нийт судалгаа, шинжилгээний ажлын төсвийн 50 дээш хувийг зарцуулж байна.

Япон Улсын "эдийн засгийн гайхамшиг"-ийг бүтээж байсан онуудын судалгааны ажлын зардлын бүтцийг авч үзвэл 15 жилийн дотор судалгааны ажлын санхүүжилтийн бүтцийг эдийн засагт эерэг нөлөө үзүүлэхээр шилжүүлж чадсан байна. Буурай хөгжилтэй орнуудад шинжлэх ухааны салбарын санхүүжилтийг ихэвчлэн төрөөс дааж

Хүснэгт 2. Судалгааны ажлын зардлын бүтэц (төрлөөр, %)

Улс	Суурь судалгаа	Хэрэглээний судалгаа	Туршилт, боловсруулалт	Бусад
Израиль	16	5	80	-
БНХАУ	6	19	76	-
Япон	12	21	67	-
Өмнөд Солонгос	16	20	64	-
Дани	16	26	58	-
Англи	9	40	51	-
Сингапур	19	31	50	-
Украин	23	17	48	11
Норвеги	19	35	46	-
Австри	18	35	46	2
Тайланд	16	40	45	-
Чех	28	27	45	-
Польш	30	18	31	22
Латви	27	43	31	-
Литва	34	37	29	-
Азербайжан	38	43	16	3
Монгол	33	48	4	14

Эх сурвалж: UNESCO, Шинжлэх ухааны салбарын санхүүжилт, Ц. Баярхүү, 2013


байгаа бол өндөр хөгжилтэй орнуудад нийт төсвийн 4:1 буюу 80 орчим хувийг хувийн хэвшил санхүүжүүлж байна. Манай улсад энэ харьцаа 19:1. Иймд хувийн хэвшлийг шинжлэх ухааны салбарын үйл ажиллагаа, санхүүжилтэнд идэвхтэй татан оролцуулах нь чухал байна. Хувийн хэвшлийг ШУ-ны салбарт өргөнөөр татан оролцуулахын тулд хууль, эрхзүйн тодорхой зохицуулалтыг хийх шаардлага байна.

Санхүүжилтийн эх үүсвэр хүрэлцээгүй, түүний хуваарилалт оновчтой бус, дэлхий жишигт нийцсэн судалгааны лабораторууд цөөн, эрдэм шинжилгээний ажлын үр дүн үйлдвэрлэл бизнесийн салбарт нэвчилт муутай, судалгаа шинжилгээний байгууллага их дээд сургуулиудын уялдаа

холбоо сул зэрэг олон бэрхшээлээс болж шинжлэх ухаан технологийн салбарын нөхцөл байдал, нийгэмд хуримтлагдсан олон асуудлуудыг шийдвэрлэж чадахгүй хүрчээ.

Сүүлийн 20 гаруй жил ШУ-ны салбарт төрөөс баримталж байгаа "мөнгөтэй болохоороо дэмжих" амиа аргацаасан бодлогоос болж тухай салбарын чадавхи улсын хөгжилд бодит хувь нэмэр оруулах түвшин хүртлээ хөгжиж чадаагүй. Төр, хувийн хэвшил болон ШУ-ны салбарын хамтын ажиллагаа сул, төрөөс үзүүлэх институцийн болон санхүү, техникийн дэмжлэг хангалтгүй, салбарын нийт чадавхи, дэд бүтэц сул. Иймээс төсөв санхүү, хөрөнгө оруулалтын оновчтой тогтолцоо бүрдүүлэх шаардлагатай байна.

Зураг 9. Япон улсын ЭШ-ийн ажлын зардлын бүтэц (%)



Эх сурвалж: UNESCO, Шинжлэх ухааны салбарын санхүүжилт, Ц. Баярхүү, 2013

Үүнд, судалгааны ажлын санхүүжилтийг олон эх үүсвэртэй болгох, санхүүжилтийн нийт хэмжээг ойрын 3 жилд ДНБ-ийн 0,5 хувьд хүргэх, ШУ-ны үйл ажиллагааг санхүүжүүлсэн хувь хэмжээгээр бизнесийн байгууллагад татварын хөнгөлөлт үзүүлэх, хөрөнгө оруулалтыг

нэмэгдүүлэх замаар лабораториудын чадамжийг сайжруулах, шинжлэх ухаан технологийн хуульд заасан гадаадын зээл, тусламжийн 1-ээс доошгүй хувийг тус салбарт тогтвортой тууштай зарцуулах, ЭШ-ийн байгууллагуудын бие даасан байдлыг хангах.

ДҮГНЭЛТ

- Боловсролын санхүүжилтийн бодлого хэрэгжихдээ тэгш байдлыг хангахад биш, тэгш бус байдлыг аажмаар нэмэгдүүлж болзошгүй гэж дүгнэж болохоор байна.
- Боловсролын санхүүжилтийн гол учирч буй бэрхшээл бол алслагдсан сумын цэцэрлэг, сургуулиудад чанартай боловсрол өндөр зардалтай болдог явдал юм.
- ЕБ-ийн нэг суралцагчдад ногдох боловсролын зардал нэмэгдэх тусам ЭИШ-ын дундаж оноо буурах сөрөг хамаарал ажиглагдаж байгаа нь төсвийн санхүүжилтийн үр дүн, үр ашигт байдалд тун тааруу байгааг илэрхийлж байна.
- Боловсролын салбарт ашиглагдаж байгаа санхүүжилтийн зарчим нь

- нийлүүлэлт болон эрэлтэд суурилсан хэлбэрүүдийн багтаасан ажээ.
- ЕБ-ийн сургуулийн нийт зардлын 70 орчим хувийг багш нарын цалинд (багшийн дундаж цалин 600,0 мянган төгрөг), тогтмол зардал нийт зардлын 10-20 хувийг, тэр дотроо түлш халаалтын зардалд 75-77,6 хувийг зарцуулж байна. Хичээл практикийн зардалд тун ч бага хувь ногдож байгаа нь зардлын үр ашигтай байдлыг бууруулж байна.
- ДБ-ийн санхүүжилтийн бодлого нь салбарын зорилгоо ч тэр, үйлчилгээний хүртээмж чанарын асуудлыгч тэр дэмжсэн чиглэлтэй хараахан болж чадаагүй байна.
- ДББ-ийн чанарын өрсөлдөөнийг урамшуулах механизм тогтоогүй, үүнд: чанарыг тодорхойлох, үнэлэх талуудын

харилцаа, оролцоо хэвшээгүй гэж хэлж болохоор байна.

- Шинжлэх ухаан, технологийн салбарын төсөв санхүү, хөрөнгө оруулалтын оновчтой тогтолцоог бүрдүүлэх нь тулгамдсан асуудал болжээ.
- Гадаадын бусад оронтой харьцуулсан судалгаанаас үзэхэд манай улс шинжлэх

ухаан, технологийн үйл ажиллагааг зөвхөн төрөөс санхүүжүүлдэг дүр зураг харагдаж байна. Судалгаа шинжилгээний ажлын санхүүжилтийн олон эх үүсвэртэй болгож, салбарын үйл ажилаагаа, санхүүжилтэд хувийн хэвшлийг идэвхитэй татан оролцуулах нь тэргүүлэх ач холбоотой юм.

НОМ ЗҮЙ

1. Banzragch, O. 2012. "Educational and the labor market in Central Asia." Ulaanbaatar.
2. Behrman, Jere, Lia Fernald, and Patrice Engle. 2013. «Preschool Programs in Developing Countries.» P. Glewwe, Education Policy in Developing Countries. Chicago: University of Chicago Press.
3. Berlinski, Samuel, and Norbert Schady, eds. The Early Years: Child Well-being and the Role of Public Policy. Palgrave Macmillan, 2015.
4. Carneiro, P.M., and J.J. Heckman. 2003. "Human Capital Policy" in J. Heckman and A. Krueger (eds) Inequality in America: What Role for Human Capital Policy? MIT Press, Cambridge.
5. Case, Anne, and Christina Paxson. 2008. "Stature and Status: Height, Ability, and Labor Market Outcomes." Journal of Political Economy 116(3): 499-532.
6. Cunha, Flavio, James Heckman and Lance Lochner. 2006. "Interpreting the Evidence on Life Cycle Skill Formation." In Eric Hanushek and Finis Welch, eds., Handbook of the Economics of Education. North Holland: Amsterdam, pp. 697–812.
7. Currie, J. and D. Thomas. 1999. "Early Test Scores, Socioeconomic Status and Future Outcomes." NBER Working Paper 6943. National Bureau of Economic Research, Cambridge, MA.
8. International Institute for Educational Planning. (2001). "Financing secondary education in Developing countries". France: United Nations Educational, Scientific and Cultural Organization.
9. OECD. 2011. "Education at a Glance 2015: OECD indicators", OECD Publishing
10. World Bank. 2005. "Expanding opportunities and building competencies for young people: new agenda for secondary education", Washington, D.C.
11. World Bank. 2012. "World development indicators".
12. Дэлхийн Банк. 2016. "Монгол улсын сургуулийн өмнөх боловсрол: үйлчилгээний хүртээмж, чанар ба хүүхдийн хөгжлийн үр дүн", Улаанбаатар.
13. Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг, 2013, "Боловсролын салбарын тойм судлагаа", Улаанбаатар.
14. Ц. Баярхүү, 2013, "Шинжлэх ухааны салбарын санхүүжилт", Шинжлэх ухаан, технологи, инновацийн бодлогын шинэчлэл үндэсний чуулган, Улаанбаатар.
15. Ж. Мижиддорж, 2014, "Шинжлэх ухаан технологийн өнөөгийн байдал, тургамдсан асуудлууд", Өдрийн сонин, Улаанбаатар.
16. Д. Рэгдэл, 2014, "Шинжлэх ухааны салбар: тулгамдсан асуудлууд", Улаанбаатар.

МОНГОЛ УЛСЫН ТӨСӨВ БА ДЭД БҮТЭЦ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТУЛГАМДСАН АСУУДЛУУД

Ж.Дэлгэрсайхан

Санхүүгийн удирдлагын тэнхимийн дэд профессор

Судалгааны зорилго, хамрах хүрээ. Монгол улсын төсвийн хөрөнгө оруулалтын байдал, үр дүнд дүгнэлт өгөх, хөрөнгө оруулалтын бодлого ямар байгаа талаар дүгнэх, төсвийн хөрөнгө оруулалтын үр дүнг төсвийн зорилготой уялдуулан тайлбарлах нь судалгааны зорилго байна.

Үүний тулд Монгол улсын төсвийн төлөвлөлт, хөрөнгө оруулалтын талаар онол, эрх зүйн орчин, төсвийн тоон мэдээлэлд үндэслэн шинжилгээ хийх түүний үр дүнд дүгнэлт өгөх зарчмаар хөрөнгө оруулалтын өнөөгийн байдлыг тодорхойлж дүгнэлт санал зөвлөмж өгнө.

Түлхүүр үгс: Төсөв, Төсвийн төлөвлөлт, Төсвийн хөрөнгө оруулалт, ДНБ, үр ашиг, ядуурал

МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Монгол улсын хувьд төсвийн хөрөнгө оруулалт нь сүүлийн жилүүдэд их хэмжээгээр нэмэгдэж байгаа бөгөөд үүний үр дүнд нийгэм, эдийн засгийн ямар эерэг үр дүнг бий болгосон нь төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын хамгийн чухал зорилго юм. Тэгвэл төсвийн хөрөнгө оруулалтын асуудал нь

Хүснэгт 1. Судалгааны ажлын зардлын бүтэц (төрлөөр, %)

	ТЗ батлагдсан	ТЗ гүйцэтгэл	Орлого батлагдсан	Орлого Гүйцэтгэл	Төсвийн алдагдал
2006	935,455.70	1,237,008.00	849,343.40	1,360,409.80	123,401.80
2007	1,447,854.30	1,747,310.50	1,295,599.70	1,880,488.90	133,178.40
2008	2,568,625.70	2,466,774.40	2,403,699.20	2,170,370.00	-296,404.40
2009	2,619,524.80	2,336,629.70	2,223,816.50	1,993,995.60	-342,634.10
2010	2,785,393.70	3,080,685.10	2,426,823.70	3,122,464.20	41,779.10
2011	4,084,114.40	4,997,039.90	3,304,614.90	4,227,178.10	-769,861.80
2012	6,309,450.00	6,017,800.50	5,825,663.30	4,881,171.90	-1,136,628.60
2013	7,449,265.80	6,164,685.30	7,088,333.70	5,940,066.70	-224,618.60
2014	7,293,848.60	7,144,567.98	6,883,889.00	6,276,608.84	-867,959.14
2015	7,599,156.40	7,137,973.90	7,159,971.20	5,981,064.00	-1,156,909.90
2016	7,954,413.00	9,519,906.00	7,013,898.60	5,852,075.80	-3,667,830.20

Эх сурвалж: Судлаачийн нэгтгэл, 2017

энэ үүргийг гүйцэтгэх нэг гол тулгуур болох ёстой бөгөөд хөгжиж буй орны хувьд хөрөнгө оруулалт нь оновчтой бөгөөд үр ашигтай байх шаардлагатай юм. Энэ үүднээс төсвийн төсвийн хөрөнгө оруулалтыг эрх зүйн, хэрэгжилтийн хувьд судалж нийгэм, эдийн засгийн үр ашигтай уялдуулан тайлбарлахыг зорилоо.

Монгол улсын төсөв сүүлийн жилүүдэд өндөр өсөлттэй байгаа бөгөөд төсвийн алдагдал, нэмэгдсээр байгаа бөгөөд 2018 оны төсөв ч гэсэн өндөр алдагдалтай байх хандлагатай байна. 2016 он хүртэлх сүүлийн 5 жилийн төсвийн алдагдал 7 их наяд төгрөг хүрсэн нь тэр хэмжээгээр төсвийн бодлого хэрэгжих боломжид сөргөөр нөлөөлж байна.

Дээрх хүснэгтээс харахад төсвийн хэмжээ нэмэгдэхийн хэрээр төсвийн алдагдал нэмэгдэж байгаа бөгөөд төсвийн хууль тогтоомжид өөрчлөлт оруулах замаар төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн шаардлагуудыг биелүүлж байна. Товчхон хэлэхэд төсвийн удирдлага хангалтгүй байгаа бөгөөд үүнийг төсвийн тодотгол¹, төсвийн орлого зардлын биелэлт, төсвийн алдагдал зэрэг үзүүлэлтээс харагдаж байна.²

Төсвийн хүрээний үзүүлэлтүүд нь эдийн засгийн нөхцөл байдалтай ямар хамааралтай байгааг харах зорилгоор төсвийн үзүүлэлтүүд болон ДНБ-ний хэмжээ, тэдгээрийн өөрчлөлтийн хувийг харья:

Хүснэгт 2. Дотоодын нийт бүтээгдэхүүн ба төсвийн орлого зардал

	ДНБ	ТЗ батлагдсан	ТЗ гүйцэтгэл	Орлого батлагдсан	Орлого Гүйцэтгэл
2006	4,027,558.60	935,455.70	1,237,008.00	849,343.40	1,360,409.80
2007	4,956,647.20	1,447,854.30	1,747,310.50	1,295,599.70	1,880,488.90
2008	6,555,569.40	2,568,625.70	2,466,774.40	2,403,699.20	2,170,370.00
2009	6,590,637.10	2,619,524.80	2,336,629.70	2,223,816.50	1,993,995.60
2010	9,756,588.40	2,785,393.70	3,080,685.10	2,426,823.70	3,122,464.20
2011	13,173,763.40	4,084,114.40	4,997,039.90	3,304,614.90	4,227,178.10
2012	16,688,419.60	6,309,450.00	6,017,800.50	5,825,663.30	4,881,171.90
2013	19,174,242.60	7,449,265.80	6,164,685.30	7,088,333.70	5,940,066.70
2014	22,227,054.30	7,293,848.60	7,144,567.98	6,883,889.00	6,276,608.84
2015	23,150,385.60	7,599,156.40	7,137,973.90	7,159,971.20	5,981,064.00
2016	23,935,853.70	7,954,413.00	9,519,906.00	7,013,898.60	5,852,075.80

Эх сурвалж: Судлаачийн нэгтгэл, 2017

Монгол улсын төсөв нь ДНБ-ийг дагаж өсч ирсэн байдалтай харагдаж байгаа боловч хамаарлын хувьд жил бүр харилцан адилгүй өсч байсан. Тухайлбал 2007 онд ДНБ нэрлэсэн дүнгээр 23 хувь

өсч байхад төсвийн зардал 41.18, 2011 онд ДНБ 35 хувь, төсвийн зардал 62 хувь өсч байсан бол 2013 онд ДНБ 14.9 хувь, төсвийн зардал 2.44 хувиар өсч байсан байна.

¹ 2006 – 2016 онд Монгол улс төсвийн тодотгол хийгээгүй жил байхгүй бөгөөд ихэнхдээ 2009 онд 3 удаа тодотгол хийж байжээ.

² Төсвийн орлогын гүйцэтгэл 2015, 2016 онд 1 их наяд төгрөгөөс давсан хэмжээгээр тасалдсан нь төсвийн төлөвлөлт муу байгааг харуулах нэгэн үзүүлэлт юм.

ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, БА ҮР ДҮН

Төсвийн хөрөнгө оруулалтын хэмжээ 2006-2016 онд тасралтгүй өсч ирсэн бөгөөд энэ хугацаанд 13.12 дахин өссөн байна. Гэтэл энэ хугацаанд ДНБ нэрлэсэн

дүнгээр 5.4 дахин өссөн байдаг. ДНБ-ний өсөлтөөс хурдтай өссөн энэ хөрөнгө оруулалтад эдгээр жилүүдэд нийт 11.9³ их наяд төгрөгийг зарцуулсан байна.

Хүснэгт 3. Төсвийн хөрөнгө оруулалт, орлого зардал

	Зардал гүйцэтгэл	Зардал гүйцэтгэл өсөлтийн хувь	Хөрөнгийн зардал	Хөрөнгийн зардал өсөлтийн хувь	Орлого Гүйцэтгэл	Орлого Гүйцэтгэл өсөлтийн хувь
2006	1,237,008.00		175,671.5		1,360,409.80	
2007	1,747,310.50	41.25	299,498.3	70.49	1,880,488.90	38.23
2008	2,466,774.40	41.18	624,389.8	108.48	2,170,370.00	15.42
2009	2,336,629.70	-5.28	460,564.5	-26.24	1,993,995.60	-8.13
2010	3,080,685.10	31.84	591,039.5	28.33	3,122,464.20	56.59
2011	4,997,039.90	62.21	1,280,919.6	116.72	4,227,178.10	35.38
2012	6,017,800.50	20.43	1,525,357.6	19.08	4,881,171.90	15.47
2013	6,164,685.30	2.44	1,490,741.7	-2.27	5,940,066.70	21.69
2014	7,144,567.98	15.90	1,739,895.8	16.71	6,276,608.84	5.67
2015	7,137,973.90	-0.09	1,396,704.6	-19.72	5,981,064.00	-4.71
2016	9,519,906.00	33.37	2,304,564.4	65.00	5,852,075.80	-2.16

Эх сурвалж: Судлаачийн нэгтгэл, 2017⁴

Төсвийн хөрөнгө оруулалтын хэмжээ төсвийн орлого, зардлын өсөлтөөс ч өндөр байгаа бөгөөд энэ хөрөнгө оруулалтын үр дүн юу байсан, эдгээр хөрөнгө оруулалтууд төсвийн хууль болон бусад эрх зүйн актын хүрээнд тавигдсан шаардлагад нийцсэн эсэх нь эргэлзээтэй юм.


Тэгвэл төсвийн хөрөнгө ДНБ болон эдийн засгийн гол салбаруудын өсөлтэй хэрхэн уялдаж ирснийг харах зорилгоор дараах графикайг (Зураг 1) оруулав.

Энэ хугацаанд төсвийн хөрөнгө оруулалт 13.12 дахин өссөн нь төсвийн үзүүлэлтээс гадна ДНБ, уул уурхай, ХАА-н салбарын өсөлтөөс өндөр байгаа бөгөөд энэ өсөлтийн дийлэнхи хувийг хөрөнгө оруулалтын зардал эзэлж байгаа юм. 2006 онд хөрөнгийн зардалд хөрөнгө оруулалтын эзлэх хувь 76 хувь байсан бол 2014 онд 82.5 хувь болж өссөн байна. Үлдсэн нь их засвар, геологи хайгуулалт гэх мэт хөрөнгийн бусад хэлбэрээр зарцуулагдсан байна.

³ Үндэсний статистикийн хорооны гаргасан тухайн оны нэрлэсэн ДНБ-ний хэмжээгээр тооцов.

⁴ Тухайн мэдээллийг ҮСХ-ны 2006-2016 оны тоон мэдээлэл болон СЯ-ны төсвийн мэдээллийг ашиглан боловсруулсан.

Зураг 1. Төсөв эдийн засгийн үзүүлэлтүүдийн өөрчлөлт



Эх сурвалж: Судлаачийн нэгтгэл, 2017

ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ БА НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Төсвийн онолын хүрээнд болон Монгол улсын төсвийн тухай хууль бусад эрх зүйн актын хүрээнд төсөв нь нөөцийг

зөв удирдах, нийгэм, эдийн засгийн үр ашигтай байх зэрэг шалгуурын хүрээнд төсвийн өсөлт хөрөнгийн зардалын өсөлтийн үр дүн ямар байсан талаар

Хүснэгт 4. Төсвийн хөрөнгө оруулалт, нийгмийн үзүүлэлтүүд


	Хөрөнгийн зардал өсөлтийн хувь	1 хүнд ногдох ДНБ /өсөлтийн хувь/	Өрхийн орлого /өсөлтийн хувь/	Өрхийн зарлага /өсөлтийн хувь/
2007	70.49	28.68	31.72	28.19
2008	108.48	28.12	37.89	25.63
2009	-26.24	1.20	10.71	19.09
2010	28.33	32.19	11.30	2.88
2011	116.72	22.53	28.01	28.25
2012	19.08	30.81	42.97	42.06
2013	-2.27	16.81	16.98	17.24
2014	16.71	-0.31	12.60	11.95
2015	-19.72	-9.17	-3.04	-1.09
2016	65.00	-8.55	-9.84	-9.26

Эх сурвалж: Судлаачийн нэгтгэл, 2017

зарим харьцуулалтыг хийж үзье. Тухайн үзүүлэлтээс харахад төсвийн хөрөнгийн зардал нь нэг хүнд ногдох

ДНБ болон өрхийн орлого зардлаас ихэнх жилд өндөр өсөлттэй, зарим жилд 4 дахин ихээр нэмэгдсэн байна үүнийг дүрслэлээр

Зураг 2. Төсвийн хөрөнгийн зардал ба өрхийн орлого, зардал



харуулбал дараах байдалтай байна. Төсвийн хөрөнгийн зардал нь нэг хүнд ногдох ДНБ болон өрхийн орлого

зардалтай уялдаа хамаарал багатай байгаа нь дээрх дүрслэлээс харагдаж байгаа бөгөөд дараах хамааралтай байна.

Хүснэгт 5. Төсвийн хөрөнгө оруулалт өрхийн орлого зардлын хамаарал


Хөрөнгийн зардал /өсөлтийн хувь/	1 хүнд ногдох ДНБ /өсөлтийн хувь/	Өрхийн орлого /өсөлтийн хувь/	Өрхийн зарлага /өсөлтийн хувь/
Корреляцийн коэф	0.44608569	0.42493779	0.255908

Төсвийн хөрөнгө оруулалт нь макро эдийн засгийн үзүүлэлтүүдээс гадна өрхийн эдийн засгийн үзүүлэлтүүдээс хамаарал багатай байгаа нь төсвийн хөрөнгө оруулалтын асуудлыг онол эрх зүйн хүрээний шалгуурын хүрээнд хийдэг байдлыг үгүйсгэж байна.


Тэгвэл энэ хугацаанд төсвийн хөрөнгийн зардал болон дээрх үзүүлэлтүүдийн өөрчлөлтийг авч үзье. (Зураг 3)

Хөрөнгийн зардал нь Монгол улсын эдийн засгийн гол үзүүлэлт болон нэг хүнд ногдох ДНБ, өрхийн амжиргааны үзүүлэлт өрхийн орлого, зардаас хэд дахин өндөр өссөн нь төсвийн хөрөнгө оруулалтын бодлого оновчтой хэрэгжсэн эсэхийг дахин нягтлах шаардлагыг бий болгож байна. Иймээс төсвийн хөрөнгө оруулалтыг нийгмийн үзүүлэлтүүдтэй харьцуулан авч үзвэл дараах байдалтай

Зураг 3. Хөрөнгийн зардал ба өрхийн орлого, зардал



Зураг 4. Төсвийн хөрөнгө оруулалт, нийгмийн үзүүлэлтүүд



Эх сурвалж: Судлаачийн нэгтгэл, 2017

харагдаж байна. (Зураг 4)
Төсвийн хөрөнгө оруулалт нэмэгдсээр байгаа боловч эдийн засгийн

үзүүлэлтүүдтэй уялдаа холбоо бага бөгөөд нийгэм, эдийн засгийн үр ашиг гаргаж байгаа хэлэхэд хүндрэлтэй байна.

2017-2018 ОНЫ ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

2017 онд батлагдсан төсвийн хөрөнгө оруулалтын хэмжээ 1,579811, 9 сарын гүйцэтгэл 806 тэрбум төгрөг байна. 2018 оны одоо хэлэлцэж буй төсвийн төслийн 7 зүйлд "Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2018 оны төсвийн жилд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн дүнг 625,281.9 сая төгрөгөөр баталсугай." 8-р зүйлд "Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2018 онд санхүүжүүлэх «Барих-Шилжүүлэх» концессын төрлөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн эргэн төлөлтийн дүнг 82,884.4 сая төгрөгөөр баталсугай" (МУЗГ, 2017) Мөн төсвийн баримт бичигт төсвийн ерөнхийлөн захирагчдад батлагдах төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ 969119,5 сая төгрөг байна. 2018 оны төсвийн нийт хөрөнгө оруулалтын хэмжээ

2 их наяд төгрөг давсан бөгөөд дээрх 625 тэрбум төгрөг нь 2018 онд санхүүжих хэмжээ байна. Үүний дотор өмнөх жилүүдээс шилжих хэлбэрийн хөрөнгө оруулалтууд багтсан байна. Түүнчлэн шинэ хөрөнгө оруулалтуудыг бүлэглэн үзвэл үзвэл гол анхаарал татсан хэсгүүдэд i) Төрийн дээд байгууллагуудын засварын ажил, ii) Сумын засаг даргын тамгын газрын болон багийн төвийн барилгууд, iii) Сумдад цэцэрлэгт хүрээлэн барих, iv) 30 гаруй сумдад соёлын төв шинээр барих ажил, v) Дүүрэг, сумдын спорт цогцолбор, зэрэг ажлууд байна. Эндээс үзэхэд төсвийн хөрөнгө оруулалтын хэмжээ буурахгүй байгаа бөгөөд эдгээр арга хэмжээнүүдийн хувьд нийгэм, эдийн засгийн үр ашиг, ач холбогдлын эрэмбэ гэх мэт зүйлс нь өмнөх төсвүүдийн нэгэн адил хэрхэн тодорхойлогдсон нь эргэлзээтэй байна.

ДҮГНЭЛТ

Төсвийн хөрөнгө оруулалт, түүний өнөөгийн байдал, үр ашгийн талаар судалгааны үр дүнд дараахь дүгнэлтэд хүрч байна.

Төсвийн хөрөнгө оруулалтыг онол арга зүйн хүрээнд үр ашигтай, нийгэм эдийн засгийн эерэг үр дагаврыг бий болгох ёстой гэж үздэг ажээ. Монгол улсын төсвийн хууль болон бусад эрх зүйн актуудад эдгээр онол арга зүйн хандлагыг хангалттай суулгаж өгсөн байдаг.

Гэвч эдгээр зарчим, бодлого, шалгууруудыг хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ хэрхэн хангаж буй, төсвийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг батлуулсан байдал, тухайн жилийн төсөвт хөрөнгө оруулалтын үр ашиг, нийгэм эдийн засгийн үр дагавар, эрэмбэ дарааллыг хэрхэн баримталсан зэрэг асуудлууд бүрхэг тодорхойгүй байна. Энэ асуудлыг төсвийн удирдамж, төсвийн хязгаар, төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн хэдэн шалгуурыг хангах явцуу хүрээнд хийж байгаа нь төсвийн баримт бичгүүдээс харагдаж байна. Үүнээс гадна төсвийн хариуцлагын тухай асуудал орхигдсон болох нь энэ төрлийн эрх зүйн баримт, тогтоол шийдвэр байхгүй байгаагаас харагдаж байна.

Үүний үр дүнд 2006-2016 онд 11.9 их наядыг зарцуулсан, 2017-2018 онд 3 их наяд гаруй төгрөгийг төсвийн хөрөнгө оруулалтын зардалд зарцуулахаар төлөвлөсөн, сүүлийн жилүүдэд бүтээн байгуулалт нэрийн

доор их хэмжээний мөнгө зарцуулсан, үүний зэрэгцээ нийгмийн халамжид асар их мөнгийг зарцуулсан Монгол улсын нийгэм, эдийн засгийн байдал, ядуурал, төрийн үйлчилгээний байдал яагаад сайжрахгүй байна гэсэн асуулт гарч ирнэ. Төсвийн зардал, хөрөнгө оруулалт нь эдийн засаг, нийгмийн үзүүлэлтүүдээс хурдтай нэмэгдэж байхад яагаад өрхийн орлого нэмэгдэхгүй, ядуурал буурахгүй, нийгмийн эрүүл мэнд сайжрахгүй байна вэ? Яагаад төсвийн хөрөнгө оруулалт хамгийн их нэмэгдсэн 2015-2016 онд ядуурлын түвшин 8 хувиар нэмэгдэв гэх олон асуулт хариулт хүлээж байна.

Хөрөнгө оруулалтыг буруу хийж байна, хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт нэрийн доор зарцуулсан их хэмжээний мөнгө зохих үр дүндээ хүрч чадаагүй байна гэсэн дүгнэлтэд хүрч байна.

Цаашид төсөв, төсвийн хөрөнгө оруулалтыг үр ашигтай болгох нь тулгамдсан асуудал бөгөөд үүнийг яаралтай шийдэхгүй бол буруу хөрөнгө оруулалт нь нийгэм, эдийн засагт эерэг биш сөрөг нөлөөллийг бий болгох, баялгийн зрхисгүй хуваарилалтыг дэмжих хандлагатай байж болзошгүй харагдаж байна.

Иймд төсвийн шинэчлэлийг i) Хууль дээдлэх, ii) Хариуцлагатай байх, iii) Нийгэм эдийн засгийн хувьд үр ашигтай байх чиглэлүүдэд цогцоор хийх шаардлагатай. Энэ нь нэг удаагийн шинжтэй биш урт хугацааны бодлогын шинэчлэл байх юм.

НОМ ЗҮЙ

1. Robert D.Lee, Ronald W.Johnson Philip G.Joyce. (2013). Public budgeting and systems. Burlington: Jones&Barlett Learning LLC.
2. Bodie Kane Marcus. (2009). Investment. New York,: The McGraw-Hill/Irwin.
3. CoBPP. (2015). Revenue and expenditure forecasting techniques for a PER Spending. n/a: OECD.
4. Davina F. Jacobs. (2009). CAPITAL EXPENDITURES AND THE BUDGET. New-York: IMF, Fiscal Affairs Department.
5. Edward Anderson, Paolo de Renzio and

- Stephanie Levy. (2006). The Role of Public Investment in Poverty Reduction. London,UK: Overseas Development Institute.
6. Smith,Robert W and Thomas D.Lynch. (2004). Public Budgeting in America 5 th edition. New Jersey: Pearson.
 7. МУЗГ. (2016/6/28). Монгол улсын засгийн газрын тогтоол" 2017 оны төсвийн хязгаарыг батлах тухай. Улаанбаатар: МУЗГ.
 8. МУЗГ. (2017). Монгол улсын 2018 оны төсвийн баримт бичиг. Улаанбаатар: МУЗГ.
 9. МУЗГазар. (2010). Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах нийтлэг журам. Улаанбаатар: МУЗГазар.
 10. МУЗГазар. (2012). Хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх зарим арга хэмжээний тухай. Улаанбаатар: МУЗГ.
 11. Сангийн яам. (2012). Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам. Улаанбаатар: Сангийн яам.
 12. Сангийн яам. (2016). Монгол улсын 2017 оны төсвийн танилцуулга. Улаанбаатар: Сангийн яам.
 13. Судлаачийн нэгтгэл. (2017). Төсөв дэд бүтэц хөрөнгө оруулалтын тулгамдсан асуудлууд. Улаанбаатар: СЭЗИС.
 14. УИХ. (2010). Төсвийн тогтвортой байдлын тухай хууль. Улаанбаатар: УИХ.
 15. УИХ. (2011). ТӨСВИЙН ТУХАЙ. Улаанбаатар: УИХ.
 16. УИХ. (2015). Өрийн удирдлагын тухай. Улаанбаатар: УИХ.
 17. ҮСХ. (2006-2017). Монгол улсын нийгэм эдийн засгийн байдал. Улаанбаатар: ҮСХ.
 18. ҮСХ. (2014). Монгол улсын статистикийн эмхэтгэл. Улаанбаатар: ҮСХ.

УЛСЫН ТӨСӨВТ ГАДААД ӨРИЙН ҮЗҮҮЛЭХ ДАРАМТ

Д. Мөнхцэцэг

СЭЗИС-ийн Экономиксийн тэнхиймийн эрхлэгч (МА)

Хураангуй: Монгол Улсын 2018 оны төсвийн баримт бичигт тусгагдсан өрийн удирдлагын тооцооллын дагуу 2020 он гэхэд өр/ДНБ-ий харьцаа 68,3%-д хүрч, “Төсвийн тогтвортой байдлын хууль”-ийг хангасан байхаар төсөөлсөн хэдий ч зөвхөн нэг улс төрийн сонгуулийн мөчлөгийг хамран дотоодын валютаар илэрхийлсэн тооцоолол хийжээ. Гадаад өр төлбөрийг гадаад валютаар гүйцэтгэх тул өрийн удирдлагын тооцооллыг гадаад валютаар тооцож, таамаглах нь ханшийн эрсдэлээс зайлсхийх мөнгөний бодлогын хувилбар боловсруулахад чухал ач холбогдолтой юм.

Сүүлийн жилүүдэд засгийн газрын өрийг өндөр хүүтэй шинэ бондоор санхүүжүүлдэг хэв загвар тогтлоо. Улсын эрсдэл өндөртэй, засаглал сул, засгийн газар олон дахин солигдож буй энэ үед өндөр хүүтэй их хэмжээний бондыг олон улсын санхүүгийн зах зээл дээрээс босгож, өмнөх өрөө төлж байгаа нь хэзээ зогсох, хэн хариуцлага хүлээх нь мэдэгдэхгүй өрийн сүлжээнд орсны дохио болж байна. 2021 оноос эхлэн он дараалан төлөх бондын өр нь эдийн засагт хүнд дарамт учруулахаар байгаа тул өрийн удирдлагын тооцооллыг урт хугацаанд, бодитой хийж, төлөвлөгөөтэй, тууштай бодлого баримтлах шаардлага тулгарч байна.

Эдийн засагт засгийн газрын гадаад өрийн нөлөөллийг судалсан судалгааны ажлууд, онолын үзэл баримтлалууд дээр тулгуурлан дүгнэвэл манай эдийн засаг өрийн дарамтаас гарахын тулд (1) төсвийн сахилга батыг сахиж, засгийн газрын зардлаа танах, (2) халамж, дэмжлэг, татаас зэрэг шилжих төлбөрүүдийг бууруулах сангийн бодлогыг хэрэгжүүлэх хэрэгтэй. Харин татварын хэмжээг өсгөж болохгүй. Түүнчлэн засгийн газрын бүтэц сул, сонгуулийн тогтолцоо муу, төсвийн үйл явцыг тодорхойлж байдаг янз бүрийн дүрэм, зохицуулалтууд шударга биш, засаглал муутай байх нь өрийн дарамтад унагах эрсдэлийг үүсгэдэг учраас улс төр – институцийн хүчин зүйлсийг сайжруулах тал дээр анхаарах шаардлагатай байна.

ЗАСГИЙН ГАЗРЫН ГАДААД ӨРИЙН ТАЛААРХ ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Аливаа улсын макро эдийн засагт — өрх гэр, бизнес эрхлэгч, засгийн газар болон гадаадын иргэд гэсэн үндсэн дөрвөн субъект оролцдог бөгөөд тэдгээрийн үйл ажиллагааны үнэ цэнийн нийлбэрээр тухайн улсын жилийн дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ийг хэмждэг.

Тиймээс ДНБ нь эдийн засгийн цар хүрээ, үйл ажиллагааны идэвхжлийг мэдээллэгч гол индикатор юм. Дэлхийн бүхий л улс орнууд ДНБ-ээ нийт орлого, эсвэл нийт зардлын аргаар тооцож байна. Үүнийг томъёолон бичвэл:

$$Y=C+G+I+X-M \quad (1)$$

Энд, Y – ДНБ, C – өрх гэрийн хэрэглээний нийт зардал, G – засгийн газрын бараа, үйлчилгээний худалдан авалтад гаргасан нийт зардал, I – бизнес эрхлэгчдийн хөрөнгө оруулалтандаа гаргасан нийт зардал, X – экспорт, M – импорт бөгөөд экспортоос импортыг хассан зөрүү нь тухайн улсын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнд гадаадын иргэдийн гаргасан цэвэр зардлыг илэрхийлнэ.

Харин улсын нийт орлого өрхөд төвлөрөх бөгөөд өрхөд төвлөрсөн нийт орлого байдлаар хуваарилагддаг. Үүнд:

$$Y=T+C+S \quad (2)$$

Энд, T – цэвэр татвар буюу засгийн газарт төлөх нийт татвараас шилжих төлбөр (халамж, татаас гэх мэт)-ийг хассан зөрүү, S – өрхийн хадгаламж.

(1) болон (2) тэгшитгэлүүдийг тэнцүүлэн гадаад худалдааны тэнцлийг илэрхийлбэл (3) тэгшитгэл гарна.

$$(X-M)=(T-G)+(S-I) \quad (3)$$

(3) тэгшитгэл нь дараах үндсэн хоёр хамаарлыг илтгэж байгаа юм. Үүнд:

1. Төсвийн алдагдал нь тухайн улсын хадгаламжийг бууруулж, дотоодын бизнес эрхлэгчдийн хувьд хөрөнгө оруулалтын дотоод эх үүсвэрийг багасгаж, хүүний түвшинг нэмэгдүүлснээр гадаадаас зээл авах шаардлагыг үүсгэнэ. Төсвийн алдагдлаа нөхөхийн тулд засгийн газар гадаадаас зээл авах шаардлага тулгарснаар засгийн газрын өрийг тойрсон асуудлууд урган гардаг.
2. Төсвийн алдагдал нь гадаад худалдааны алдагдлыг бий болгох буюу импортын хэмжээ экспортын хэмжээг давах шалтгаан болно. Энэ тохиолдолд дотоод эдийн засгаас капитал гадагшилж, дотоод валютын ханш сулардаг.

Засгийн газрын гадаад өр нь эдийн засагт хэрхэн нөлөөлөхийг тайлбарладаг үндсэн

хоёр онолын хандлага бий¹. Үүнд:

1. *Засгийн газрын өрийн талаарх уламжлалт хандлага.* Засгийн газрын төсвийн алдагдал нь богино хугацаанд нийт эрэлтийг дэмжиж, үйлдвэрлэлийг өсгөх нөлөөтэй ч урт хугацаанд улсын хадгаламжийг бууруулж, капиталын нөөцийг багасгаснаар гадаадын өрийг улам нэмэгдүүлнэ. Энэ хэрээр улсын нийт ДНБ буураад зогсохгүй, гадаадынхны эзэмшдэг орлогын хувь нэмэгддэг.

2. *Засгийн газрын өрийн талаарх Рикардогийн тэнцүү чанарын хандлага.* Уламжлалт хандлагаар өгүүлсэнчлэн засгийн газар зардлаа нэмэгдүүлж, нийт эрэлтийг дэмжин, богино хугацаанд үйлдвэрлэлийг өсгөж болох хэдий ч урт хугацааг харвал энэ нь нийт орлогод төдийлөн эерэг нөлөө үзүүлэхгүй. Засгийн газрын өрийн нөлөөг шинжлэхийн тулд Рикардо хэрэглэгчид ирээдүйг харсан рационал шийдвэр гаргадаг гэж үзсэн. Засгийн газрын өр гэдэг бол ирээдүйн татварын өсөлт. Засгийн газар өрийг санхүүжүүлэхийн тулд ирээдүйд татварыг өсгөнө гэж хэрэглэгчид хүлээдэг. Тиймээс өнөөдрийн хэрэглээгээ төдийлөн өсгөхгүй учраас нийт эрэлт дэмжигдэхгүй, үйлдвэрлэл өсөхгүй буюу засгийн газрын өрөөрх санхүүжилт нь татвараарх санхүүжилттэй тэнцүү чанартай болж хувирдаг.

Харин засгийн газрын гадаад өр нь урт хугацаанд дэлхийн эдийн засаг дахь тухайн улсын гүйцэтгэх үүрэг, нөлөөг өөрчилж болох юм. Төсвийн алдагдал улсын хадгаламжийг бууруулж, алдагдлаа нөхөхийн тулд гадаадаас зээл авснаар худалдааны алдагдлыг бий болгодог. Төсвийн алдагдал болон худалдааны алдагдлын хоорондын уялдаа нь засгийн газрын өртэй холбоотойгоор дараах хоёр

¹ N. Gregory Mankiw, 2016, p.564


ирээдүйн үр дагаврыг бий болгодог².

1. Засгийн газрын өрийн хэмжээ өндөр байх нь тухайн эдийн засгаас капитал гадагшилж, дэлхийн санхүүгийн зах зээл дээрх тухайн улсын хөрөнгийн эрэлтийг огцом бууруулах эрсдэлийг өсгөдөг. Засгийн газар өрөө төлөхгүй байх (дефолт) замаар өрийн асуудлаа амархан шийдэх боломжтой гэдгийг гадаадын хөрөнгө оруулагчид мэдэж байгаа. Саяхан ОХУ 1998 онд өр төлбөрөө төлөлгүй, дефолт зарлаж байсан бол 2001 онд Аргентин Улс мөн ижил байдлыг үүсгэж байжээ. Ийнхүү засгийн газрын үлдэгдэл өр өсөхийн хэрээр тухайн засгийн газар зээлээ төлж чадахгүйд хүрч магадгүй гэсэн болгоомжлол гадаадын хөрөнгө оруулагчдад бий болдог. Хэрвээ тэд итгэл үнэмшлээ гэнэт алдвал үр дүн нь капитал гадагшлалтын сонгодог шинж чанарыг үүсгэнэ. Энэ сонгодог чанар гэдэг нь валютын ханшийн уналт

болон хүүний түвшингийн өсөлт хоёр зэрэг бий болохыг хэлнэ. 1990-ээд оны эхэн үед Мексикт мөн ийм зүйл анх тохиож байжээ.

2. Гадаадын зээлээр санхүүжүүлж буй засгийн газрын өрийн өндөр түвшин нь дэлхийн эдийн засаг дахь тухайн улсын улс төрийн нөлөөг бууруулдаг. Ийм болгоомжлол байдаг гэдгийг 1988 онд Бенжамин Фридман "Day of Reckoning" номондоо онцлон тэмдэглэжээ. Тэрээр "АНУ-ын эдийн засгийн сэргэн мандалтын үе болон дэлхийд эзлэх байр суурь өссөн үе хоёр давхцаж байсан нь тохиолдол биш. Түүхийн туршид цэвэр зээлдэгч улсын дэлхийн эдийн засагт үзүүлэх нөлөө, байр суурь нь хуримтлагдсаар ирсэн юм. Харин АНУ-ын худалдааны алдагдал их хэвээр үргэлжилсээр байвал олон улс дахь нөлөөгөө алдах болно" гэжээ.

Зураг 1. Богино болон урт хугацаанд эдийн засагт гадаад өрийн үзүүлэх нөлөө



Эх сурвалж: N. Gregory Mankiw, 2016

² N. Gregory Mankiw, 2016, p.575

СУДЛАГДСАН БАЙДЛЫН ТОЙМ

1970-аад оны дунд үед "Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага"-ын (OECD) хэд хэдэн оронд их хэмжээний улсын өр хуримтлагджээ. Харьцангуй нэгдмэл үндэстнээс бүрдэх улс орнуудад тайван цагт өр/ДНБ харьцааны ийм өсөлт урьд өмнө гарч байгаагүй ажээ³. 1990 он гэхэд Грек, Итали, Ирланд зэрэг оронд хуримтлагдсан өрийн харьцаа 95 хувиас давж байсан бол Герман, Франц, Их Баританид өрийн харьцаа 50 хувиас бага байв. (Alberto Alesina and Roberto Perotti, 1995)

Алесина, Пероти нар өрийн харьцаа ингэж өссөн цаг хугацааны болоод улс орны онцлогийг тайлбарлахад улс төр-институцийн хүчин зүйлсийг авч үзэх нь чухал гэжээ. Тэдний үзэж буйгаар хамгийн чухал хоёр хүчин зүйл нь:

1. Төсвийн үйл явцыг тодорхойлж байдаг янз бүрийн дүрэм, зохицуулалтууд
2. Засгийн газрын бүтэц, өөрөөр хэлбэл, сонгуулийн тогтолцооны нөлөөгөөр намууд эвсэж засгийн газар байгуулах хандлагатай юу, эсвэл дангаараа засгийн газар байгуулах хандлагатай юу гэдэг хандлага чухал нөлөөтэй.


Эдийн засаг гэнэтийн том өөрчлөлттэй тулгарсан үед эвслийн сулхан засгийн газар сангийн бодлогын зайлшгүй өөрчлөлтийг хойшлуулах хандлагатай байдаг. Судалгаа, төлөвлөгөө сайтай, тууштай бодлого баримталдаг засгийн газрын хувьд эдийн засгийн аливаа шокод түргэн хариу үйлдэл үзүүлж, сангийн бодлого явуулдаг бол ашигч улс төрч бүхий засгийн газрууд сангийн бодлогын

зайлшгүй өөрчлөлтийг хойшлуулдаг байж болох юм. (Alesina Alberto and Allan Drazen, 1991)

Сангийн бодлогын өөрчлөлт макро эдийн засгийн үр дүн, тогтвортой байдалд амжилттай нөлөөлөх эсэх нь уг өөрчлөлтийн бүтцээс хамаардгийг Алесина, Перотти нарын судалгаа харуулдаг. (Alesina Alberto, and Roberto Perotti, 1996) Сангийн бодлогын хувьд үндсэн хоёр төрлийн өөрчлөлт бий. Нэгдүгээр төрлийн сангийн бодлогын өөрчлөлт нь засгийн газрын зардлыг танаж, шилжих төлбөр, нийгмийн салбарын цалин хөлс, ажил эрхлэлтийг бууруулдаг бол хоёрдугаар төрлийн сангийн бодлогын өөрчлөлт нь өргөн суурьтай татварыг өсгөж, төсвийн зардлыг санхүүжүүлэх, улсын хөрөнгө оруулалтыг бууруулахад голлон чиглэнэ. Алесина, Перотти нар нэгдүгээр төрлийн өөрчлөлтийн дүнд төсвийн бат бэх байдал удаан үргэлжилж, эдийн засгийн тэлэлт явагддаг бол хоёрдугаар төрлийн өөрчлөлт удалгүй төсвийн доройтлоор солигдож, эдийн засгийг хумих үр дагавартайг тогтоожээ. Иймээс нийгмийн хамгаалал, халамжийн хөтөлбөр, төрийн хүнд суртлын бэрхшээлийг шийдэлгүй тойрсон сангийн бодлогын ямар ч өөрчлөлт бүтэлгүйтдэг. (Alberto Alesina, 2000) Түүнчлэн нэгдүгээр төрлийн өөрчлөлт нь өрсөлдөх чадварт (нэгж хөдөлмөрийн зардалд) татварыг жигд бус өсгөх бодлогоос илүү эерэг нөлөө үзүүлэх хандлагатай байдаг. (Alesina Alberto, and Roberto Perotti, 1997) **(Зураг 2)**

³ Brian Snowdon and Howard R. Vane, 2005

Зураг 2. Сангийн хумих бодлого дахь бүтцийн өөрчлөлтийн нөлөө



Эх сурвалж: Alesina Alberto, and Roberto Perotti, 1997

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ГАДААД БОНДЫН ӨРИЙН ТАЛААРХ ШИНЖИЛГЭЭ

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн худалдаанаар 2018 оны төсвийн төслийг УИХ-аар хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлэхээр тогтжээ. Энэхүү төсвийн төслийн хүрээнд засгийн газрын өрийн удирдлагыг төлөвлөхдөө 2018-2020

оны хоорондох засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнийг тооцон дараах хүснэгтэд харуулсан байдлаар төсөөлсөн бөгөөд энэ нь “Төсвийн тогтвортой байдлын тухай” хуульд заасан өр/ДНБ-ий шалгуур үзүүлэлтийг хангаж байна гэж дүгнэжээ.

Хүснэгт 1. 2018 оны Монгол Улсын төсөвт тусгагдсан өрийн удирдлага

(Төсвийн тусгай шаардлагын тооцоолол, тэрбум төгрөгөөр)

	Өрийн бүтэц, өрийн хэрэгсэл	2016	2017	2018	2019	2020
1	Засгийн газрын дотоод өр	6,464.9	4,772.7	4,769.1	4,778.5	4,227.6
2	Засгийн газрын гадаад өр	12,363.8	16,964.9	19,959.1	22,803.1	24,247.3
3	Засгийн газрын өрийн баталгаа	3,451.5	1,852.5	1,703	1,325.6	1,278.1
	Нийт өр	22,280.2	23,590.1	26,431.2	28,907.2	29,753.0
	Засгийн газрын өр/ДНБ	78.8%	74.1%	76.1%	73.5%	68.3%

Эх сурвалж: Монгол Улсын 2018 оны Төсвийн баримт бичиг, 13 дугаар хэсэг, Засгийн газрын өрийн удирдлага


Дээрх хүснэгтэд үзүүлсэн засгийн газрын өрийн төсөөллийг графикаар дүрслэн харвал засгийн газрын гадаад өр 2020 оныг хүртэл алгуур, тогтмол өсөх хандлагатай

байгаа бол дотоод өр болон өрийн батлан даалтын хэмжээ тогтмол буурах төсөөлөл гарчээ.

Гэвч дээрх төсөөллийг хийхдээ **(1)** зөвхөн

Зураг 3. 2018 оны Монгол Улсын төсөвт тусгагдсан өрийн удирдлага

(тэрбум төгрөгөөр)



Эх сурвалж: Монгол Улсын 2018 оны Төсвийн баримт бичиг, 13 дугаар хэсэг, Засгийн газрын өрийн удирдлага

төгрөгөөр хэмжсэн нь дутагдалтай. Ялангуяа засгийн газрын гадаад өрийн төлөлтийг гадаад валютаар хийх бөгөөд энэ нь өр төлөгдөх жилдээ төлбөрийн тэнцлийн хямрал, ханшийн хямралыг дагуулах эрсдэлтэй учраас гадаад өрийн удирдлагыг гадаад валютаар тооцоолсон тооцоон дээр үндэслэх нь чухал юм. **(2)** засгийн газрын өрийн тухай тусгай шаардлагын тооцооллыг 2020 хүртэл хугацаанд буюу улс төрийн сонгуулийн нэг мөчлөгөөр тооцсон нь дутагдалтай байна.


(Зураг 4)-д зөвхөн засгийн газрын гадаад бондын хэмжээ, хүү, хугацааг харуулсан бөгөөд засгийн газрын өрд тооцогдох өрийн баталгааны талаарх мэдээллийг хавсралтаар үзүүлээ. 2012 оноос хойш нийт 4,4 тэрбум долларын бондыг дэлхийн зах зээлээс босгосон ба үүний бараг 50%-ыг сүүлийн гурван жилийн хугацаанд илүү өндөр хүүтэйгээр авчээ.

Засгийн газраас УИХ-д өргөн барьсан "Монгол Улсын 2018 оны төсвийн баримт бичиг"-т тусгагдсан гадаад бондын талаарх мэдээлэлд үндэслэн 2024 он хүртэлх бондын хүүний болон үндсэн

төлбөрийн тооцооллыг хийхэд Хүснэгт 2-д үзүүлсэн байдалтай гарлаа. Иен болон юаниар хэмжигдсэн Самурай, Дим Сам бондуудын хэмжээг доллар-иен, доллар-юаньтай харьцах тухайн оны ханшаар хөрвүүлэн тооцооло.

(Хүснэгт 2)-оос харвал Евро бондын өрийг төлөх зорилгоор Хуралдай бондыг гаргасан, Чингис бондын эхний хэсэг, Дим сам бондын төлбөр болон дотоод зах зээл дээрээс босгосон өндөр хүүтэй өрийн бичгийг төлөх зорилгоор Гэрэгэ бондыг гаргасан байна. Хэдийгээр урьд нь авсан бондуудыг үр өгөөж өндөртэй төрийн болон хувийн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдэд дамжуулан зээлдүүлсэн гэх хэдий ч тэдгээрийн үр өгөөж, буцаан төлөлтийн талаар дорвитой мэдээлэл алга. Түүнчлэн өмнө нь авсан Евро, Чингис зэрэг бондуудын эргэн төлөлтийн хугацаа болоход шинэ бонд гаргах замаар бүрэн санхүүжүүлж байгаа нь **(1)** тэдгээр бондын зарцуулалт үр өгөөж маш муу, **(2)** тэдгээр бондын үр өгөөжөөс орж ирсэн буцаан төлөлтийг улсын төсвийн өнөөгийн орлого болгон бүртгээд,

Зураг 4. Засгийн газрын гадаад бонд



Эх сурвалж: Монгол Улсын 2018 оны төсвийн баримт бичиг

Хүснэгт 2. Засгийн газрын гадаад өрийг буцаан төлөх хуваарь

Гадаад өр	Он	Хэмжээ сая ам.доллар	Хүү	Эргэн төлөгдөх хугацаа	Эргэн төлөгдөх хэмжээ								
					2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	
Евро бонд	2012	580	5.75%	2017.3.21	588.3	Хуралдай бондоор төлсөн.							
Чингис бонд	2013	500	4.13%	2018.1.5	20.6	500	Гэрэгэ бондоор төлнө.						
	2013	1000	5.13%	2022.12.5	51.3	51.3	51.3	51.3	51.3	1051.3			
Самурай бонд*	2014	286	1.52%	2023	4.3	4.3	4.3	4.3	4.3	4.3	290.3		
Дим сам бонд**	2015	155	7.50%	2018	11.6	166.6	Гэрэгэ бондоор төлнө.						
Мазаалай бонд	2016	500	10.19%	2021	50.9	50.9	50.9	50.9	550.9				
Хуралдай бонд	2017	476	8.75%	2024	41.7	41.7	41.7	41.7	41.7	41.7	41.7	517.7	
	2017	124	7.63%	2024	9.5	9.5	9.5	9.5	9.5	9.5	9.5	133.5	
Гэрэгэ бонд	2017	800	5.63%	2023	7.5	45	45	45	45	45	845		
Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр	2017	440	2.00%	2020	8.8	8.8	8.8	448.8					
					4868	786.2	876.8	202.6	202.6	702.6	1151.7	1186.5	651.1
							12%	-77%	0%	247%	64%	3%	-45%

Эх сурвалж: Монгол Улсын 2018 оны төсвийн баримт бичиг

Тайлбар: * 30 тэрбум иенийг 2013 оны ханшаар ам.доллар луу шилжүүлэв.

** 1 тэрбум юанийг 2015 оны ханшаар ам.доллар луу шилжүүлэв.


гадагшаа төлөх төлбөрийг шинэ бондоор бүрэн санхүүжүүлж байна гэсэн дүгнэлт хийж болохоор байна. Сүүлийн жилүүдэд өрийн төлөлтийг дахин шинэ бонд гаргах замаар санхүүжүүлж байгаа энэ хэлбэр нь манай эдийн засаг гадаад өрийн

сүлжээ дарамтад орсныг илтгэх бөгөөд энэ талаар онолын хэсэгт дэлгэрэнгүй тайлбарласан. Өөрөөр хэлбэл, Евро, Чингис, Самурай зэрэг бондуудыг муу дүрэм, зохицуулалтын доор эргэн төлөгдөх магадлал муутай, найдваргүй

төслүүдэд хөрөнгө оруулснаар богино хугацаанд 2012, 2013 онуудад эдийн засаг өссөн дүр зураг ажиглагдсан хэдий ч урт хугацаанд төсвийн алдагдлыг нэмэгдүүлж, төсөвт дарамт учруулан, улсын хэмжээнд хадгаламж, хөрөнгө оруулалтыг бууруулж, капиталын нөөцийг багасгасан байна. Түүнчлэн улс төрийн тогтворгүй байдал, өрийн дефолт болох магадлалтай байдлаас улбаалан гадаадын хөрөнгө оруулагчдын итгэл алдарч, олон улсын хөрөнгийн зах зээл дээрх зээлжих зэрэглэл буурснаар 2015 оноос хойш гадаад бондын хүүний түвшин өссөн байна. Улсын эрсдэл өндөртэй, засаглал сул, засгийн газар олон дахин солигдож буй энэ үед өндөр хүүтэй их хэмжээний бондыг олон улсын

санхүүгийн зах зээл дээрээс босгож, өмнөх өрөө төлж байгаа нь хэзээ зогсох, хэн хариуцлага хүлээх нь мэдэгдэхгүй өрийн сүлжээнд нэгэнт орсон байна. Дээр дурьдсанчлан 2012 онд гаргасан Евро бондын төлбөрийг 2017.3 сард илүү өндөр хүүтэй Хуралдай бондоор санхүүжүүлсэн ба 2017 оны төгсгөл, 2018 оны эхээр төлөх Чингис бондын эхний хэсэг, Дим Сам бондын төлбөрийг санхүүжүүлэхээр мөн өндөр хүүтэй Гэрэгэ бондыг олон улсын зах зээл дээр босгож, өр төлбөрийн асуудлыг шийдсэн учраас 2020 он гартал засгийн газрын бондын төлөлтийн асуудал намжмал байдалтай байхаар харагдаж байна.

Зураг 5. Засгийн газрын бондын эргэн төлөлтийн хуваарь, сая ам.доллароор



Эх сурвалж: Монгол Улсын 2018 оны төсвийн баримт бичиг

2020 оны өрийн төлөлтөд Олон улсын валютын сан (ОУВС)-ийн "Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр"-ийн хүрээнд орж ирсэн 440 сая долларын төлбөрийг нэмж тооцоогүй. Учир нь, ОУВС тодорхой шаардлага тавьж, "хагуу" дэг журмын доор хөтөлбөр хэрэгжүүлж буй

учраас 440 сая долларын зээлийг өрийн дарамт болох эрсдэл бага, түүнчлэн энэ судалгаанд гадаад өрийн хэлбэрүүдээс зөвхөн засгийн газрын бондын өрийг онцлон тооцоолол, төсөөлөл хийсэн учраас ОУВС-ын зээлийг тооцооллын гадна үлдээлээ.

ДҮГНЭЛТ

Засгийн газрын өрийн удирдлагын тооцооллыг 2020 оныг хүртэл хугацаанд хийсэн бөгөөд 2021-2024 онд төлөгдөх өндөр дүнтэй өрийн эргэн төлөлтийг

хэрхэн санхүүжүүлэх төлөвлөгөө хуваарь 2018 оны төсвийн баримт бичигт тусгагдсангүй. Өрийн удирдлагын тооцооллыг хийхдээ 2020 оныг хүртэл

хугацааг авч үзсэн нь дутагдалтай. Түүнчлэн өрийн удирдлагын тооцооллыг зөвхөн төгрөгөөр тооцоолсон нь засгийн газрын гадаад өрөөс шалтгаалан төлбөрийн тэнцлийн хямрал, цаашлаад валютын ханшийн хямрал үүсэх эрсдэлийг тооцоогүй байна.

Сүүлийн жилүүдэд засгийн газрын өрийг өндөр хүүтэй шинэ бондоор санхүүжүүлдэг хэв загвар тогтлоо. 2017, 2018 онуудад төлөгдөх Евро, Чингис, Дим сам бондуудын эргэн төлөлтийг Хуралдай, Гэрэгэ бондуудаар санхүүжүүлэх хуваарь "Монгол Улсын 2018 оны төсвийн баримт бичиг"-т тусгагджээ. Улсын эрсдэл өндөртэй, засаглал сул, засгийн газар олон дахин солигдож буй энэ үед өндөр хүүтэй их хэмжээний бондыг олон улсын санхүүгийн зах зээл дээрээс босгож, өмнөх өрөө төлж байгаа нь манай улс хэзээ зогсох, хэн хариуцлага хүлээх нь мэдэгдэхгүй өрийн сүлжээнд орсны дохио болж байна.

2021-2024 оны засгийн газрын гадаадын өрийн эргэн төлөлт нь манай улсын төсөвт ихээхэн дарамт учруулахаар байна. "Монгол Улсын 2018 оны төсвийн баримт бичиг"-т тусгагдсан өр/ДНБ-ий төсөөлөл, "Төсвийн тогтвортой байдлын хууль"-д заасанчлан 2020 онд гардаа өр/ДНБ-ий харьцаа 70% байхаар

төсөөлөгдсөн. Гэтэл 2021 онд Мазаалай бондын 500 сая доллар, 2022 онд Чингис бондын 1 тэрбум долларын үлдэгдэл, 2023 онд Самурай бондын 30 тэрбум иен, 2024 онд Хуралдай бондын 600 сая долларын өрүүдийг он дараалан төлөх хуваарьтай байгаа нь манай эдийн засагт ихээхэн дарамт учруулна.

Засгийн газрын гадаад өрийн нөлөөллийг судалсан судалгааны ажлууд, онолын үзэл баримтлалууд дээр тулгуурлан тайлбарлавал манай эдийн засаг өрийн дарамтаас гарахын тулд (1) төсвийн сахилга батыг сахиж, засгийн газрын зардлаа танах, (2) халамж, дэмжлэг, татаас зэрэг шилжих төлбөрүүдийг бууруулах сангийн бодлогыг хэрэгжүүлэх хэрэгтэй. Харин татварын хэмжээг өсгөж болохгүй. Алесина, Перотти нарын дүгнэснээр татварыг өсгөвөл хадгаламж, хөрөнгө оруулалт буурч, төсвийн доройтол бий болж, эдийн засаг улам хумигдан, ажилгүйдэл өсдөг. Түүнчлэн засгийн газрын бүтэц сул, сонгуулийн тогтолцоо муу, төсвийн үйл явцыг тодорхойлж байдаг янз бүрийн дүрэм, зохицуулалтууд шударга биш, засаглал муутай байх нь өрийн дарамтад унагах эрсдэлтэй байдаг⁴ учраас улс төр – институцийн хүчин зүйлсийг сайжруулах тал дээр анхаарах шаардлагатай байна.

НОМ ЗҮЙ

1. Alberto Alesina. (2000). The Political Economy of the Budget Surplus in the United States . Journal of Economic Perspectives-Volume 14, Number 3, 3-19.
2. Alberto Alesina and Roberto Perotti. (1995). The Political Economy of Budget Deficits. Staff Papers (International Monetary Fund), Vol. 42, No. 1, pp. 1-31.
3. Alesina Alberto and Allan Drazen. (1991). Why are stabilizations delayed? American Economic Review, 81(5): 1170-1188.
4. Alesina Alberto, and Roberto Perotti. (1996). Fiscal Discipline and the Budget Process. American Economic Review, 401-407.
5. Alesina Alberto, and Roberto Perotti. (1997). The welfare state and competitiveness. American Economic Review 87(5), 921-939.
6. Brian Snowdon and Howard R. Vane. (2005). Modern Macroeconomics: Its

⁴Alberto Alesina and Roberto Perotti, 1995

- Origins, Development and Current State. USA: Edward Elgar.
7. GEREGE PARTNERS Professional Services, Эндрю Бауэр, Г.Рагчаасүрэн, Л.Мөнх-Оргил, Дэвид Михали, Т.Номуунтөгс. (2017). Монгол Улсын төсвийн тогтвортой байдал. Улаанбаатар.
 8. N. GREGORY MANKIW. (2016). Macroeconomics. New York: Worth Publishers.
 9. Paul R. Krugman, Maurice Obstfeld and Marc J. Melitz. (2012). International Economics: Theory & Policy. New York: Pearson.
 10. Torsten Persson and Guido Tabellini. (2004). Constitutional Rules and Fiscal Policy Outcomes. AMERICAN ECONOMIC REVIEW, VOL. 94, NO. 1, 25-45.
 11. Монгол Улсын Засгийн газар . (2017). 2018 оны төсвийн баримт бичиг. Улаанбаатар.
 12. Монгол Улсын Үндэсний статистикийн хороо. (2016). Монгол Улсын статистикийн эмхэтгэл . Улаанбаатар.

Хавсралт. Гадаад бондоос бусад өрийн баталгаа

	Баталгаа	Он	Хэмжээ сая ам.доллар	Хүү	Төлөх хугацаа
1	Кредит свисс банкны зээл	2014	300	4.38%	2021
2	Боинг нисэх онгоц худалдан авах	2013	77.4	2.52%	2023
			23.9	5.3%+LIBOR	2020
			20	9.38%+LIBOR	2018
3	Эрдэнэс Монгол ХХК - Азийн хөгжлийн банк	2016	35	LIBOR хүүтэй	12 жилийн хугацаатай 2019 оноос төлж эхэлнэ.
4	ХХБ-д гаргасан баталгаа	2015	500		

Эх сурвалж: Монгол Улсын 2018 оны төсвийн баримт бичиг

2018 ОНЫ ТӨСӨВ БА НИЙГМИЙН БОДЛОГЫН ТУЛГАМДСАН АСУУДЛУУД

П.Гантөмөр
СЭЗИС-ийн Экономиксийн тэнхимийн профессор (Ph.D)

НИЙГМИЙН БОДЛОГЫН ТАЛААРХИ ҮЗЭЛ БАРИМТЛАЛУУД

Нийгмийн бодлогыг 2 арга замаар тодорхойлж болно. *Нэргүүлэгч*, нийгмийн бодлого нь ихэвчлэн хувь хүн, бүлэг хүмүүст шууд нөлөөлдөг гэж харж болно. *Хоёрдугаарт*, нийгмийн бодлого бол шинжлэх ухаанчаар судлах талбар юм.

Нийгмийн бодлого бол "Нийгмийн асуудлууд руу чиглэсэн бодлого, үйл ажиллагааг хөгжүүлэх болон хэрэгжүүлэх, мөн тухайн арга хэмжээнүүдээ бүхий л давхаргуудад судлах шинжлэх ухаан юм"¹. Baldock, Manning, Bickerstaff нарын тодорхойлсоноор нийгмийн бодлого нь төрийн шууд оролцоотойгоор нийгмийн сайн сайхан байдалд хүрэхийн тулд иргэдийн дунд нөөцийг дахин хуваарилах үйл явц юм.

Нийгмийн бодлого нь хувь хүн болон тодорхой зорилтот бүлэг рүү чиглэдэг хэдий ч өргөн цар хүрээтэйгээр олон хүмүүст шууд нөлөөлдөг. Spicker

(2008:1)-ийн хэлсэнээр нийгмийн бодлого нь орон сууцжуулах, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгаалал, ажил эрхлэлт зэрэг хэд хэдэн асуудлуудад төвлөрдөг. Нийгмийн бодлогын хөгжил, хэрэгжилт нь тухайн нийгмийн бүхий л хүмүүсийн сайн сайхан байдалд шууд нөлөөтэй байдаг. Нийгмийн сайн сайхан байдал нь нийгмийн тулгамдсан асуудлуудтай холбоотой төдийгүй нийгэм дэх хувь хүн болоод бүлэг хүмүүсийн хэрэгцээг хангахуйц нийгмийн янз бүрийн зохицуулалтаас ихээхэн хамаардаг.


Fitzpatrick (2001:5)-ийн үзсэнээр нийгмийн бодлогын зорилго сайн сайхан байдлыг хамгийн их байлгахад оршдог ба тэрээр сайн сайхан байдлын үндсэн 6 үзэл баримтлалыг санал болгосон байна. Үүнд: (1) Аз жаргал (2) Аюулгүй байдал (3) Таашаал (4) Хэрэгцээ (5) Амттан (6) Харьцангуй харьцуулалт

НИЙГМИЙН БОДЛОГО БА ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

Нийгмийн бодлого болон эдийн засгийн бодлогын хоорондын ялгааг ойлгож байх нь чухал юм. Учир нь нийгмийн бодлого бол хувь хүн болон нийгмийн зорилтот бүлэг рүү чиглэсэн үйл явц бол эдийн засгийн бодлогын

зорилго нь эдийн засгийн өсөлтийг хангах, бүхий л хүмүүсийн сайн сайхан байдлыг дээшлүүлэхэд оршдог. Нийгмийн бодлого болон эдийн засгийн бодлогын хоорондын ялгааг (Зураг 1)-д харуулсан схемээс нарийвчлан харж болох юм.

¹Alcock, Erskine, May, 2002:240

Зураг 1. Нийгмийн бодлогоос эдийн засгийн үйлдвэрлэл хамаарах нь

Эх сурвалж: : Alan Walker, Chack-kie Wong: *The relationship between social policy and economic policy: Constructing the public burden of welfare in China and the West, 2009*

(Зураг 1)-д үзүүлсэнээр нийгмийн бодлого нь хувь хүн, өрхүүдэд чиглэхээс гадна ажил эрхэлж буй бүх хүмүүсийн сайн сайхан байдлыг дээшлүүлээд зогсохгүй эдийн засгийн үйлдвэрлэлийг дэмжиж байх ёстой гэдгийг харуулна. Эндээс ажил эрхэлж буй болон нийгмийн халамж үйлчилгээ авдаг хүн бүрийн сайн сайхан байдал дээшилж байна уу? гэдэг асуудал урган гарах болно. Нөгөөтэйгүүр нийгмийн бодлого нь баялагийг хуримтлуулах тохиромжтой орчинг бий болгоход чиглэгдэх ёстой. / Хамгийн энгийн жишээ бол ажилгүй хүмүүсийг ядууралд өртөхгүйгээр амьдрах боломжийг бий болгох асуудалд чиглэж болох юм. Энэ асуудал хэр зэрэг түвшинд байгааг дэлхийн банкны төлөөллийн Монгол улсын ядуурлын талаар хийсэн судалгааны үр дүнгээс харж болох юм.

2017 оны 10 сард Дэлхийн банкны "Ядуурал ба тэгш байдлын олон улсын баг"-ийн ахлах эдийн засагч Самуэль Фрейже-Родригесийн танилцуулсанаар Монгол улсын хүн амын ядуурал 2014 онд 21,6% байсан бол 2016 онд 29,6 хувь болж 8 хувиар өссөн байна. Үүнээс гадна ядуурал хотод 27,1%, хөдөөд 34,9% байна гэдгийг илтгэлдээ дурджээ. Нийт ядуусын 62,1% хот, суурин газар, тодруулбал, Улаанбаатар хотод ядуусын 37,8% амьдарч байна гэсэн үр дүн танилцуулсан байна. Уг судалгааны үр дүн нь ажил эрхэлж буй хүмүүсийн болоод нийгмийн халамж үйлчилгээ авдаг өрхийн гишүүдийн сайн сайхан байдал жилээс жилд дээшлэх бус харин бизнесийн мөчлөгийн онол ёсоор уналтын шат руу явж байгааг илтгэж байна. Өөрөөр хэлбэл, ядуурлын түвшин нэмэгдэх хандлагатай байгааг илтгэнэ.

НИЙГМИЙН ХАЛАМЖ БОЛОН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛААРХИ ТОЙМ СТАТИСТИК

Дээр өгүүлсэнээр нийгмийн бодлого нь эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгаалал, ажил эрхлэлт зэрэг асуудлуудад чиглэдэг билээ. Ийм учраас нийгмийн бодлогын хүрээнд зайлшгүй анхаарлаа хандуулах шаардлагатай асуудлын нэг болох нийгмийн халамж, үйлчилгээний хүрээнд 2018 оны төсөвт тусгасан мэдээллийг ашиглан шинжилгээнүүдийг

хийж гүйцэтгэлээ.

2018 оны төсөвт Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны багцад 1159013.3 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн бөгөөд үүнээс 94,5% нь урсгал зардалд, 4,5% нь цалин болон нийгмийн даатгалын шимтгэлд, 1% нь бусад үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөгджээ.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын

яамны харьяалал дор нийгмийн халамж, үйлчилгээнд чиглэсэн хөтөлбөрт тусгагдсан төсвийг захиран зарцуулах эрхтэй төсвийн 12 захирагч байна. Өөрөөр хэлбэл, ерөнхийд нь багцлан авч үзвэл нийгмийн халамж, тэтгэвэр, тэтгэмжийн үйлчилгээгээр дамжуулан хүн амд чиглэсэн нийгмийн бодлогыг хэрэгжүүлдэг удирдлагын түвшний 12 байгууллага байдаг гэж үзэж болох юм. Үүнд: (1) Мэргэжлийн боловсрол (2) Нийгмийн даатгал (3) Нийгмийн халамж (4) Нийгмийн хамгааллын бодлого, удирдлага (5) Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих (6) Хөдөлмөр эрхлэлтийн бодлого, удирдлага (7) Хүчирхийлэлд өртөгсдөд тусламж (8) Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил, хамгаалал (9) Хүүхдийн хөгжил, хамгаалал (10) Ахмад настны хөгжил, хамгаалал (11) Залуучууд ба оюутнууд (12) Гэр бүлийн хөгжил, хамгаалал.

Бусад байгууллагууд хэдэн аж ахуйн нэгжээс бүрддэг нь төсөвт тодорхой тусгаадаагүй байсан учраас онцлон мэргэжлийн боловсролын байгууллагыг бүрдүүлдэг нэгжийг авч үзье. Мэргэжлийн боловсролын байгууллага нь төрийн өмчит 37, хувийн өмчит 41 мэргэжлийн сургалт

үйлдвэрлэлийн төвөөс бүрдэж байна. Төрийн өмчит сургууль бүрт нэг захирал байдаг гэвэл 37 захиралтай, нэг нягтлан бодогчтой зэргээр хэдэн хүн мэргэжлийн боловсролын байгууллагад ажил эрхэлдэг болохыг нарийвчлан авч үзэж болох юм. Үүнийг өгүүлж буйн учир шалтгаан нь төрийн өмчит мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн бүхий л зардлыг төрөөс хариуцаж байдагтай холбоотой юм. Тус мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв нь 26908 суралцагчтай ба тухайн сургалт үйлдвэрлэлийн төвд 46569,7 сая төгрөг төсөвлөжээ. Уг зардал нь эдгээр сургуулиудын сургалтын үйл ажиллагааг явуулахад зарцуулагдахаар төлөвлөсөн байна. Үүнээс гадна мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн төгсөгчдийн ажлын байраар хангагдах түвшинг 65,1% байхаар төсөвт тусгажээ. Уг түвшинг ямар үндэслэл, статистикийн ямар мэдээлэл, эсвэл, ямар арга ашиглан прогноз хийж тооцсон талаар тодорхой бус байна. Мөн 20 мэргэжлийн боловсролын байгууллагын дадлагын болон сургалтын баазыг шинэчлэхээр зардал төсөвлөсөн байгааг энд зайлшгүй дурдах нь зүйтэй болов уу.

НИЙГМИЙН ХАЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮН АМ РУУ ЧИГЛЭСЭН ЗАРДЛЫН БҮТЭЦ

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас 2018 онд нийтдээ 12 хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. Эдгээр хөтөлбөрийн заримд нь тусгагдсан бөгөөд зөвхөн хүн амд халамж, тэтгэвэр тэтгэмж, урамшуулал, нөхөн олговор хэлбэрээр төлөвлөсөн зардлуудын хүрээнд судалгааг хийж гүйцэтгэлээ. Тэтгэмж, урамшуулал, дэмжлэг, нөхөн олговор болоод нийгмийн халамж хэлбэрийн бусад зардлуудыг хөтөлбөр бүрээр нь (**Хүснэгт 1**)-д харууллаа.

839,1 тэрбум төгрөгийн зардлууд нь МСҮТ-ийн багш нар, хүүхдээ асран

хамгаалж буй ээжүүд, зорилтот бүлэг, Эрүүл мэндийн даатгалын шимтгэл, инфляцитай уялдуулан халамжийн тэтгэврийг нэмэгдүүлэх, хүүхдийн мөнгөн тэтгэмж, цаа буга маллаж буй малчдын нийгмийн даатгалын шимтгэл зэрэгт төлөвлөгдсөн ба бүгд халамж, тэтгэмж, орлого хэлбэрээр зарцуулагдах ажээ. Хөтөлбөрт тусгагдсан халамж, үйлчилгээнд давхардсан тоогоор (ут халамж, үйлчилгээнд хүүхэд, ажилчин, ажилтан, өндөр настан гэх мэт хүн амын бүхий л давхаргын хүмүүс хамрагдахаар байгааг хүснэгтээс харж болно) 1393,6

Хүснэгт 1. 2018 оны төсөвт тусгагдсан нийгмийн халамжийн зардлууд, зарим хөтөлбөрт хамаарах төрлөөр

Хөтөлбөрүүд	Хөтөлбөрүүдэд тусгагдсан тэтгэмж, урамшуулал, нөхөн олговор болон бусад хэлбэрийн орлогууд	Төсөвлөсөн зардлын хэмжээ сая ам.доллар
Хөтөлбөр 1:	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	1,844.20
Мэргэжлийн боловсрол хөтөлбөр	Албан хаагчид олгох нөхөн олговор	185.80
Хөтөлбөр 2:	Тэтгэврийн санд олгох татаас	531,202.30
Нийгмийн даатгал (Татаас)		
Хөтөлбөр 3:	Цалинтай ээж хөтөлбөр	96,800.00
Нийгмийн халамж	Нийгмийн халамжийг зорилтот бүлэг рүү чиглүүлэх	27,000.00
	Халамжийн тэтгэврийг инфляцитай уялдуулан индексжүүлэх	17,300.00
	Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн эхний шатны үнэлгээ: 684.0 мянган хүүхдэд мөнгөн тэтгэмж олгох	164,160.00
	Цаа буга малладаг иргэдийн нийгмийн даатгалын шимтгэл: 172 иргэн	54.10
Хөтөлбөр 4:	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	25.50
Нийгмийн хамгааллын бодлого, удирдлага	Цэргийн албан хааж байсан иргэдийн НДШ	50.00
Хөтөлбөр 5:	Зөвлөл, хороо, комиссын гишүүдийн ажлын хөлс	198.00
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих		
Хөтөлбөр 6:	Зөвлөл, хороо, комиссын гишүүдийн ажлын хөлс	25.10
Хөдөлмөр эрхлэлтийн бодлого, удирдлага	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	33.60
Хөтөлбөр 7:	Зөвлөл, хороо, комиссын гишүүдийн ажлын хөлс	170.60
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил, хамгаалал	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	18.20
ЕРӨНХИЙ ДҮН		839,067.40
ТӨСВИЙН ЗАРЛАГАД ЭЗЛЭХ ХУВЬ		8.54

Эх сурвалж: Монгол Улсын 2018 оны төсвийн баримт бичиг

мянган хүн хамрагдахаар байна.² 2007-2016 оны хүн амын статистикийн мэдээллийг ашиглан эдгээр онуудын дундаж өсөлтөөр 2018 оны хүн амын өсөлтийг ойролцоогоор 2 хувь байхаар судлаачийн зүгээс таамаглалаа. Уг таамаглалаа ашиглавал нийт хүн амын 43,8% нь дээрх хүснэгтэд харуулсан тэтгэмж, тэтгэвэр, нөхөн олговор болоод нийгмийн даатгалын шимтгэл хэлбэрээр нийгмийн халамж, үйлчилгээнд хамрагдах боломжтой ажээ. Харин ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал болоод

зөвлөл, хороо, комиссын гишүүдийн талаарх тоон мэдээлэл байгаагүй учир эдгээрт хамрагдах хүмүүсийн тоо энд ороогүй гэдгийг тэмдэглэе. Хэрэв эдгээр хүмүүсийг тооцон үзвэл нийгмийн халамж, үйлчилгээнд хамрагдах хүний тоо нэмэгдэх нь ойлгомжтой ба хүн амын бараг тал хувь нь ямар нэгэн хэлбэрээр нийгмийн халамж, үйлчилгээг авах ажээ. Үүнээс гадна “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндэсний хөтөлбөр” төсөлд зориулан 42250 сая төгрөг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны

² Тэтгэмж, урамшуулал, дэмжлэг, нөхөн олговрын зарим зардлыг төсөвлөхдөө хамрагдах хүний тоог харгалзан үзсэн байв. Харин ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал болон зөвлөл, хороо, комиссын гишүүдэд олгох ажлын хөлс зэргийг тооцохдоо хамрагдах хүний тоог харгалзахгүйгээр төсөвлөсөн гэж үзэхүйцээр тоонуудыг төсөвт тусгажээ.

институт 529,1 сая төгрөг, Хараагүй хүмүүсийн хөдөлмөр, сургалтын үйлдвэрт 325,2 сая төгрөг, нийт залуучууд болон оюутны 40%-ийг хамруулан сургалт, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулахаар Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газарт 431,0 сая төгрөгийг тус тус төсөвлөсөн байна. Гэр бүлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 2016 оны статистикийн мэдээлэлд тулгуурлан Монгол улсын

нийт өрхийн 40% буюу 347940 өрхийг зорилтот бүлэг болгон "Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөр"-ийн хүрээнд 2018 оны төсөвт 186 сая төгрөг төсөвлөжээ. Эдгээр байгууллагууд тухайн төсвийг үр ашигтай зарцуулж чадвал халамж, тэтгэмж, урамшуулал хэлбэрээс ч илүү өгөөжтэй байж болох ажлуудад нэлээд мөнгө төсөвлөжээ гэж судлаачийн зүгээс харж байна.

ХҮН АМЫН БҮХИЙ А ДАВХАРГЫГ ХАМАРДАГ САЛБАРУУДЫН ЗАРДЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ШИНЖИЛГЭЭ

Нийгмийн бодлогын талаархи судалгаанууд болоод нийгмийн бодлогын онолын үзэл баримтлалаар эрүүл мэнд, халамж үйлчилгээ, боловсрол зэрэгт зарцуулж буй зардлын үр өгөөж чухал нөлөөтэй байдаг билээ. Иймд манай улсын боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээнд зарцуулж буй зардлын өөрчлөлтийг хувиар тооцон шинжлэв.

Хавсралт 1-д Эрүүл мэнд, Хөдөлмөр, Нийгмийн хамгаалал, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын зардлын өөрчлөлтийг харуулав. 2018 оны төсөвт өмнөх жилтэй харьцуулбал эрүүл мэндийн зардлыг 14,43%-иар, боловсролын салбарт зарцуулах зардлыг өмнөх жилээс 19,18 хувиар тус тус өсгөж төлөвлөсөн гэжээ.

Харин 2016 оны гүйцэтгэлтэй харьцуулбал 2017 онд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын зардлын гүйцэтгэл өссөн хэдий ч өмнөх жилээс өсөлтийн хувь нэлээд доогуур бөгөөд 2018 онд уг зардлыг 8,08 хувиар нэмэгдүүлэн төлөвлөсөн байна. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын зардлын өсөлт нь 4 (нийгмийн халамж, үйлчилгээний хүн ам руу чиглэсэн зардлын бүтэц)-т дурдсан тэтгэмж, тэтгэвэр, халамж, урамшуулал зэрэгтэй холбоотой юм. Энэ нь нийгмийн халамжийн тэтгэврийг инфляцийн түвшинтэй уялдуулан ойролцоогоор 8 хувиар нэмэгдүүлэхээр төсөвлөсөн ба инфляцийн зохицуулалтаас үүдэн нийгмийн халамж, үйлчилгээний зардал 17381,9 сая төгрөгөөр өссөн өссөнтэй холбоотой байна.

АЖИЛЛАСАН ЖИЛ БОЛОН ДУНДАЖ ЦАЛИНГААС ХАМААРСАН ХАЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮР ӨГӨӨЖИЙН ШИНЖИЛГЭЭ

Аливаа төслийг хэрэгжүүлэхийн тулд зардал болон үр өгөөжийн харьцуулсан шинжилгээнүүдийг хийж гүйцэтгэдэг билээ. Үүнтэй адил цалингийн үр өгөөжийг тооцох боломжтой байдаг. Иймээс ажил эрхэлдэг хүмүүсийн 2016 оны улсын дундаж цалин, эрэгтэй,

эмэгтэйчүүдийн дундаж цалин болон амралтын хугацааг ялгаатайгаар авч цалингийн үр өгөөжийг тооцох шинжилгээг гүйцэтгэв. Өөрөөр хэлбэл, тухайн хүн цалин болон түүнтэй адилтгах орлогын хүрээнд нийгмийн бодлого талаасаа хэр зэрэг үр өгөөж хүртдэг вэ?

гэдгийг сонирхож байна гэсэн үг юм. (**Хавсралт 2**-ийг үзнэ үү).

Цалингийн үр өгөөжийг тооцоход дараах таамаглалуудыг тавихаас гадна өөдрөг үзлээр шинжилгээг хийж гүйцэтгэсэн гэдгийг цохон тэмдэглэе.


Урьгач нөхцөл 1. Ажилгүй болж буй бүх хүмүүст хуулийн дагуу 3 сартай тэнцэх хэмжээний цалин, хөлсийг ажил олгогч байгууллагаас нөхөн төлбөр хэлбэрээр олгодоггүй бол цалингаас үр өгөөж хүртэж чадахгүй.

Урьгач нөхцөл 2. Эрүүл мэндийн даатгал төлж буй бүхий л хүмүүс тухайн жилдээ эрүүл мэндийн ямар нэгэн үйлчилгээ аваагүй (эрүүл мэндийн

үйлчилгээ авсан тохиолдолд эрүүл мэндийн даатгалаараа үйлчлүүлдэг) бол уг төлбөрийг улсаас буцаан олгодог тогтолцоог бүрэн нэвтрүүлсэн тохиолдолд үр өгөөж хүртэх боломжтой.

Тогорхойлолт: Үр өгөөж бол амралтын хугацаанд олгогдож буй амралтын мөнгө, эрүүл мэндийн даатгалын буцаан олголт, эрүүл мэндийн даатгалаараа үйлчилгээ авч чаддаг, байгууллагын зүгээс төлдөг нийгмийн даатгалын шимтгэл зэрэг хэлбэрээр ажил эрхэлж байгаа болон ажилгүй болсон хүмүүст нийгмийн бодлогоор дамжин олгогдож байгаа мөнгөнөөс хүртэж буй өгөөж юм.

Зураг 2. Цалингийн үр өгөөж



Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Энг: Диаграммын дээд талд байгаа хаалтанд бичсэн 2 тооны таслалын өмнөх тоо нь нийт цалингаас хүртэж буй үр өгөөжийн түвшинг, таслалын арын тоо нь амралт эдлэх хугацааг долоо хоногоор тус тус харуулна. Жишээлбэл, **(0.279,2)** гэдэг нь нийт цалингийн 27,9 хувьтай тэнцэх үр өгөөжийг амралтын хугацаа, нийгмийн даатгалын шимтгэл болон эрүүл мэндийн даатгалын буцаан олголтоос хүртдэг болохыг, 2 долоо хоногтой тэнцэхүйц хугацааны амралт эдэлдэг гэдгийг харуулна.

Улсын дундаж түвшин (2016 оны

улсын дундаж цалин 1007,1 мянган төгрөг)³ -ий цалингийн орлоготой, 2 долоо хоногтой тэнцэх хугацаанд амардаг эрэгтэйчүүд цалингийн орлогынхоо 27,9%-тай тэнцэх хэмжээний үр өгөөж хүртэж байна. Харин улсын дундаж түвшинтэй тэнцүү цалингийн орлоготой, 3 долоо хоногтой тэнцэх хугацаанд амардаг эмэгтэйчүүд цалингийн орлогынхоо 30,3 хувьтай тэнцэхүйц үр өгөөж хүртэж байна. Эндээс үзвэл ажилласан жил нэмэгдэх бүрт амралтын хугацаа өсч улмаар цалин болон түүнтэй адилтгах орлогоос хүртэх үр өгөөж нэмэгдэж

³ Статистикийн эмхэтгэл, 2016

байгааг харж болно. Жишээлбэл, багш нар 48 хоног буюу ойролцоогоор 7 долоо хоногтой тэнцэх хугацаагаар амардаг билээ. Иймд багш нарын цалин болон түүнтэй адилтгах орлогоосоо хүртэж буй үр өгөөж 39,9 хувьтай тэнцүү байна. Энэ бүхнээс ажилчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах болон эрүүл мэндийн

даатгалын буцаан олголтын тогтолцоог бүрэн нэвтрүүлж чадвал цалин болон түүнтэй адилтгах орлогын үр өгөөжийг нэмэгдүүлэх боломж байгааг цаашдаа анхаарах шаардлагатай юм.

Цэргийн албан хаагч, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн халамж,

ЗАРИМ ОНЦЛОГ ШИНЖТЭЙ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ, ХАЛАМЖИЙН ЗАРДЛЫН ТАЛААР

үйлчилгээний зардлын өөрчлөлтөд энэ хэсэгт анхаарлаа хандуулав. Хавсралт 3-аас үзвэл цэргийн албан хаагчийн тэтгэврийн хэмжээ жилээс жилд өсөх хандлагатайгаар өөрчлөгдөж байна. Харин хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгож буй халамжийн орлогын өсөлт буурсан байна. 2007-2016 оны дундажаар тооцон үзвэл Монгол улсад 67,4 мянган хөгжлийн бэрхшээлтэй иргэд байдаг гэсэн статистик байна. Гэтэл 2015, 2016 оны байдлаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо 70,0 гаруй болж нэлээд өссөн дүр зураг харагдлаа. Иймээс төрөөс хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хандсан халамж, үйлчилгээнд зарцуулах мөнгийг бууруулан төсөвлөж байгааг харгалзан үзэж хувийн болоод төрийн бус байгууллагууд нийгмийн хариуцлагын үйл ажиллагаагаараа дамжуулан дэмжих боломж гарч ирж болох юм. Өөрөөр хэлбэл, төрийн бус байгууллага болон хувиараа бизнес эрхлэгчдийн нийгмийн хариуцлагын хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэд рүү чиглэн хийсэн ажлын үр дүнг харгалзан татаас хэлбэрээр мөнгө олгох замаар төрийн ачааллыг бууруулах хувилбар байж болох юм.

Дээр өгүүлсэн эерийн гийн халамж, үйлчилгээг зайлшгүй чиглүүлэх ёстой салбар бол боловсролын салбар билээ. Иймд боловсролын салбарт ажиллаж буй багш нарын тооны өөрчлөлтөд анхаарлаа хандуулаа. Бүх шатны боловсролын

байгууллагад ажиллаж буй багш нарын тооны өөрчлөлтийг хавсралт 4-өөс харна уу. Өмнөх жилд харьцуулсан хувиар тооцсон тооцоолоос харвал мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн салбарт ажиллаж буй багш нарын тооны өөрчлөлтийн хувь ихээхэн хэлбэлзэлтэйгээр өөрчлөгдөж улмаар 2014-2015 оны хичээлийн жилд мэргэжлийн сургалт үйлдвэрлэлд ажиллаж буй багш нарын тоо 8 хувиар буурчээ. Үүнээс гадна сүүлийн хоёр жилийн байдлаар Их, дээд сургууль, коллежид багшилж буй багш нарын тооны өсөлт нэлээд буурах хандлагатай болжээ.

Нийгмийн бодлогын хүрээнд анхаарлаа хандуулах өөр нэг асуудал нь өвчлөгсдийн тоо болоод өвчний тархалт байж болох юм. Өөрөөр хэлбэл, эрүүл мэндийн асуудал байж болох юм. Иймд эрүүл мэндийн талаархи зарим үзүүлэлтийг ашиглан гүйцэтгэсэн судалгааны үр дүнг хавсралт 5-аас харна уу. Халдварт өвчнөөр өвчлөгсдийн тооны өөрчлөлтийг онцлон авч харуулаа. Хавсралтаас үзвэл 2010 онд гар, хөл амны өвчин, 2012 онд гахайн хавдар зэргээр өвчлөгсдийн тоо нэлээд өндөр байжээ. Харин улаан бурханаар өвчлөгсөд 2015 онд 23464 байсан бол 2016 онд 30273 болж өссөн байна. Мөн трихомониаз, улаан эсэргэнэ зэрэг өвчтөний тоо нэлээд өсөх хандлагатай байна.

ДҮГНЭЛТ

Нийгмийн бодлогын хүрээнд төрийн бодлогын төлөвлөлт болоод нийгмийн бодлого хэр үр өгөөжтэй байгаа талаар хийсэн судалгааны ажилдаа тулгуурлан дараах дүгнэлтүүдийг өгч байна.

1. Нийгмийн халамж, үйлчилгээг үзүүлэгч байгууллагуудын зорилтуудыг төсөвт тодорхой тусгах хэрэгтэй байна. Өөрөөр хэлбэл, Халамж, үйлчилгээ авсан хүн ямар түвшинд байсан тухайн халамж, үйлчилгээг авсанаар ямар дэвшилттэй өөрчлөлт гарсан байх ёстой вэ? гэдгийг тодорхой тусгадаг байх шаардлагатай байна.
2. Тодорхой хөтөлбөрт зориулан зардал төсөвлөж байгаа хэдий ч хөтөлбөрийн хүрээнд зорилтуудыг дэвшүүлэх шаардлагатай байна. Жишээлбэл, халдварт өвчний тоог хэрхэн яаж бууруулах, халдварт өвчний талаарх мэдлэгийн түвшинг яаж дээшлүүлэх гэх мэт.
3. Халамж, үйлчилгээ болоод бусад урамшуулал, тэтгэмжид хамрагдах хүмүүсийн тооны статистикийг тодорхой тусгадаг байх шаардлагатай болов уу. Жишээлбэл, Хөдөлмөр эрхлэлтийн бодлого, удирдлага гэсэн нэгжийн түвшинд зөвлөл, хороо, комиссын хөлсөнд мөнгө төсөвлөсөн хэдий ч хэдэн хүнд олгох нь тодорхой бус байна.
4. Нийгмийн халамж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах талаар төсөвтөө тодорхой тусгах хэрэгтэй байна. Өөрөөр хэлбэл, эрүүл мэндийн яам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам ямар хөтөлбөрийн хүрээнд ямар ямар чиглэлээр хамтран ажиллах боломжтой вэ? гэдгийг төсөвт тусгах нь зүйтэй болов уу?
5. Цалин болон түүнтэй адилтгах

орлогын үр өгөөжийг нэмэгдүүлэхэд цаашдаа анхаарах нь чухал байна.

Нийгмийн бодлогын хөтөлбөр, төсвийг боловсруулахдаа анхаарах зөвлөмжүүд

- (1) Эрүүл байх нөхцөл байдлыг өдөөгч хүчин зүйлс (жишээлбэл, явган аялал, уралдаан тэмцээн гэх мэт)-ийг урамшуулах байдлаар зардлыг төсөвт суулгах шаардлагатай байна.
- (2) Хувийн болон нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний балансыг тэнцвэржүүлэхэд нэлээд анхаарлаа хандуулах ёстой. Өөрөөр хэлбэл, ямар хэлбэрийн өвчин болон өвчтөнг төрөөс зайлшгүй хариуцах, ямар хэлбэрийн өвчин болон өвчтөнг хувийн байгууллагууд бүрэн хариуцах боломжтой вэ? гэдэг талаар бодолцох нь балансыг хангахад чухал ач холбогдолтой юм. Нөгөө талаар төрийн ачааллыг ч бууруулах сайн талтай байж болох юм.
- (3) Урамшуулах, урьдчилан сэргийлэх, оношлох, эмчлэх, нөхөн сэргээх болон нийгмийн халамжийн бодлогын хоорондын тэнцвэрийг хангахад анхаарах нь чухал болов уу? Урьдчилан сэргийлэх, оношлох үйл ажиллагааг сайн зохион байгуулж буй байгууллагад ч гэсэн төрөөс урамшуулал хэлбэрээр татаас өгвөл нийгмийн халамжийн бодлогын ачаалал буурч болох юм.
- (4) Ямар эмчилгээ, сувилгаа бусдаас давамгайлах ёстой вэ? Өөрөөр хэлбэл, ямар, ямар төрлийн өвчнөөс урьдчилан сэргийлсэнээр бусад хэлбэрийн өвчний өвчлөл, өвчний тархалтыг зогсоох боломжтой вэ? гэдэгт эрүүл мэндийн яам цаашид анхаарч ажиллах ёстой гэсэн үг юм.
- (5) Тусламж, үйлчилгээ үзүүлэгч, эсвэл нийгмийн халамж руу чиглэсэн байгууллагуудад зөв хөшүүргийг


бий болгохын тулд ямар шалгуураар санхүүжилтийг хуваарилах нь илүү үр ашигтай, зохистой байж болох вэ? Ялангуяа хувийн эмнэлгүүдэд нийгмийн халамж руу чиглэсэн үйлчилгээ үзүүлдэг гэж үзээд мөнгөн хэлбэрийн тусламжийг байнга олгодог. Тусламж авсан хувийн эмнэлэг болон халамжийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд эрүүл байхын ач холбогдлыг хүмүүст таниулах ажлыг хэдэн удаа, хэрхэн зохион байгуулсан, ямар үр дүнд хүрсэн гэх мэт шалгууруудаар олгодог

зохицуулалт руу шилжиж болох юм.
 (6) Эрүүл мэнд болоод халамжийн үйлчилгээний ажилчдын урамшуулалт цалин хөлсийг хүн бүрт үр ашигтайгаар гүйцэтгэлийн урамшуулал болохуйцээр хэрхэн олгох, цаашилбал халамжийн үйл ажиллагаа явуулдаг байгууллагын ажилчдад урамшуулалт цалинг хэрхэн хуваарилбал үр ашигтай байх вэ? Энд нөөц хуваарилалтын оновчтой аргуудыг ашиглах талаар цаашдаа анхаарах хэрэгтэй болов уу?

НОМ ЗҮЙ

1. Alan Walker, Chack-kie Wong, The relationship between social policy and economic policy: Constructing the public burden of welfare in China and West, 2009
2. Atkinson, A. & Stiglitz, J. (1980) Lectures on Public Economics, London, McGraw-Hill.
3. Okun, A.M. (1975) Equality and Efficiency: The big Trade-off, Washington DC, Brooking Institution.
4. Sainsbury, D. (ed.) (1994) Gendering Welfare States, London, Sage
5. 2018 оны төсөв
6. 2007-2016 оны статистикийн эмхэтгэл
7. 1212.mn сайт

Хавсралт 1. Эрүүл мэнд, хөдөлмөр-нийгмийн хамгаалал, боловсрол-соёл, шинжлэх ухаан, спортын зардлын өсөлт, өмнөх жилтэй харьцуулсан өсөлтийн хувиар



Эх сурвалж: Статистикийн эмхэтгэл, 2016

Хавсралт 2. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ болон дундаж цалингийн үр өгөөж


Ажилласан хугацаа	Жилийн цалин мян.төг	Амралтын үр өгөөж	25%, Ажилгүй длийн тэтгэмжийн үр өгөөж	7, ор хоног*	10%, Нийгмийн даатгалын үр өгөөж	10%, эрүү мэндийн даатгалын үр өгөөж	Нийт үр өгөөж	Нийт үр өгөөжийн нийт цалинд эзлэх жин	
Эрэгтэй	Улсын дундаж	2	464.9	116.2	371.9	1,208.7	1,208.7	3,370.5	0.279
	Дундаж хугацаагаар ажилласан хүн	3	697.3	174.3	371.9	1,208.7	1,208.7	3,661.0	0.303
	Олон жил ажилласан хүн	4	929.8	232.4	371.9	1,208.7	1,208.7	3,951.6	0.327
Эмэгтэй	Багш нар	7	1,627.1	406.8	371.9	1,208.7	1,208.7	4,823.3	0.399
	Улсын дундаж	3	609.1	152.3	324.9	1,055.8	1,055.8	3,198.0	0.303
	Дундаж хугацаагаар ажилласан хүн	4	812.2	203.0	324.9	1,055.8	1,055.8	3,451.8	0.327
	Олон жил ажилласан хүн	5	1,015.2	253.8	324.9	1,055.8	1,055.8	3,705.6	0.351
Багш нар	6	1,218.3	304.6	324.9	1,055.8	1,055.8	3,959.4	0.375	

Эх сурвалж: Дундаж цалингийн мэдээллийг 1212.mn сайтаас авлаа.

Тайлбар: *-12 сарын 3 сартай тэнцэх хэмжээний тэтгэмжийг ажил олгогчоос олгодог гэдгийг харгалзан ажилгүйдлийн түвшинг тооцов.


** - Статистикийн мэдээлэлд тулгуурлан 1000 хүнд оногдох дундаж ор хоногоор тооцов.

Хавсралт 3. Нийгмийн халамжийн бодлогын хүрээнд олгосон тэтгэврийн хэмжээ, сар, төгрөг




Эх сурвалж: Статистикийн эмхэтгэл, 2016

Хавсралт 4. Бүх шатны боловсролын байгууллагад ажилладаг багш нарын тооны өөрчлөлт, хувиар



Эх сурвалж: Статистикийн эмхэтгэл, 2016

Хавсралт 5. Халдварт өвчнөөр өвчлөгсдийн тооны өөрчлөлт, өмнөх жилд харьцуулсан харьцаагаар



Эх сурвалж: Статистикийн эмхэтгэл, 2016

ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ 80 ХУВЬТАЙ ТЭНЦЭХ ӨРТЭЙ ТӨСӨВ

С.Батзаяа
Сэтгүүлч

Монгол гэдэг их айл ирэх онд 7.2 их наядын орлого олж 9.6 их наядыг зарлагадахаар тооцжээ. Үндсэндээ 2.4 их наяд гаруй төгрөгийн алдагдал хүлээж байгаа нь ДНБ-ий найман хувьтай тэнцэж буй юм. Хоёр ч Засгийн газар дамнан боловсруулсан 2018 оны төсвийг эрх баригчид 10 хүрэхгүй хоногийн дотор баталлаа. Төсвийн хуулиар тухайн жилийн төсвийг аравдугаар сарын 1-ний өдөр өргөн барьж, арваннэгдүгээр сарын 15-ны дотор батлах ёстой. Нэг ёсондоо 45 хоног хэлэлцдэг төсвийг улс төрийн нөхцөл байдлаас шалтгаалж энэ удаа 10 хоногийн дотор хэлэлцэн, сүүлдээ шөнө дөл хүртэл хуралдаж байж, арайхийн хуулийн хугацаандаа багтаалаа. Цаг хугацааны хувьд давчуу энэ төсөвт он гараад дахин тодотгол хийх нөхцөл байдал үүсэх юм биз гэх болгоомжлол байна. Батлагдсан төсөвт тодотгол хийх нь төсвийн сахилга батыг алдагдуулж буйн сонгодог жишээ гэж эдийн засагчид үздэг. Цаашлаад төсвийг ойр ойрхон тодотгох нь жижиг 76 тойрог буюу мөжаратар системээр сонгууль явуулсан энэ үед гишүүд тойрог руугаа мөнгө хуваарилуулах шалтаг болж, сул төсөв болдог. Сайн төсөв баталсан бол тодотгол хийх шаардлагагүй гэдгийг ч судлаачид хэлж байна. Уг нь олон улсад төсвийн алдагдал өндөр үед төлөвлөөгүй орлого орж ирвэл ирэх жилийн төсөвт хадгалдаг жишигтэй. Харин манайд бага зэрэг орлого илүү гарвал түүнийгээ юунд зарцуулах вэ гэх хэрүүл хийж байх. Уг нь ирэх оны төсвийн төслийг хэлэлцэх үед дараагийн хоёр жилийн төлөвийг хамтад нь хэлэлцүүдэг. Үүнийг ирэх онуудад төсвийн төлөвлөлтөө хэр сайн хийв


гэдгийг шалгаж байгаа хэмжүүр ч гэж ойлгож болох.

Засгийн газар ирэх онд зээлийн хүүгийн зардалд 1.2 их наядыг зарцуулахаар байна. Манай улс ирэх онд "Чингис" бондын 500 сая, "Дим сам" бондын 161 сая ам.долларыг төлнө. Үүнийг өрийг өрөөр санхүүжүүлэх хэлбэрээр буюу "Гэрэгэ" бонд арилжаалж, төлөхөөр болсон. Үндсэндээ бид өрийг өрөөр дарахын тулд зээлд авдаг болсон нь хүүгийн зардлыг өсгөх нэг шалтгаан болж байна. Товчхондоо, долоо их наяд гаруйн орлого олоод 1.2 их наядыг нь зөвхөн зээлийн хүүгийн төлбөрт төлөхөөр байгаа юм. Энэ нь улсын төсвийн орлогын 15 хувь гэсэн үг. Үүнээс Монгол Улсын төсөв ямар эрсдэлтэй байдалд байгааг харж болохоор байна. Цаашид бид одоо авсан зээлүүдээсээ өндөр хүүгээр зээл авбал хүүгийн дарамт жил ирэх тусам нэмэгдэх дүр зураг харагдаж байна. Энэ талаар УИХ-ын эдийн засагч гишүүдийн нэг Б.Жавхлан "Сүүлийн 10 гаруй жил Монгол Улсын төсвийн бодлого биш тойргийн төсөв ярьж, баталсаар ирлээ. Энэ удаагийн төсөв ч мөн ялгаагүй. Сүүлийн хоёр жилийн төсвийн онцлог нь ОУВС-тай хамтарч хэрэгжүүлж буй хөтөлбөрийн хүрээнд хайрцаглагдаж орж ирж байгаагаараа онцлог. 2017 оны төсөв анх өргөн баригдахад сахилга баттай байсан. Харамсалтай нь, нэг жилийн дотор хоёр ч удаа тодотгол хийсэн. Яг төсөв хэлэлцэх үеэр гишүүд тойрогтоо нэг цэцэрлэг, сургууль бариулна гээд зүтгэдэг. Энэ нь УИХ-ын гишүүдийн буруу биш. Сонгуулийн хууль, тогтолцоо нь өөрөө төсвийг бодлогын хэмжээнд,

бодлогын загвараар явуулах боломж олгодоггүй юм байна" гэлээ. Ирэх онд манай улс 7.2 их орлого олохоос нэг их наяд гаруйг нь нийгмийн даатгал халамжид зарцуулна. Манай улсын төсвийн бодлого нийгмийн

хамгаалал халамж тал руугаа илүү их зарцуулагддаг. Гэтэл хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хүрээнд 65 тэрбум, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжихэд 70 гаруй тэрбум төгрөг төсөвлөсөн нь учир дутагдалтай байгааг зарим УИХ-ын

Зураг 1. Засгийн газрын өрийн нийт хэмжээ



Зураг 2. 2018 оны төсвийн орлого зарлага /төсөл/



Зураг 3. 2018 оны зардлын төсөв /төсөл/



гишүүн хэлж байсан юм. З.Нарантуяа гишүүн энэ талаар "Төсөв, мөнгөний бодлогын эцсийн зорилго нь ажлын байрыг нэмэгдүүлэх, иргэдийг өөрийнхөө хөдөлмөрөөр амьдрах боломжийг нь дэмжихэд чиглэсэн байх ёстой. Гэтэл энэ удаагийн төсвийн бодлого энэ шинжийг агуулаагүй байна" хэмээсэн юм.

2018 оны зарлагыг задалж үзвэл, цалин хөлс 24.1 хувь, бараа үйлчилгээний бусад зардал 19.5 хувь, зээлийн хүүгийн зардал 15.4 хувь, татаас ба урсгал шилжүүлгийн зардал 40.9 хувь байна. Ирэх онд эдийн засгийн өсөлтийг 4.2 хувь байхаар оруулж ирсэн нь шүүмжлэл дагуулж байна. УИХ-ын гишүүн Л.Энх-Амгалан "Ирэх онд эдийн засгийн өсөлт 4.2 хувь байхаар тооцсон нь чамлалттай үзүүлэлт. Эдийн

засгийн нэг хувийн өсөлтийн цаана 10 мянган хүн ажилтай болох боломж байдаг гэх тооцоо бий. Монголын эдийн засаг жижиг. Нэг тэрбум ам.долларын төсөл хөдөлгөхөд 10 хувийн эдийн засгийн өсөлт хийнэ. Уг нь хүнд юм биш. Даанч энэ танхимд суугаа хэдхэн улсуудаас болоод цахилгаан станц, төмөр замын төслүүд гагцхисан. Хэрэв бид УИХ-аас баталсан Монгол Улсыг хөгжүүлэх бодлогын баримтаа хэрэгжүүлэе гэвэл жилд 10-15 хувийн эдийн засгийн өсөлт гаргаж байж, нэг хүнд ногдох ДНБ-ээ 10 мянган ам.долларт хүргэнэ. Гэтэл жил бүр өрийн хэмжээ өссөөр 26 их наяд төгрөгт хүрлээ. 2020 онд улсын төсвийн алдагдлыг 1.6 их наяд байхаар тооцсон. Энэ бүхнээ одоо ярьж, цэгцлэх ёстой. Ингэхгүй бол

Хүснэгт 1. «Цалинтай ээж» хөтөлбөр

		Хүний тоо мянга	Тэтгэмжийн хэмжээ мян.төг
0-3 насны хүүхдээ асарч байгаа эхэд	сар бүр	135	50
3 ба түүнээс дээш 0-18 насны хүүхэдтэй өрх толгойлсон/эцэг	улирал бүр	16.5	240
НИЙТ			96.8 тэрбум

Хүснэгт 2. 2018 онд төсвийн төсөлд тусгасан халамжийн бодлого /тэрбум төгрөг/


164.2	“Хүүхдийн мөнгө” хөтөлбөр	23.4	“Элэг бүтэн Монгол” хөтөлбөр
137.4	Тэтгэвэр тэтгэмж нэмэх	20.5	Насны хишиг
72.8	“Цалинтай ээж” хөтөлбөр	12.6	Сургалтын төлбөрийн буцалтгүй тусламж
55.5	Нэн ядуу, эмзэг бүлэгт чиглэсэн халамж	9.2	Эмзэг бүлгийн иргэний ЭМД
44.6	Малчны тэтгэвэрт тогтоолгох насыг 5 жилээр бууруулах	4.0	Өрхийн 3 ба түүнээс дээш хүүхэд нь их, дээд сургуульд зэрэг суралцаж байгаа бол санхүүгийн дэмжлэг үзүүлэх

төрийнхөө бодлоготой уялдахгүй байна” хэмээн чуулганы хуралдааны үеэр байр сууриа илэрхийллээ.


Ирэх оны төсөвт судлаачид анализ хийж байгаа аж. Тэдний нэг СЭЗДС-ийн Санхүүгийн удирдлагын тэнхмийн ахлах багш Ш.Батцэнгэл “Төсвийн алдагдал

бага зэрэг буурсан нь сайн хэрэг ч ирэх жилийн алдагдлын дийлэнхийг бондын эргэн төлөлтэй холбож тайлбарлаж байна. Өрийн дарамт нэмэгдэж байгааг анхаарах хэрэгтэй. Ирэх жилүүдэд төсөв алдагдалтай гарах учраас төсвийн үндсэн төлбөрийн дарамт нэмэгдэнэ. Өрийн хэмжээ ДНБ-ий 80 хувьтай тэнцэж

Зураг 5. Төсвөөс нийгмийн халамжид зарцуулах хөрөнгө



Зураг 6. ДНБ-ий бодит өсөлтийн хэмжээ



Зураг 7. Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ



байгаа ч энэ өрөө хэзээ яаж төлөх вэ гэдэг нь асуудал дагуулдаг. Өрийг өрөөр санхүүжүүлэх, орлогоо өсгөх хоёр л боломж бий. Төсвийн алдагдал төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг

мөрдөж байгаа ч цаашид алдагдлын шалтгаан юу байв гэдгийг тодорхойлох шаардлагатай” гэв. Манай улсын өрийн ихэнх хувийг дотоод, гадаадын өр эзэлж байгаа. Энэ нь Засгийн газар

дунд хугацаанд төсвийн төлөвлөлтдөө эрс өөрчлөлт хийх шаардлага үүсч буйг илэрхийлж байх. Товчхондоо, дотоод, гадаадаас зээлж байгаа өрийн зөв бүтцийг бүрдүүлэх, өрийн хэмжээг дунд хугацаанд бууруулах арга хэмжээ авахгүй бол төсвийн алдагдлын 70-80 хувь нь дотоод, гадаад өрийн хүүгийн төлбөр болоод байгаа. Иймээс төсвийн төлөвлөлтийг цаашид боловсронгуй болгохын тулд дотоод, гадаад өрийн зохист харьцааг тодорхой болгох шаардлага үүсч байна. Ялангуяа Засгийн газар дотоодод гаргаж байгаа бондыг багасгахгүйгээр зээлийн үйлчилгээний хүүгийн төлбөрийг багасгах боломжгүй юм.

УИХ-аас ирэх оны төсвийн төслийг судлах, анализ хийх ажлын хэсэг байгуулсан. Энэ ажлын хэсгийг УИХ-ын гишүүн Д.Тогтохсүрэн ахалсан юм. Тэрээр "Манай ажлын хэсэг 2018 оны төсвийн төслийг гурван зарчмыг үндэслэн судаллаа. Нэгдүгээрт, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нийцэж байгаа эсэх. Энэ шаардлагыг хангасан байна. Тухайлбал, төсвийн алдагдал 9.5 хувь байх ёстой. Засгийн газар найман хувьтай байхаар тооцож оруулж ирсэн. Хоёрдугаарт төсвийн хүрээний мэдэгдэлд нийцэж байна уу, үгүй юү гэдгийг нягталсан. Үүнд бүрэн нийцэж байгаа. Гуравдугаарт, Засгийн газар орлого нэмэгдүүлэх, зарлага бууруулах алхам хийсэн эсэх. Орлогыг өмнөх оныхоос 690 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн оруулж ирсэн байна лээ. Төсвийн зарлагыг 497 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн байна. Энэ нь хөрөнгө оруулалтын төслүүд, зарим нэг сайдын урсгал зардал нэмэгдсэнтэй холбоотой" гэх байр суурийг илэрхийлсэн.

Дэлхийн зах зээл дээр уул уурхайн бүтээгдэхүүний үнэ өсч буй. Үүнтэй холбогдуулан ирэх оны төсөвт зэсийг 6430 ам.доллараар тооцжээ. Зэсийн үнэ манай эдийн засагтай шууд холбоотой. Тиймээс

үнэ буурвал яах вэ гэдэг арга хэмжээний төлөвлөгөө бэлэн байх ёстой. Энэ талаар МУИС-ийн Бизнесийн сургуулийн Санхүүгийн тэнхмийн зөвлөх профессор Г.Намжил "Гадаадад гаргаж байгаа уул уурхайн бүтээгдэхүүний дэлхийн зах зээлд өсөх, буурах нь төсвийн орлогод шууд нөлөөлдөггүй. Төсвийн орлогод нөлөөлж байгаа ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, бусад төлбөрүүдээс орох орлого төсвийн орлогыг бүрдүүлэх гол үүрэгтэй. Төсвийн зарлага хөрөнгийн, хөгжлийн төсөв гэж байдаг. Үүнд өөрчлөлт хийж, нэн шаардлагатай хөтөлбөр арга хэмжээг дунд хугацаанд санхүүжүүлэхэд томоохон хөтөлбөр жагсаалт гаргаж ажиллах хэрэгтэй байна. Эдийн засаг тооцож төлөвлөсөн хэмжээндээ хүрэхгүй бол дотооддоо бонд гаргана. ДНБ-ий 4.2 хувийн өсөлттэй байна гэдэг хамгийн том эрсдэл. Төсвийн тогтвортой байдлын тухай хууль зөрчигдлөө гэхэд төсөвтөө байсхийгээд тодотгол хийдэг. Төсвийн тухай хуулиар бүгдийг зохицуулдаг зарчим руу шилжих ёстой" гэсэн юм.

Товчхондоо, 2018 оны төсөв ДНБ-ний найман хувьтай тэнцэх хэмжээний алдагдалтай, 2020 он гэхэд энэ алдагдлын хэмжээг 4.5 хувьд хүргэх төсөөллөөр боловсруулагдсан байна. Засгийн газрын өрийн хэмжээг 2020 онд 70 хувьд хүргэж бууруулах, 4.2 хувийн эдийн засгийн өсөлтийг зургаан хувьд хүргэх зорилт тавьжээ. ОУВС-гийн "Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр" хэрэгжиж байгаа энэ хугацаанд төсвийн сахилга батыг сахиж, зөв гольдрилд нь оруулах чиглэлд ирэх оны төсөв боловсруулагдсан гэж хэлж болохоор байна.

Гэхдээ өр, халамж гэсэн хоёр зүйл ирэх оны төсөвт ч том асуудалт дагуулах нь ойлгомжтой байна. Монгол Улсын хамгийн том "бялуу"-г хуваарилж байгаа энэ цаг улстөрчид ч тойрог руугаа хөрөнгө оруулалт татахаар зүтгэж байгааг тодотгох нь зүйтэй биз ээ.

2018 ОНЫ ТӨСӨВ

2018 оны улсын төсвийг УИХ арав гаруй хоногт хэлэлцэн батлав. Төсвийн төслийг УИХ-аас судлах ажлын хэсэгт ажилласан гишүүдийн 2018 оны Төсвийн талаар илэрхийлсэн байр суурийг хүргэж байна.

ТӨСВИЙН АЛДАГДЛЫГ БУУРУУЛАХ НЬ ӨР БУУРУУЛАХ ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

Ч.ХҮРЭЛБААТАР

УИХ-ын гишүүн, Сангийн сайд

УИХ ИРЭХ ОНЫ ТӨСВИЙГ АРАЙХИЙН ХУУЛИЙН ХУГАЦААНДАА БАТАЛЛАА. ЭНЭ УДААГИЙН ТӨСӨВ ЯМАР ОНЦЛОГТОЙ БОЛОВ?

Богинохон хугацаанд төсөв батлагдсан ч харьцангуй чамбай төсөв болсон гэж хэлнэ. Төсвийн алдагдлыг бууруулж, давсан орлого нэмэлт эх үүсвэрээр өрийн хэмжээг багасгахаар төлөвлөлөө. Ирэх жил боловсролын салбарт 1.6 их наяд төгрөг төсөвлөсөн. Өөрөөр хэлбэл, улсын хэмжээнд нийт 82 сургууль, 127 цэцэрлэг барих ажлыг эхлүүлнэ. Он дамнасан сургууль, дотуур байрны барилгыг барьж дуусгаж, сургуулиудыг гурван ээлжгүй болгож, ээж аавууд цэцэрлэгт хүүхдээ оруулах гэж сугалаанд найддаг цаг ард үлдэнэ. Төсвийн орлогыг аваад үзэхээр хөдөө орон нутгаас төвлөрүүлэх татварын хэмжээ буурах хандлагатай байна. Тиймээс орон нутагт хийх хөрөнгө оруулалтын хэмжээг гурав дахин нэмсэн. Товчхондоо, орон нутгийн санал санаачилгыг дэмжихээр хөрөнгө оруулалт хийсэн л дээ. Орон нутагт 147 тэрбум, улсын төсвөөс 183 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийхээр баталлаа. Энэ нь эдийн засаг царцаж байсныг тэлэх, аж ахуйн нэгжүүдийг ажилтай болгох, эдийн засгийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд онцгой ач холбогдолтой. Дараагийн зүйл нь

газар лицензийг дагасан далд наймаа их явагддагийг цэгцэлнэ. Гараас гарт газрын эрх шилждэг, лиценз борлуулдаг ч Монголд ямар нэг татвар төлөгддөггүй. Үүнийг эмх цэгцэнд нь оруулахаар газар, лицензтэй холбоотой наймааг цэгцлэхээр өөрчлөлт хийхээр оруулж ирсэн. Энэ төсвийн онцлог нь анх удаа ЭМД-ын санг бие даалган оруулж ирж байгаа. Нийт орлого нь 450 тэрбум, жилдээ 40-50 тэрбум үлдэгдэлтэй байдаг уг санг бие даалгаснаар үлдэгдэл хөрөнгийг нийт даатгуулагчдад хүртээх боломж бүрдэнэ гэж үзсэн.

МАНАЙ УЛС ДОТООДОО ӨНДӨР ХҮҮТЭЙ БОНД АРИЛЖДАГ. ЭНЭ НЬ ЭРГЭЭД ТӨСӨВТ АЧААЛАЛ ДАРАМТ ҮҮСГЭДЭГ. ДОТООДЫН БОНДЫГ ҮЕ ҮЕИЙН САНГИЙН САЙД БАГАСГАНА ГЭЖ ЯРЬДАГ Ч ТӨДИЙЛЭН АЖИЛ ХЭРЭГ БОЛДОГГҮЙ. ТАНЫ ҮЕД ЯМАР АХИЦ ДЭВШИЛ ГАРАХ БОЛ?

Дотоодоос арилжааны банкуудаас өндөр хүүтэй зээл авахыг зогсооно. Арилжааны банкуудын чөлөөт үлдэгдлийг төр зээлчихээр иргэд, аж ахуйн нэгжүүдэд очиж байгаа мөнгө бараг байхгүй. Үүнийг зогсоож, Засгийн газар өөрөө зээлдэхээ больчихвол арилжааны банкуудаас иргэд, аж ахуйн нэгжүүд зээл авна. Энэ нь эргээд ажлын байр, хөрөнгө оруулалт, эдийн засгийн өсөлтийг бий болгоно.

Өөрөөр хэлбэл, дотоодын зах зээлд бонд бага гаргана. Төсвийн алдагдлыг бууруулвал өр тавихгүй. Засгийн газар төсвийн хөрөнгийг зөв явуулъя, сахилга баттай байа гэж байгаа. Одоо бол Засгийн газар байгаа мөнгөө бага хүүтэйгээр арилжааны банкуудад зээлүүлчихээд эргээд өндөр хүүтэй зээлж авч байна. Энэ асуудалд төсвийн сахилга бат 100 хувь алдагдсан. Үүнийг болиулах үүднээс Сангийн сайдаар томилогдсоныхоо дараа арилжааны банкуудад хадгалуулсан байсан хөрөнгийг татах шийдвэр гаргасан. Амаргүй юм билээ. Бид арилжааны банкуудын эрх ашгийг алийн болгон бодох юм. Өндөр хүүтэй зээл авч байхынхаа оронд Засгийн газрын санхүү хөрөнгийг зөв удирдаад аваад явах ёстой. Төсвийн сахилга бат, хариуцлагыг манай яам хатуу мөрдөж ажиллана.

ИРЭХ ОНД ТӨЛӨХ БАЙСАН “ЧИНГИС” БОНДЫН 500 САЯ, ДИМ САМ БОНДЫН 160 САЯ АМ.ДОЛЛАРЫН ӨРИЙГ МАНАЙ УЛС “ГЭРЭГЭ” БОНД АРИЛЖИЖ ТӨЛӨХӨӨР БОЛЛОО. НЭГ ЁСОНДОО ӨРИЙГ ӨРӨӨР ДАРЖ БАЙНА. ЭНЭ НЬ ЭРГЭЭД ЭДИЙН ЗАСАГТ ЯМАР ҮР ДАГАВАРТАЙ ВЭ. НӨГӨӨТЭЙГҮҮР ЭНЭ МӨНГӨНИЙ ҮДЭГДЛИЙГ ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭХЭЭР БОЛСОН. МАНАЙХ ГАДНААС АВСАН ЗЭЭЛЭЭРЭЭ ТӨСВИЙН АЛДАГДЛАА САНХҮҮЖҮҮЛЭЭД ЯВААД БАЙНА. ҮҮНИЙГ ЦЭГЦЭЛЖ БОЛДОГГҮЙ ЮМ УУ?

Өрийг бууруулах, өрийн дарамтаас гарах гэдэг Монгол Улсын хувьд тулгамдсан асуудал. Төсвийн алдагдлыг бууруулах нь өр бууруулах үндсэн үзүүлэлт. Монгол Улсын өр байнга нэмэгдэж ирсэн. Төсвөө хэт өөдрөгөөр төсөөлдөг. Нэгэнт суугдсан зардал гэж мөнгө авч хэрэглэсээр байгаад өр нэмэгдчихдэг. Засгийн газрын өр гэхэд 20 гаруй их наяд төгрөг байна. Зээлийн хүүнд бид жилийн төсвийн орлогын 20 гаруй хувийг төлж байгаа. Хүү нь өндөр байна. Өр нэмэхгүй байх, өрийн

үйлчилгээний төлбөрийг багасгахаар ажиллаж байна.

Өндөр хүүтэй бондуудаа бага хүүтэйгээр солих бодлого барьж байна. Ингэж чадвал зээлийн үйлчилгээний төлбөрт төлж байгаа мөнгө багасна. Жишээлбэл, нэг их наяд төгрөгийн 18 хувийн хүүтэй мөнгийг найман хувьтай бондоор сольбол 100 тэрбум төгрөгийн зөрүү гарна. Төсвийн алдагдлыг бууруулахад хамгийн гол хүчин зүйл бол авсан зээлүүдийн хүүнд төлж байгаа мөнгөн дээр анхаарах. Төсвийн алдагдал энэ онд 2.7 их наяд байна. Үүнийг 2018 онд 300 гаруй тэрбумаар бууруулж оруулж ирсэн. Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд 2023 оноос төсвийг алдагдалгүй болгож батална гэж байгаа. Төсвийн төсөөллийг хэлэлцэн батлахдаа жилээс жилд алдагдлыг буулгахаар хийж байна. Хэрэв огцом буулгавал хэд хэдэн асуудал үүснэ. Хөрөнгө оруулалтаа танахаар хөдөө орон нутагт эдийн засгийн идэвхжил саармагжаад байна. Орон нутгийн аж ахуйн нэгжүүд ажилгүй болж, ажилгүйдэл нэмэгдээд эхэлсэн учраас бид хөрөнгө оруулалтыг хасах боломжгүй. Харин төсвийнхөө сахилга батыг нэлээд сайн бариад цаашдаа төсвийнхөө алдагдлыг аажмаар эдийн засагт сөрөг нөлөө үзүүлээд байхгүйгээр бууруулах бодлого барьж байна.

ЖИЛ БҮР ТОМООХОН ОБЪЕКТУУДЫГ ХУВЬЧИЛНА ГЭЖ ЯРЬДАГ. ЭНЭ УДААД Ч ЯРИГДАЖ БАЙНА. ТУХАЙЛБАЛ, ТӨРИЙН БАНКЫГ ХУВЬЧЛАХААР ТӨСӨВТ ТУСГАЛАА. ИРЭХ ОНД ЭНЭ АЖИЛ ХЭРЭГ БОЛНО ГЭЖ ОЙЛГОЖ БОЛОХ УУ. ЕР НЬ ХУВЬЧЛАЛААС ТӨДИЙ ХЭМЖЭЭНИЙ ОРЛОГО ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛНЭ ГЭЭД ТОО ТАВЬЧИХДАГ. ЖИЛИЙН ЭЦЭСТ ЭНЭ НЬ БИЕЛЭЭГҮЙ ТОХИОЛДОЛ БАЙНГА ГАРЧ БАЙНА..?

Төсвийг оруулж ирэхдээ өмч хувьчлалын тухай асуудал яриагүй. Төрийн өмчийн аж ахуйн нэгжүүдийн удирдлага,

менежментийг сайжруулах, шинэчлэхээр ярьж байна. Энэ хүрээнд Засгийн газар өмч хувьчлах үндсэн чиглэлийг УИХ-д өргөн мэдүүлэх ёстой юм байна. Үүн дотор ямар аж ахуйн нэгжүүдийг, яаж

хувьчлах вэ зэрэг бодлогоо тодорхойлоод УИХ-аар ярина. УИХ-аар батлагдсаны дараа хувьчлалын арга хэмжээнүүдийг явуулна.

ХОЁР ЖИЛИЙН ДАРААГААС ТӨСӨВ АЧААЛЛАА ДААХГҮЙД ХҮРНЭ

Д.ТОГТОХСҮРЭН
УИХ-ын гишүүн

2018 ОНЫ ТӨСӨВ ӨМНӨХ ЖИЛҮҮДИЙНХЭЭС ЯМАР ОНЦЛОГТОЙ БОЛСОН БЭ?

Засгийн газар 2018 оны төсвийг аравдугаар сарын 1-ээс өмнө өргөн барьсан. Шинэ Засгийн газар байгуулагдсаны дараа буцааж татаад, зарим нэг өөрчлөлтийг хийгээд УИХ-д өргөн барьсан байгаа. УИХ төсвийн төслийг нэлээн шахуу хэлэлцсэн. Шинэ Засгийн газрын өргөн барьсан төсөв өмнөхөөсөө сайжирсан хэд хэдэн зүйл бий. Нэгд, 2.7 их наяд буюу ДНБ-ий 9.5 хувьтай байсан төсвийн алдагдлыг бууруулаад найман хувьд хүргэсэн. Хоёрт, эдийн засгийн өсөлтийг ирэх онд 4.2 хувьд хүргэнэ гэж үзсэн нь том дэвшил. Шинэ Засгийн газар гарч ирснээсээ хойш хэд хэдэн хөтөлбөрийг хэрэгжүүлнэ гэж ОУВС-тай тохирсон. Өмнө нь ОУВС-аас зөвшөөрөхгүй байсан зүйлүүд дээр ч тохиролцоонд хүрч чадсан. Тухайлбал, төрийн албан хаагчдад олгож байгаа ажлын үр дүнгийн урамшууллыг хэлж болно. 2017 онд 54.9 тэрбум төгрөг, 2018 онд 56 тэрбум төгрөгийг үр дүнгийн урамшуулаар өгөхөөр болсон. Бид төрийн албан хаагчдын цалинг нэмж чадахгүй байгаа. Нэмэх ганц арга нь ажлын үр дүнгийн урамшуулал болоод байна л даа. Мөн тэтгэврийг 133 тэрбум төгрөгөөр нэмж байна. Малчдын тэтгэвэрт гарах насыг таван жилээр наашлуулсан хууль ирэх жилээс хэрэгжинэ. Ирэх хоёр жил 90 цэцэрлэг, 59 сургуулийн хөрөнгө

оруулалтын зардлаар орж ирсэн. Мөн эрүүл мэндийн даатгалын санг тусад нь бие даалгахаар болж байна. Ингээд бодохоор 2018 оны төсөв бас ч гэж бололцооны болсон гэж үзэж байна.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗАРДУУД НЭМЭГДСЭН БАЙСАН. НЭГ ЁСОНДОО ЗАРЛАГАА БАГАСГАЖ ЧАДААГҮЙ ТӨСӨВ БОЛСОН ГЭХ ШҮҮМЖЛЭЛ БАЙНА Л ДАА?

Зарим нэг хөрөнгө оруулалтын зардлууд нэмэгдсэн. 2016, 2017 оны төсвийн тодотголд бид шинэ хөрөнгө оруулалт тавьж ерөөсөө чадаагүй. Дандаа он дамжсан хөрөнгө оруулалтуудаа дуусгах тал дээр анхаарч байсан. Харин 2018 онд 1.9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт орж ирсэн. Үүний 700 орчим тэрбум төгрөг нь шинэ объект байгаа. Шинэ сургууль, цэцэрлэг, соёлын төв. Энэ бол суурь эдийн засагт дэмжлэг өгч чадна гэж үзэж байна. Мөн төсвийн орлогыг 700 орчим тэрбум төгрөгөөр нэмж оруулж ирсэн. Зарлага харин ч багасгасан шүү. Гэхдээ 400 орчим тэрбум төгрөгөөр зарлага нэмэгдсэн. Энэ дотор хөрөнгө оруулалтын шинж чанартай зүйл байгаа, урсгал төсвүүд ч бий. Мэдээж төсөв сайн болсон гэж хэлэхгүй. Цаашид зарлагаа бууруулах, төсвийн сахилга батаа сайжруулах шаардлага зайлшгүй бий.

ТӨСВИЙН САХИЛГА БАТЫГ САЙЖРУУЛАХ ТАЛ ДЭЭР ЯМАР АРГА ХЭМЖЭЭ АВСАН БЭ?

Төсөвтэй хамт орж ирсэн хуулиуд дээр төсвийн сахилга батыг сайжруулахтай холбоотой хууль бий. Үүнд УИХ-ын гишүүд, нам эвслийн бүлэг, Ерөнхийлөгч, аудитын байгууллага гэсэн дөрвөн субъектыг хариуцлагажуулсан заалт оруулсан. “Та зардал нэмэх гэж байгаа бол хаанаас нь танах вэ гэдгээ тодорхой болго. Эсвэл энэ зардлыг нэмэхийг тулд орлогоо ингэж нэмнэ” гэдгээ тэнцвэржүүлэх ёстой. Түүнээс биш дураараа сургууль, цэцэрлэгийн төсөв тавиад байж болохгүй болсон. Төсвийн хуулийг боловсруулах Ажлын хэсэг УИХ-ын даргын захирамжаар байгуулсан. ОУВС-тай тохирсон хөтөлбөрийн хүрээнд зарлага гаргахын тулд орлого нэмэгдүүлдэг байдлыг больсон. Өмнө нь нүүрснээс олох орлогоо тэдээр нэмчихье, тэр мөнгөөрөө энэ хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэе гэдэг байсан. Энэ байдлыг ОУВС-гаас хорьсон. Тэгэхээр бид өөр зарлагаас хасах л эрх олдож байна гэсэн үг. Тиймээс бид Ажлын хэсгийн хүрээнд нийт 125 орчим тэрбум төгрөгийн өөр зардлуудаас танасан.

ТОЙРОГ РУУ ЧИГЛЭСЭН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТУУД ДАНДАА ЗАСГИЙН ГАЗРЫН САЙД, ЭСВЭЛ ТӨСВИЙН ХУУЛИЙГ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН ГИШҮҮДИЙН СОНГОГДСОН ГАЗАРТ БАЙНА ГЭСЭН ШҮҮМЖЛЭЛ БАЙГААД БАЙНА?

Тийм зүйл байхгүй. Жишээлбэл, би Ажлын хэсгийг ахалсан хүн. Гэтэл манай тойрогт нэг ч ажил тавиагүй. Би өөрөө Ажлын хэсэгт орчихоод өөрийнхөө тойрогт хөрөнгө оруулалт суулгуулаад байвал ёс зүйгүй, хариуцлагагүй болно шүү дээ. Тэгвэл цаашид төсвийн Ажлын

хэсэгт орох гээд энэ гишүүд чинь уралдаж гүйнэ шүү дээ.

ТӨСВИЙН ОРЛОГЫГ ХЭР БОДИТОЙ ТӨСӨӨЛӨВ. ЭНЭ ТАЛААР НЭЛЭЭД МАРГААН ГАРЧ БАЙСАН?

Дажгүй боломжийн түвшинд төлөвлөсөн. 2018 онд шинэ татвар нэмэгдээгүй. Гэтэл өмнөх оноос, тэр дундаа бидний хийсэн хоёрдугаар тодотголын орлогоос 700 орчим тэрбум төгрөг илүү байгаа юм. Тиймээс татварын төрөл, хувь нэмжээ нэмэгдээгүй байхад орлогыг энэ хэмжээнд нэмэгдүүлнэ гээд тун дажгүй төсөөлжээ. Хэрэгжүүлэх явцад санаа зовох зүйлүүд бий. Жишээлбэл, нүүрснээс орох орлого. Яг одоо бол экспорт эрс багассан байгаа. Эхний долоон сарын байдлаар Монгол Улс 20 орчим сая тонн нүүрс гаргаж чадсан бол сүүлийн хэдэн сарын хугацаанд сард хоёр сая тонноос илүү экспортолж чадахгүй байна. Эндээс эрсдэл үүсч болзошгүй байгаа.

45 ХОНОГ ХЭЛЭЛЦЭГ ТӨСВИЙГ БОГИНО ХУГАЦААНД ХЭЛЭЛЦЭЭ. ЗАСГИЙН ГАЗАР ИХ ЧАМБАЙ ТӨСӨЛ ӨРГӨН БАРЬСАН УУ, ЭСВЭЛ АЖЛЫН ХЭСЭГ ШАХАЖ СУУВ УУ?

Бид сайн шахсан гэж хэлж чадахгүй. Мэргэжлийн хүмүүс нарийн үзвэл хэлэх зүйл бий л байх. Бид нэг буруу зуршилтай болчихсон байгаа нь асар өндөр зардалтайгаар төсвөө баталдаг болж. 2018 оны төсвийн долоо орчим их наяд нь зарлага байна шүү дээ. Цаашид энэ зарлагаа бууруулахгүй бол хоёр жилийн дараагаас төсөв ачааллаа даахгүйд хүрнэ. Төрийн албан хаагчдын тоо маш их болсон. Олон шат дамжлагатай, байгууллагууд бий болчихлоо. Энэ талаар Засгийн газар судалж байгаа юм билээ.

ТӨСВИЙН РЕФОРМ ХИЙХ ЦАГ БОЛСОН

Б.БАТТӨМӨР
УИХ-ын гишүүн

ИРЭХ ОНЫ ТӨСӨВ ХЭР БОДИТОЙ БОЛСОН БЭ?

Ирэх жилийн төсөв 7.2 их наяд төгрөгийн орлоготой, 9.6 их наядын зарлагатай. Төсвийн алдагдал дотоодын нийт бүтээгдэхүүний найман хувьтай тэнцэж байгаа. Алдагдал их байгаа гэсэн үг. Монгол Улсын төсөв их хялбархан. Ирэх жилийн хувьд 6.2 их наяд төгрөг нь татвараар, үлдсэн нэг их наяд нь татварын бус орлогоор төвлөрнө. Зарлагын 1.7 их наяд нь цалинд, 1.8 их наяд нь тэтгэвэр тэтгэмжид, 1.1 их наяд нь зээлийн үйлчилгээний төлбөрт, 625 тэрбум төгрөг нь хөрөнгө оруулалт, үлдэж байгаа хоёр их наяд нь урсгал зардал. Ийм л жижигхэн төсөв. Гэтэл хэлэлцэн батлахдаа хугацаа их алдаж байна. Ер нь цаашдаа төсвийн орлогыг нэмэгдүүлж, зарлагыг бууруулж төсвийн реформ хийх хэрэгтэй.

ӨМНӨХ ЖИЛҮҮДТЭЙ ХАРЬЦУУЛАХАД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗАРДАЛ БАГА БАЙГАА НЬ ОУВС-ТАЙ ХАМТРАН ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГААТАЙ ХОЛБООТОЙ ЮУ. ӨМНӨ НЬ ГИШҮҮД ТОЙРОГТОО БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ ХИЙХИЙН ТУЛД МАШ ИХ САНАЛ ГАРГАЖ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗАРДЛЫГ НЭМДЭГ БАЙСАН?

Ингэж ойлгож болно. Яагаад гэвэл, гишүүд хөрөнгө оруулалтын зардлыг хүссэн хэмжээгээрээ нэмэхийг ОУВС зөвшөөрөхгүй шүү дээ. Ер нь цаашдаа ОУВС ингэж хязгаар тавиагүй байсан ч Засгийн газрын оруулж ирсэн төсвийн төслийг УИХ дээр өөрчилдгийг зогсоох хэрэгтэй. Товчхондоо төсвийн сахилга батыг сайжруулна гэсэн үг. Энэ жилийн гол зорилго нь гурван ээлжээр хичээллэж байгаа сургуулиудыг хоёр ээлжтэй болгох. Тэгэхээр хөрөнгө оруулалтын зардлын дийлэнх хэсэг нь үүнд зарцуулагдана. Ер

нь цаашлаад 2020 он гэхэд бүх хүүхдийг цэцэрлэгт хамруулах зорилттой байгаа. Тиймээс ирэх онд болон 2020 он хүртэл Монгол Улсын хэмжээнд нэлээд олон сургууль, цэцэрлэг баригдана.

ӨМЧ ХУВЬЧЛАЛААС ХЭДЭН ТӨГРӨГ ОРЖ ИРНЭ ГЭЖ ТӨЛӨВЛӨСӨН БЭ. 2017 ОНЫ ТӨСӨВТ ТӨРИЙН БАНКИЙГ ХУВЬЧЛАХААР ТУСТАЖ БАЙСАН. ГЭВЧ ХУВЬЧИЛЖ ЧАДСАНГҮЙ. ИРЭХ ОНД ХУВЬЧЛАХ БҮРЭН БОЛОМЖТОЙ ГЭЖ ҮЗЭЖ БАЙГАА ЮМ УУ?

Өмч хувьчлалаас 100 орчим тэрбум төгрөг орж ирнэ гэж төлөвлөсөн. Үүнээс 75 тэрбум төгрөг нь Төрийн банкны хувьчлалаас орж ирэх ёстой. Үлдсэн нь жижиг объектуудын хувьчлалаас орж ирнэ. Би хувьдаа Төрийн банкныг 100 хувь хувьчилж болохгүй гэж боддог. Төрийн банк хувьцаа гаргах замаар тодорхой хэсгээ хувьчилж болно. Тодорхой хэсэг нь төрд байх ёстой. Үүний давуу тал их. Төрийн эзэмшлийн банкаараа дамжуулж ипотекийн зээлээ олгох хэрэгтэй. Гадаадаас бага хүүтэй, урт хугацаатай зээл аваад ипотекийн зээлийг найм биш зургаан хувийн хүүтэй болгож болно. Ипотекийн зээлийг төрийн эзэмшлийн банкаараа олгохын давуу тал нь энэ шүү дээ. Мөн жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих зээлийг төрийн эзэмшлийн банкаараа дамжуулан хүү багатай олгодог байх нь зүйтэй. Тийм учраас Төрийн банкны хувьчлал дээр болгоомжтой хандах хэрэгтэй.

ТӨСӨВТ ҮР ДҮН БАГАТАЙ ЗАРЛАГА ИХ БАГТСАН ГЭСЭН МЭДЭЭЛЭЛ БИЙ. ТУХАЙЛБАЛ, УИХ-ЫН ТАМГЫН ГАЗАРТ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ АВАХАД 800 САЯ, ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ӨРӨӨГ ТОХИЖУУЛАХАД 500 САЯ ГЭХ МЭТ ЗАРДАЛ НЬ АНХААРАЛ ТАТАЖ БАЙНА.

ЭНЭ ТАЛААР ЮУ ХЭЛЭХ ВЭ?

Оновчгүй зардал их бий. Мөн хөрөнгө оруулалтын зардлын зөрүү их ажиглагдсан. Улаанбаатар хот болон орон нутагт барьж байгаа 150 хүүхдийн ортой цэцэрлэг гэхэд л нэг тэрбум төгрөгийн зөрүүтэй байх жишээтэй. Баян-Өлгий аймагт барьж байгаа 10 ортой эмнэлгийг 120 сая, Төв аймгийн Заамар суманд барьж байгаа 10 ортой эмнэлгийн барилга 1.5 тэрбум төгрөг байна. Тиймээс төсвийн хяналтыг сайжруулах зайлшгүй шаардлага бий.

ТӨСӨВ БАТЛАГДАХЫН ӨМНӨ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛӨӨ ШИЛЖҮҮЛЭХЭД 10-30 ХУВИЙН ТАТВАР ТӨЛДӨГ БОЛОХ НЬ ГЭСЭН ШҮҮМЖЛЭЛ ГАРСАН. ЭНЭ НЬ ЯМАР УЧИРТАЙ ЮМ БЭ. УГ НЬ АНХ ТӨСӨВ ӨРГӨН БАРИХАД ТАТВАР НЭМЭХ САНАЛ НЭГ Ч БАЙХГҮЙ ГЭЖ БАЙСАН?

ОУВС-тай тохирсон ёсоор архи, тамхины онцгой албан татварыг нэмсэн. Энэ бол дэлхийн хандлага. Иргэдийн хувьд өндөр орлоготой бол өндөр татвар төлнө. Мөн нийгмийн даатгалын шимтгэлийн хэмжээ нэмэгдэж байгаа. Энэ бол өнгөрсөн хавар Ерөнхийлөгчийн сонгуулийн өмнө батлагдсан. ОУВС-гийн шаардлагын дагуу нэмэгдсэн эдгээр татвар зохицуулалт ирэх оны нэгдүгээр сарын 1-нээс

хэрэгжиж эхэлнэ. Харин сая батлагдсан төсөвтэй хамт ямар нэгэн татвар нэмэх шийдвэр гаргаагүй. "Засгийн газар тусгай зөвшөөрлийн эрх шилжүүлэхэд 10-30 хувийн татвартай болгох санал оруулж ирсэн. Түүнийг нь төсвийн ажлын хэсэг, Төсвийн байнгын хороо дэмжсэн" гээд байх юм. Энэ бол ташаа ойлголт. Тийм зүйл огт байхгүй. Угаасаа газар, болон ашигт малтмалын лиценз шилжүүлэх, эсвэл компаниа зарах тохиолдолд 30 хувийн татвар төлөх хуультай. Үүнийг харин ч бууруулж байгаа юм. Иргэн хувийн газар, тусгай зөвшөөрөл бүхий үл хөдлөх хөрөнгөө зарахаар бол 10 хувийн татвар төлнө. Харин аж ахуйн нэгж газар болон, лицензээ зарахаар бол 30 хувийн татвар төлдөг хэвээрээ. Хууль бус газрын наймааг таслан зогсоох зорилгоор ийм зохицуулалт хийж байгаа юм. 30 хувийн татварыг нь 10 хувь болгочихвол зугтахгүйгээр төлнө гэж тооцсон юм билээ. Энэ зохицуулалт төсөвтэй хамт батлагдсантай холбоотойгоор Засгийн газар Татварын тухай хуульд өөрчлөлт оруулах төсөл УИХ-д оруулж ирэх ёстой. Үүнийг Засгийн газарт анхааруулсан. Сангийн сайд ч ойрын хугацаанд төслөө оруулж ирнэ гэднээ хэлсэн. Ингэхгүй бол аж ахуйн нэгжүүдүүд 30 хувийн татвараас зугтаж хувь хүн рүү шилжих эрсдэлтэй.

МОНГОЛД КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА БА ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТУУД СУДАЛГААНЫ ТОВЧЛОЛ

Монголын Компанийн Засаглалын Хөгжлийн Төв (CGDC)

Энэхүү судалгааг Конрад Аденауэрын Сангийн өмнөөс Монголын Компанийн Засаглалын Хөгжлийн Төв (CGDC) хийсэн юм. Судалгаа нь Монголд Компанийн Нийгмийн Хариуцлага (КНХ)/хариуцлагатай/тогтвортой бизнесийн хөгжлийн төлөв байдлын одоогийн түвшнийг тодорхойлохоос гадна Тогтвортой Хөгжлийн Зорилтуудад (ТХЗ, мөн Дэлхийн Зорилтууд гэж нэрлэдэг) Монголын компаниудын оруулах боломжтой ирээдүйн хувь нэмэр, оролцоог тодорхойлох зорилготой юм. Судалгаа нь бизнесийн төлөв байдал болон ирээдүйд төвлөрсөн бөгөөд ингэхдээ тогтвортой амьжиргааны тухай үзэл санааг түгээхэд чухал үүрэг бүхий хамаарагч талуудыг онцгойлон авч үзсэн юм. Үр дүнд нь улс төр, төрийн засаг захиргаа, бизнесүүд болон нийгмийн байгууллагуудад илүү мэдлэг мэдээлэл түгэх, тэдгээр хоорондоо тогтвортой хөгжил, тэр дундаа тогтвортой бизнесийн ирээдүй, боломж ба бэрхшээлүүдийг шийдэхэд хамтран ажиллах, үр дүнтэй мэдээлэл солилцоход ихээхэн тустай байх юм. Мөн энэхүү судалгаа нь хариуцлагатай нэгдмэл сонирхол, үүрэг хариуцлагууд дээр суурилсан тогтвортой нийгэм ба амьжиргааны сайн сайхан байдлыг бий болгож чадах эдийн засгийн системийн үр өгөөж, ач холбогдлыг хамаарагч талууд илүү сайн ойлгож хүлээж авахад тус нэмэртэй гэж үзэж байна.

НЭГ. СУДАЛГААНААС ХАРАГДСАН ҮР ДҮНГҮҮД

- Дэлхий нийтээр хариуцлагатай бизнес компанид ямар үр өгөөж авчирдаг болон КНХ нь “үр дүнгээ” өгдөг болохыг хэзээ хэзээнээс илүүтэйгээр хүлээн зөвшөөрдөг болоод байна. Илүү олон компаниуд өөрийн улсдаа болон дэлхий нийтийн хэмжээнд ТХЗ-уудыг хангахад хувь нэмрээ оруулахыг хүсэх болсон боловч ТХЗ-уудын өдөр тутмын бизнест үзүүлэх нөлөөллүүд дээр чиглэл, зөвлөмжүүд шаардагдсаар байна. Улс төрийнхэн, олон нийт ба хэрэглэгчдийн зүгээс тэдний зүтгэлийг үнэлэн дэмжих, хөхүүлэн сайшаах нь компаниудын зүгээс идэвх зүтгэлээ гарган хариуцлагатай, тогтвортой бизнесүүдэд илүүтэй хөрөнгө оруулахад чухал үүрэгтэй болж байна. Компани дотор болон түүнээс гадуур харилцаа холбоо бий болгох, харилцан ярилцах болон санал солилцох нь итгэлцлийг бий болгох үндсэн нөхцөл бөгөөд бүгдэд нь харилцан үр өгөөжтэй шийдлүүдийг гаргахад нэн чухал юм.
- Монголд компаниуд КНХ/хариуцлагатай/тогтвортой бизнес гэдэг

нь ерөнхийдөө юу болох, өөрсдийн бизнестэй нь хэрхэн уялдаг болохыг ерөнхий, тойм байдлаар ойлгож байна. Ийм төрлийн арга хэмжээ, ажиллагаануудыг хэрэгжүүлэн удирдах явц хөгжлийнхөө дөнгөж эхний түвшиндээ явж байгаа бөгөөд компанийн төлөөлөгчдийн үзэж буйгаар улс төр, засаг захиргаа, хэрэглэгчид ба олон нийтийн зүгээс санхүүгийн болоод санхүүгийн бус дэмжлэгүүд илүү шаардлагатай байгаа юм. Компаниуд ТХЗ-уудын тухай хязгаарлагдмал ойлголтой байгаа бөгөөд ТХЗ хангахад оролцох шалтгаан, эндээс бий болох өргөн боломжуудыг хүлээн зөвшөөрч

байгаа хэдий ч өөрсдийн зүтгэл, оролцоог бодитоор үнэлүүлэхийг хүсч байна.

- Дэлхий нийтийн хандлагатай харьцуулахад Монголын бизнесүүдийн хувьд бизнес болон улс төрийн хамтын ажиллагаа, харилцан ойлголцол, итгэлцэл бий болгох шаардлага өндөр байгааг хүлээн зөвшөөрч байна. Гэхдээ тогтвортой бизнесийн талбарт голлон оролцогч байх бус харин үүрэг, зорилтуудыг ажилчдынхаатүвшинд хэрэгжүүлэх хэмжээнд оролцох сонирхол Монгол компаниудад ажиглагдаж байна..

ХОЁР. СУДАЛГААНААС ГАРСАН НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Үр дүнгээс харахад компаниуд КНХ ба ТХЗ-уудын бий болгох нэмэлт үнэ цэнүүдийг сайн ойлгож байгаа бөгөөд тэдний олонх нь илүү хариуцлагатай бизнес хийхэд бэлэн байна. Гэхдээ Монголын бизнесийн ертөнц, хууль эрх зүй, улс төрийн орчин, мөн нийт Монголын хүн амын зүгээс хариуцлагатай бизнесийн үйлдүүдийг сайн дэмждэггүй нь компанийг илүү хичээл зүтгэл гаргахад нь хязгаарладаг байна. Тиймээс судалгааг дүгнэвэл Монгол дахь ТХЗ-уудын ирээдүй нь Дэлхийн Зорилтуудаас гарах үр өгөөжийг хүртэж саад бэрхшээлүүдийг шийдэхэд бизнес, төр захиргаа ба

иргэний нийгмийн талуудын хоорондын гүн гүнзгий, ил тод, урт хугацааны хамтын ажиллагаанаас, бас үүнээс дутахгүйгээр ТХЗ-уудыг амжилтын түүх болгоход хувь хамаарагч тал бүрийн оруулах үүрэг хариуцлагаас хүчтэй хамаарахаар байна. Итгэлцэл бүхий хамтарсан яриа хэлцэлүүд Дэлхийн Зорилтуудыг үйл хэрэг болгоход түлхүүр хүчин зүйл болох ба судалгааны дүнгээс харахад ТХЗ-ууд нь өмнөх оролдлогуудаасаа ялгаатай, ирээдүйтэй санаачлага гэж олон компаниуд үзэж байгаа бөгөөд тиймээсхувь нэмрээ оруулахад бэлэн байгаагаа илэрхийлсэн юм.

ГУРАВ. СУДАЛГААГ ҮНДЭСЛЭН ГАРГАСАН ЗӨВЛӨМЖҮҮД

- Бүхэлдээ КНХ/ТХЗ-ууд нь санхүүгийн болон санхүүгийн бус хүчтэй сэдэл урамшуулалыг компаниудад бий болгож байна. Гэхдээ энд онгорхой асуултууд их байгаа, учир нь Дэлхийн Зорилтуудыг улс орны хэмжээнд хэрэгжүүлэхэд тодорхойгүй зүйлс олон байгаа юм. Иймээс компаниуд Зорилтуудыг сайн таньж мэдээд,

тодорхойлсныхоо дараа уялдах зорилт зорилгуудыг дэвшүүлэх хэрэгтэй байгаа бөгөөд мөн хамаарагч талуудтай зохистойгоор харилцах арга замыг олох шаардлагатай байна. Улс төр, бизнес ба иргэний нийгмийнхэн мэдлэг мэдээлэл солилцох, арга барилуудаа хуваалцах, хамтарч ажиллах нь нэн чухал байна.

- Хамаарагч талуудын оролцоо, ялангуяа

компаниуд үйл ажиллагаагаа явуулдаг нийгмийн бүлгүүдийн оролцоо улам ач холбогдолтой болсоор байна.

- Итгэлцлийг бий болгоход харилцаа холбоо, яриа хэлцэл ба манлайлал нь суурь хүчин зүйлүүд болно. Дэлхий нийтийн хандлагыг харахад бизнес болон улс төрд итгэх итгэл буурсаар байгаа тул компаниуд энэ хандлагыг эргүүлэх арга замуудыг эрэлхийлэх ёстой. Үүний нэг чухал алхам бол хамаарагч тал бүр өөрсдийн гүйцэтгэх үүрэг, бусдынхаа боломж хязгаарыг ойлгож мэдсэнээр үүнийхээ дагуу үүрэг хариуцлагуудаа тодорхойлох явдал юм.
- Ажилчин ажилтнууд ирээдүйд илүү

үүрэг гүйцэтгэх бөгөөд компанийн тогтвортой амжилтанд шийдвэрлэх үүрэгтэй оролцоно. Компаниуд шилдэг боловсон хүчинг өөртөө татах, нийт ажилчид, тэр дотроо залуу боловсон хүчний эргэлтийг бууруулахын тулд тэдний оролцоонд хөрөнгө оруулах хэрэгтэй юм.

- Ирээдүйд компанийн бизнесийн үйл ажиллагаанд хэрэглэгчид ба олон нийтийн гүйцэтгэх үүрэг өссөөр байх болно. Үүний зэрэгцээ Хариуцлагатай хэрэглээ ба үйлдвэрлэл (Goal #12) дэлхий нийтийн хэмжээнд хамгийн ахиц дэвшил багатай зорилт байсаар байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Дэлхий нийтийн болон Монголд хийсэн судалгаануудын үр дүнд дараах үндсэн дүгнэлт ба зөвлөмжүүдийг гаргаж болохоор байна. Үүнд:

- Компаниуд, улс төр, иргэний нийгэм ба олон нийт бүхэлдээ КНХ/хариуцлагатай бизнес ба тогтвортой байдал, мөн уялдах үйл ажиллагаануудыг бизнесийн гол хүчин зүйл, элемент гэж үзэх ёстой.
- Хамаарагч талуудын дунд мэдлэг мэдээлэл солилцох, ахиц дэвшил болон саад бэрхшээлүүдийн тухай яриа хэлцлүүдийг тогтмол хийж байх үйл явцыг системтэйгээр зохион байгуулалтанд оруулж үүрэг хариуцлагуудыг тодорхойлох ёстой.
- Компаниуд өөрсдийн боловсон хүчнийг сургаж боловсруулан, эрх мэдлийг олгож илүү хариуцлагатай, тогтвортой бизнесийг хэрэгжүүлэхэд шаардлагатай бизнесийн шийдэл ба арга замуудыг олох, тодорхойлоход тэднийг түлхүү оролцуулж байх ёстой юм. Энэ нь Чанартай боловсролыг дэмжих (Goal #4) зорилт нь Монголд маш чухал гэсэн судалгааны үр дүнтэй шууд уялдаж чадна.

- Компаниуд өөрсдийн ажиллаж буй байгаль орчин ба нийгэмдээ үзүүлж байгаа эерэг болон сөрөг үр дагавар, нөлөөллүүдээ илүү анхаарах хандуулах шаардлагатай байна. Компани өөрийн хариуцлагын гүйцэтгэлээ хэрхэн үнэлж байгаа болон бусад талууд энэ гүйцэтгэлийг хэрхэн үнэлж байгаагийн хооронд зөрүү гарснаар тал талд үл итгэлцэл, сэтгэлд хүрэхгүй байх явдал гарч болохыг ямагт анзаарч байх ёстой юм.
- Компаниуд болон бусад бүх хамаарагч талууд хариуцлагатай зан төлөв ба харилцаа холбоо аль алины хувьд жишиг, үлгэр жишээ болох ёстой. Тэд ямагт, нээлттэйгээр өөрсдийн үүрэг хариуцлагуудаа илэрхийлж бусдын хичээл зүтгэлийг хүлээн зөвшөөрч, үнэлж байснаар олон нийтийн сэтгэхүйг өөрчилж, олон нийтийн зүгээс хамаарагч талуудын зүтгэлийг илүүтэй үнэлэхэд хүргэж чадна.
- Компаниуд зөвхөн чанартай бүтээгдхүүн үйлчилгээг хүргэх замаар хэрэглэгчид ба олон нийттэй итгэлцлийг үүсгээд зогсохгүй ил тод нээлттэй

байж өөрсдийн бизнесийн үйлдэл үйл ажиллагаа, татвар төлөлт зэрэгтээ найдвартай, итгэлтэй байх ёстой юм. Энэ ч компанийн төлөөллүүдээс судалгаанд Хариуцлагатай хэрэглээ ба үйлдвэрлэлийн (Goal #12) зорилт нь компанийн болон улс орны түвшинд хамгийн чухал зорилтуудын нэг гэж үнэлсэнтэй шууд зохилдож байгаа юм.

- Монголын хамаарагч талууд хариуцлагатай ба тогтвортой бизнесийн хэлбэр, хэв загвар, үйлдлүүдийг таньж тодорхойлон, хүлээн зөвшөөрч үнэлэх тал дээр илүү түлхүү ажиллах хэрэгтэй байна. Хичээл зүтгэл бүхий урьд алхаж байгаа компаниудыг урамшуулан сэдэлжүүлж, харин тэдэнд өгсөн

урамшуулал нь нийтэд зөв зүйтэйгээр ойлгогдож үнэлэгдэж байх ёстой.

Эцэст нь судалгаа өгсөн хамаарагч талуудын нэн чухалд үзсэн зүйл бол, компаниуд, улс төрийнхэн ба иргэний нийгмийн бүлгүүд ил тод, тогтмол, зорилтонд чиглэсэн яриа хэлцэл, харилцаа холбоог өрнүүлдэг соёлыг хэвшүүлэх арга замыг олох ёстой. Зөвхөн итгэлцэл дээр суурилсан орчинд нийтлэг ойлголцол ба дэмжлэг туслалцаа бий болох боломжтой. Компаниуд эерэг хандлагыг тогтоож үйл явцыг эхлүүлэхэд хувь нэмрээ оруулахын тулд өөрсдийгөө үйл ажиллагааг тодорхойлогчид, эхлүүлэгчид гэж харах ёстой юм.

Судалгааны ажлыг бүрэн эхээр нь

<http://www.kas.de/mongolei/mn/publications/49856/>–ээс үзэх боломжтой.

ECONOMIC ANALYTICA

УЛС ТӨРИЙН ЭДИЙН ЗАСАГ СУДЛАЛ

Эдийн засгийн шинжлэх ухааны эрдэмтэн судлаач, багш оюутан, мөн эдийн засгийн чиглэлээр бичдэг сэтгүүлч нарыг эрдэм шинжилгээний өгүүлэл, эдийн засгийн өгүүлүүдээ "Economic Analytica – Улс төрийн эдийн засаг судлал" сэтгүүлд хүргүүлж хэвлүүлэхийг урьж байна.

Манай сэтгүүл нь хэвлэгдэх өгүүлүүдээ доорх академик болон техникийн шаардлагыг тавих болно.

ЗОХИОГЧИЙН ҮҮРЭГ

МЭДЭЭЛЛИЙН СТАНДАРТ

- Зохиогч өөрийн судалгааны үр дүнг танилцуулахдаа гүйцэтгэсэн ажлаа бүрэн дүүрэн тайлагнаж, судалгааны ач холбогдлыг нь бодитойгоор илтгэнэ.
- Судалгааны тоон мэдээлэл бодитой, үнэн зөв байх шаардлагатай.
- Өгүүлэлд тодорхой мэдээлэл болон эшлэлийг хангалттай оруулсан байна.
- Хууран мэхэлсэн болон санаатайгаар алдаатай бичлэгийг ёс зүйгүй үйлдэл гэж үзэн хүлээн зөвшөөрөхгүй.

БҮТЭЭЛ

Зохиогчид өөрийн судалгааны эх бүтээлийг ирүүлднэ. Харин зохиогчид бусдын бүтээлээс болон бусдын үг ашигласан тохиолдолд заавал эх сурвалжийг эш татсан байх шаардлагатай.

ОЛОН УДААГИЙН БУЮУ ДАВХАЦСАН НИЙТЛЭЛ

Зохиогч нэг судалгааны ажлыг нэгээс илүү сэтгүүл эсхүл анхдагч хэвлэлд хэвлүүлэх ёсгүй. Адилхан эх бичмэлийг нэгээс илүү сэтгүүлд хэвлүүлэхээр өгөх нь нийтлэлийн ёс зүйгүй үйлдэл юм.

ЭХ СУРВАЛЖАА НОТЛОХ

Зохиогч бусдын бүтээлийг хүлээн зөвшөөрч, тухайн судалгааны агуулгад нөлөөлсөн бүтээлийг нэр зааж эшлэл татсан байх шаардлагатай.

ЭХ БИЧМЭЛИЙН ЗОХИОГЧИЙН ЭРХ

Тухайн судалгааны бүтээлийн концепц гол санаа, загвар, гүйцэтгэл, аль эсхүл судалгааны дүгнэлт тайлбар зэрэгт зарчмын хувь нэмэр оруулсан хүмүүсийг зохиогчид хамааруулна. Харин судалгаа хийх явцад тодорхой ажилд оролцсон бол талархлын хэсэгт тэмдэглэнэ.

ТОДРУУЛГА БА СОНИРХЛЫН ЗӨРЧИЛ

Бүх зохиогчид эх бичмэлдээ аливаа санхүүгийн эсхүл бусад үндэслэл бүхий сонирхлын зөрчил байвал тодруулга хийх хэрэгтэй. Төслийн санхүүгийн дэмжлэгийн бүх эх сурвалжийн талаар тодруулга хийсэн байна.

НИЙТЛЭГДСЭН БҮТЭЭЛ ДЭХ ЗАРЧМЫН АЛДААНУУД

Хэрэв нийтлэгдсэн бүтээлд нь утгын алдаа эсхүл доголдол гарсан бол зохиогч сэтгүүлийн редактор эсхүл хэвлэн нийтлэгчид мэдэгдэх ба бүтээлийг нийтлэхийг цуцлах аль эсхүл хэвлэлийн алдааг засах дээр хамтран ажиллах бүрэн эрхтэй.

ӨГҮҮЛЛИЙН БҮТЭЦ




- Эх бичмэлийг WORD DOC, PDF хэлбэрээр өгнө
- Хэрэв таны эх бичмэл тусгай тэмдэгт, томъёо зэрэг агуулсан бол PDF хэлбэрээр давхар явуулах хэрэгтэй.
- Сэдвээ Монгол хэл дээр бичнэ
- Дараах бүтцийг ашиглана
 - Танилцуулга /сонголтоор/
 - Дэд хэсэг /хүснэгт, график, тайлбар агуулсан.../
 - Хавсралт /хэрэв байгаа бол/
 - Товчилсон үгийн тайлбар
 - Ашигласан материал – номзүй
 - График, хүснэгтүүдийг текстэн дотор биш тусад нь файл үүсгэн хийх.

ОНЦЛОН ТЭМДЭГЛЭСЭН ТЕКСТ, ГАРЧИГ, БОЛОН ГАДААД НЭР ТОМЬЁОНУУД

- Хэрэв текстийг онцлон тэмдэглэхийг хүсвэл доогуур зурааснаас илүүтэйгээр италик-ийг ашиглах. Текстийг өнгөөр тодруулах нь тийм ч зохистой биш.
- Гадаад нэр томьёонуудыг онцлохын тулд доогуур зураас биш италик-ийг ашиглах
- Ном, киноны нэрийг онцлохын тулд доогуур зураас биш италик-ийг ашиглах

ФОРМАТ

- Зөвхөн Юникод фонт ашиглана.
- Гарчгууд үндсэн хэсгээс ялгаатай бичигдэх
 - Гарчгууд дээрээс доош /томоос жижигрүү/ шаталсан байх
- Хөл тайлбарууд бүтээлийн төгсгөлд биш тухай тухайн хуудасны доод талд тусгагдсан байх.
 - Маш урт хөл тайлбарыг хавсралт хэсэгт оруулбал илүү дээр.
- Хүснэгт, графикуудыг задгай болон зурган форматаар хавсаргасан байх.

 Монгол Улс, Улаанбаатар хот,
Төв шуудан – 558 хайрцаг,
“Амаржаргал Сан” ТББ
 (976) 9909-4435
 info@amarjargal.org



ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГААНЫ ХҮРЭЭЛЭН

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2017 оны 7 сарын 5-нд хуралдсан СЭЗИС-ийн Удирдах зөвлөлийн хурлаар эрдэм шинжилгээ, судалгааны хүрээлэн байгуулах шийдвэрийн дагуу үүсгэн байгуулагдаж, үйл ажиллагаагаа эхлүүлээд байна. СЭЗИС-ийн мэргэжилтэй ажилтан бэлтгэх, бакалавр, магистр, докторын бүхий л хөтөлбөрт суралцаж байгаа оюутнууд практик ажлын дөртэй болж бизнесийн зөвлөгөө өгөх, судалгаа шинжилгээ хийх үр чадвар эзэмших бололцоо нөхцөлийг бүрдүүлэн хангах болно.

ЗОРИЛГО

Монгол улсын нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн судалгаа шинжилгээ, бизнесийн зөвлөгөө, сургалтын чанартай бүтээгдэхүүн бий болгож нийтийн хүртээл болгох, үр нөлөөтэй судалгааны байгууллага болж төлөвших.

ЗОРИЛТ

- Монгол улсын нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийн хэрэгцээ шаардлагад нийцсэн макро, микро түвшний тэргүүлэх чиглэлийн судалгааг глобал эдийн засгийн чиг хандлага, монгол ахуй, монгол хүний онцлог, төрийн бодлоготой холбон судалдаг нэр хүндтэй судалгааны институт болж төлөвших;
- Эрдэм шинжилгээ, судалгааны орчин үеийн арга, аргачлал, мэдээлэл харилцааны технологи, судалгаа шинжилгээний сүүлийн үеийн ололт амжилтыг эзэмшин судалгаа шинжилгээний үйл ажиллагаанд хэрэглэж, хэвшүүлэх, СЭЗИС-ийн бүх оюутан, багш нарын хүртээл болгох;
- Судалгаа шинжилгээний лаборатори, техник хэрэгсэл, програм хангамж, дадлагын газар, бизнес инкубатор зэрэг шаардлагатай материаллаг баазийг бүрдүүлэн судалгаа шинжилгээ, бизнесийн зөвлөгөө, сургалтыг зохион байгуулахад үр дүнтэй ашиглах;
- Бүтэц, зохион байгуулалт, материаллаг бааз, санхүүгийн хувьд бэхжиж, цаашдаа бие даан үйл ажиллагаагаа явуулах нөхцөлийг бүрдүүлэх
- Гадаад, дотоодын ижил төстэй судалгааны байгууллагуудтай үр ашигтай хамтын ажиллагааны харилцаа тогтоож, харилцан туршлага судлах, олон улсын шилдэг туршлагаас суралцах зэргээр судалгаа шинжилгээ, бизнесийн зөвлөгөө, сургалтын чанар чансааг олон улсын түвшинд хүргэх зэрэг болно.

ЧИГ ҮҮРЭГ

- СЭЗИС-ийн Эрдэм шинжилгээ судалгааны тэргүүлэх чиглэлүүдийн дагуу судалгаа шинжилгээний ажил гүйцэтгэх
- Төр, хувийн хэвшил, иргэний байгууллагуудтай хамтран ажиллаж тэдний захиалга, санхүүжилтээр судалгаа шинжилгээний ажил гүйцэтгэх, СЭЗИС-ийн төсөвт эрдэм шинжилгээ судалгаанаас орох орлогыг нэмэгдүүлэх
- СЭЗИС-ийн захиалга, санхүүжилтээр хийгдэх судалгааны ажлуудын хэрэгцээг тодорхойлж, зохион байгуулж, хугацаанд нь гүйцэтгэж хүлээлгэн өгөх
- Бизнесийн зөвлөгөө, богино хугацааны сургалтын бодит хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн боловсруулж, бизнес эрхлэгчдэд санал болгох, гүйцэтгэх, тайлагнах
- Гүйцэтгэсэн судалгааны ажил, бизнесийн зөвлөгөө, сургалтын үр дүнг нийтийн хүртээл болгох, судалгааны бүтээлийн санг баяжуулах, эрдэм шинжилгээний бүтээлийн үзэсгэлэн, хурал, семинар зохион байгуулах зэрэг арга хэмжээ авах
- Судалгаа шинжилгээний арга зүйг боловсронгуй болгон судалгааны анхдагч мэдээллийн баазыг бий болгож баяжуулах
- СЭЗИС-д ажиллаж байгаа доктор, профессор, дэд профессоруудтай нягт хамтран ажиллаж, тэдний хүчин чармайлтаар судалгаа, бизнесийн зөвлөгөөний захиалга авах, гүйцэтгэх, хийсэн ажилд нь үнэлэлт дүгнэлт өгөх, урамшуулах арга хэмжээ авах

